

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН БАЙГУУЛАЛ

НАМЖИЛЧОЙЖИЛЫН АЛТАНТӨГС
МУИС-ийн Түүхийн тэнхимийн дэд профессор

ПҮРЭВСҮРЭНГИЙН ДЭЛГЭРЖАРГАЛ¹
МУИС-ийн Түүхийн тэнхимийн профессор

Хураангуй: Монголын уламжлалт эдийн засгийн байгуулал нь мал өмчлөгч өрхөөс үүссэн мал аж ахуйн хот, малаас үүссэн сүрэг, газар ашиглалтаас үүссэн нутаг, товчоор хот-сүрэг-нутаг гэсэн зохион байгуулалтай байв. Мал аж ахуйн хот ба сүрэг нь байнгын суурин цэг өвөлжөөгөөр дамжуулан нутагтай уягдаж, иймээс Монголын уламжлалт эдийн засгийн байгуулал тус бүр нэг өвөлжөө эзэмшсэн мал аж ахуйн хотуудаас бүрэлдэн тогтож, тэрхүү мал аж ахуйн хотууд нь язгууртан, баян, дундаж, ядуу малчин зэрэг янз бүрийн өрхүүдээс бүрдэж байжээ. Энэ эдийн засгийн байгууллын үндэс суурьт бүх газрыг өмчлөгч, Монголын газар нутаг, гол ус, уул нурууд, газрын хэвлий, ой мод, усгүй цөл, зэлүүд газрын дээд эзэн – хаан, түүнийг төлөөлөн, түүний соёрхлын үндсэн дээр газрыг эзэмшигч засаг захиргааны нэгжүүд оршин байв. Монголын уламжлалт эдийн засгийн үндэс нь Евразийн нүүдлийн мал аж ахуйгаас онцлог ялгаатай, хүйтний улирлын нутгийг үйлдвэрлэлийн нэгжүүдэд үнэгүй, хугацаагүйгээр эзэмшүүлдэг, төрийн өмчийн газар дээр суурилсан *нутаг эзэмших харилцаа* байв.

Түлхүүр үг: Мал аж ахуйн хот, нутаг, сүрэг, өвөлжөө

Keywords: Pastoral Camp, Nutag, Herd, Winter Settlement

УДИРТГАЛ

Монголын уламжлалт нийгэм Евразийн хээр талын бусад нийгмүүдийн адил мал аж ахуй дээр тулгуурлан оршдог боловч тэднээс ялгаатай нь Монгол нутагт Хүннү, Хөх Түрэг, Их Монгол улс зэрэг томоохон, нэгдмэл эзэнт улсууд удаа дараа хүчирхэгжин мандаж байв. Иймээс тэдгээр хээр талын эзэнт улсууд

¹ Холбоо баригч зохиогч

гололтлон мандаж байсан Монгол газар, түүн дээр оршин байсан уламжлалт нийгмийн байгууллын түүх судлаачдын анхаарлыг ихээхэн татдаг.

Монголын хээр тал гэдэгт өрнөдөд Алтайн нуруунаас дорнодод Хянганы нуруу, умардад Байгал нуураас өмнөдөд Хатан гол хүртэл удам бүс нутгийг ойлгоно. Монголын тал нутгийн дотор Хангай, Хэнтийн нурууд, Орхон, Туул, Онон, Хэрлэн дөрвөн голын савыг хамрах Төв Монголын ойт хээрийн бүсэд хүн, малын ихэнх нь төвлөрөн амьдарч иржээ. Энэ бүс байгаль, цаг уурын эрс тэс уур амьсгалтай, хүн, малын томоохон төвлөрөл үүсгэдэг бөгөөд Евразийн шинжтэй улс төрийн томоохон үйл явдлууд энэ бүс нутгаас эхээ аван өрнөж байв. Иймээс бид Монголын уламжлалт нийгмийн байгууллыг эдийн засгийн үүднээс авч үзэхдээ Хангай, Хэнтийн уулс, Орхон, Туул, Онон, Хэрлэн голын сав газруудын байгаль, газарзүйн нөхцөлд тулгуурлах ба өөрийн гэсэн ялгаатай онцлог бүхий Алтайн бүс нутаг, мөн Өвөр Монголын бүс нутгийн уламжлалт нийгэм дэх газар зүйн нөхцлийг үүнд хамруулахгүй юм.

Монголын уламжлалт эдийн засаг нь дэлхийн бусад ихэнх улсын адил хөдөө аж ахуй болон үеэс үед өвлөгдөж ирсэн уламжлалт мэдлэг ухаан, технологи дээр суурилж байв. Монголын уламжлалт эдийн засаг гэж бэлчээрийн мал аж ахуй, түүнд суурилсан ан агнуур, нутгийн тариалан, дотоод ба гадаад худалдаа, нэгдсэн төрийн татвар санхүү зэргийг ойлгоно. Мал аж ахуйд суурилсан энэхүү уламжлалт эдийн засгийн байгуулалт Монгол газарт бэлчээрийн мал аж ахуй дагнан эрхлэх болсон хөгжингүй хүрлийн үе буюу НТӨ 15-р зуунаас бүрэлдэн бий болж, 20-р зууны дунд үе хүртэл үргэлжлэн оршжээ.

Монголын уламжлалт эдийн засгийн байгууллын үндэс гэдэгт мал аж ахуй дахь өмчийн харилцаа, үйлдвэрлэл явуулах хөдөлмөр зохион байгуулалт, нүүдлийн технологи, эдгээрийн үндэс болсон газрын харилцааг хамруулан үзэх болно. Уламжлалт эдийн засгийн үндсэн байгууллыг оновчтой тайлбарласнаар бид өнөөгийн Монгол Улсын эдийн засгийн байгуулалд хүчтэй нөлөөлсөөр буй түүхэн хүчин зүйлсийг танин мэдэх онолын суурь мэдлэгийг олж авах боломжтой.

Монголын уламжлалт эдийн засгийн байгууллыг судлаачид нүүдлийн мал аж ахуй хэмээн үзэж, түүний үндсийг номадизмын үүднээс нүүдэл анхдагч хэмээн тайлбарлаж ирсэн ба тэдгээрээс харьцангуй боловсронгуй, тодорхой үзэл баримтлал дэвшүүлсэн нийгмийн хувьслын онолын марксист чиглэл болон сүүлийн үеийн онолын шинэ чиг хандлага болох “аппанаж коммунити”-г авч үзье.

Нийгмийн хувьслын онолын марксист чиглэл: нүүдлийн феодализм. Монголын уламжлалт мал аж ахуйн эдийн засгийн байгууллыг марксистын үүднээс анхлан Б.Я.Владимирцов тайлбарлаж, нүүдлийн феодализмын үзэл баримтлалыг дэвшүүлсэн². Нүүдлийн феодализмын онолд бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн үндэс нь газар ба малыг өмчлөх байдал хэмээн үздэг.

Б.Я.Владимирцовын үзэл баримтлалд тулгуурлан Ш.Нацагдорж нүүдэлчдийн нийгэмд газар ба малын гүйцэтгэх үүргийг тусгайлан судлаад “Газар нь малын

² Владимирцов, Б.Я. *Общественный строй Монголов, Монгольский кочевой феодализм*, Ленинград, Издательство Академии Наук СССР, 1934.

оршин тогтнохын үндэс, үйлдвэрлэлийн гол хэрэгсэл” хэмээн үзэхдээ “газрын нэгэн адил эдийн засгийн роль гүйцэтгэсэн малын эзлэх байр суурийг хэт бууруулдаг үзэлтэй санал нийлдэггүй” болохоо илэрхийлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, нүүдлийн мал аж ахуйд газар болон мал хоёр адилхан чухал үүрэгтэй хэмээн үзсэн ажээ. Ш.Нацагдорж “Монголд газар нь улсын өмч байсан нь феодалын газрын өмчийн нэгэн хэлбэр боловч газрыг улс өмчлөхийн зэрэгцээ феодалууд хувьдаа өмлөх ёс бас байжээ”³ хэмээн үздэг. Тэрээр “Феодалын газрын өмчийн тухай хэлэхдээ нүүдэлчид газрыг эдлэн ашиглах нь хүйн шинжтэй байсныг цохон тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь хүйн үеийн ёс журмын үлдэц арвин байснаас болсон төдийгүй нүүдэлчдийн уул эрхлэн амьдрах аж ахуйн онцлогоос ихээхэн шалтгаалсан байна” хэмээжээ.

Эдгээр үзэл баримтлалд үндэслэн С. Цолмон “Хэрэв суурьшил оронд тариачдыг ноогдол буюу түрээсний өчүүхэн хэсэг газарт хааш ч хөдөлгөлгүй бэхэлдэг бол нүүдлийн аж ахуйт оронд газрыг Европын орнууд шиг хэрчээс болгон хуваадаггүй тул нүүдэлчин малчныг гагцхүү ноёдынх нь нэр дээр данслан бүртгэж ноёны хувь эзэмшлийн газарт нийтэд нь барьж байдаг ажээ. Чухамхүү үүнд нүүдэлчдийг газарт бэхлэхийн өвөрмөц чанар оршиж байжээ” хэмээн нүүдэлчин гэдэг үүднээс тайлбарлажээ⁴.

Харин Н.Ишжамц “газрын дээд эзэн буюу ганц өмчтөн нь төр улс, тухайлбал, хаан байжээ. Ноёд газрыг үе улиран эзэмшиж байснаас биш, өмчлөх болоогүй байжээ”⁵ хэмээн газрын дээд өмчтөн нь эзэн хаан байсан бөгөөд ноёдууд эзэмших эрхтэй байсан гэдэг саналыг дэвшүүлсэн. Тэрээр ноёд газар өмчлөх болсон нь Монгол гүрэн мөхсөний дараа төв засаг суларсан феодалын бутралын үед хамаарна хэмээжээ.

Д.Гонгор “XIII-XIV зууны тэргүүн хагасын үед Монгол оронд нэгд, түмэт мянгатын эзэмшил буюу тэдгээрийн ноёдын “захирамж нутаг”, хоёрт, эзэн хаан ба алтан ургийн “их аураг нутаг”, гуравт, талын язгууртны “дархалсан нутаг” хэмээх газар нутгийн өмч эзэмшлийн үндсэн гурван хэлбэр буй болсон хэмээгээд “яваандаа нэгэн наснаас хэдэн үе улирсан хувийн өмч болон хувирчээ”⁶ гэж үзсэн.

Гэвч нүүдэлчдийн уламжлалт эдийн засгийн байгууллын үндэс нь газар биш, зөвхөн малыг хувьдаа өмчлөх ёс хэмээн зарим судлаачид үздэг. Тэд энэхүү саналаа дэвшүүлэхдээ нүүдэлчид газрыг хувьдаа өмчилж байгаагүй гэдгийг гол үндэслэл болгодог⁷. Энэ саналыг дэмждэг судлаачид монголчууд нүүдэлчид учир эдийн засгийн амьдралд газар үндсэн үүрэгтэй биш, малыг хувьдаа өмчлөх нь гол үүрэгтэй байсан гэж үздэг байна.

³ Нацагдорж Ш. *Монголын феодализмын үндсэн замнал*. УБ., 1978. т. 54-55.

⁴ *Монголын феодализмын нийтлэг, онцлогийн зарим асуудал*, Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл, 1987. т. 29.

⁵ Ишжамц Н. *Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь*. УБ., 1974. т. 79.

⁶ Гонгор Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. т. 260-261.

⁷ Толыбеков С.Е. *Общественно-исторический строй Казаков в XVII-XIX веках*. Алма-Ата, 1971. с. 14-24.

Гэтэл Монголын уламжлалт нийгэм дэх газар эзэмшил нь мал хөрөнгөний ялгаанаас биш, харин эзэн хаанаас ургийн гишүүддээ, эсвэл шадар нөхдийн төр, цэргийн үйл хэрэгт байгуулсан гавьяаг үнэлж “соёрхол” хүртээсний үр дүнд үүссэн болох нь Хүннүгийн түүхэнд холбогдох хятад сурвалж болон Монголын нууц товчооны мэдээнээс тодорхой харагддаг билээ.

Монголын уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлд газар, бэлчээрийн гүйцэтгэх үүргийн талаарх асуудалд нэлээд анхаарал хандуулж, гүнзгий судалгаа хийсэн судлаач бол Д. Гонгор юм. Тэрээр “монголчуудын газар өмчийн эрх, эзэмшил эдэлбэрийн бүхүйлэн явцыг туйлын товчоор харуулж болох нь “нутаг” (нунтуг) “нүүдэл” (нэ’үдэл) хэмээх хоёрхон үг болно. Өөрөөр хэлбэл, “нутаг” хэмээн газар шороог, “нүүдэл” гэж түүнийг ашиглах арга хэлбэрийг хэлнэ. Иймээс “нутаг”, “нүүдэл” хоёр бол монголчуудын нүүдлийн амьдралын тодорхой дүр төлөв, газрын харилцааны үндсэн шинж тэмдгийг илэрхийлнэ”⁸ гэж үзжээ. Эндээс үзвэл тэрээр “нутаг” гэж газар шороог, харин “нүүдэл” нь малчдын хувьд газар ашиглах арга хэлбэр гэдэг саналыг дэвшүүлсэн байна. Д.Гонгор Монголын уламжлалт эдийн засгийн тулгуур ойлголт болох “нутаг” гэдэг ухагдахууныг онцгой анхаарч, мөн түүнчлэн хот айл бол газар нутаг эдэлбэрлэх үндсэн нэгж хэмээн санал дэвшүүлсэн нь шинэлэг байсан боловч тэрээр энэ саналаа гүнзгийрүүлэлгүй орхиж, харин нүүдэл бол нүүдэлчдийн газар-бэлчээрийг ашиглах үндсэн арга гэж үзсэнээр нүүдлийг анхдагч хэмээн номлодог номадизмд шилжин оржээ.

Марксист түүх бичлэгт нүүдэл, хот айл, хүрээ, феодалын газар эзэмшил, түүнд суурилсан эзэн хараатын ёсыг нарийвчлан судалж, эдийн засгийн байгууллын ерөнхий тоймыг мал аж ахуй эрхлэгч малчин ард, түүний бүтээгдэхүүнийг татварлан оршигч газар эзэмшигч ноёд, улсын бүх газрыг өмчлөгч хаан гэсэн дарааллаар тайлбарлажээ. Үүний үр дүнд Монголын уламжлалт нийгэм дэх газрын тухай асуудлыг хэрхэн үзэхээс шалтгаалан эдийн засгийн байгууллыг цэргийн ардчилал, аймгийн холбоо, феодалын түрүү үеийн улс, феодалын нэгдсэн улс, феодалын бутралын үе гэх зэргээр шатлан тайлбарлах загвар үүсч, мөн үүний хамт бэлчээр нь феодалын газар өмчлөл үү, эсхүл феодалын газар эзэмшил үү гэсэн урт хугацааны мэтгэлцээн марксист түүхчдийн дунд өрнөсөн юм. Гэвч тэд Монголын уламжлалт эдийн засгийг нүүдлийн технологид тулгуурласан эдийн засаг, ангийн тэмцлийн улмаас тогтсон байгуулал гэж үзэж, мал аж ахуйн үйлдвэрлэл дэх газрын гүйцэтгэх үүргийг нүүдлийн технологи болон дарлах, дарлагдах ёсны үүднээс харж, номадизм болон марксистид гүнээ автаж байсны улмаас Монголын уламжлалт эдийн засгийн байгууллыг газартай холбох асуудлыг шийдвэрлэж чадаагүй ажээ. Ялангуяа монголчууд дулааны улирлын бэлчээрийг нийгмээр хамтран ашигладаг атлаа хүйтний улиралд нэг газартаа байргашин аж төрөгч эсрэг тэсрэг үзэгдэл ангийн тэмцэл болон нүүдэл анхдагч гэх үзлүүдэд гүнээ итгэгч марксистуудын хувьд шийдвэрлэхэд бэрх зөрчил байлаа.

⁸ Гонгор Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. т. 235.

Аппанаж коммунити. К.Этвуд нийгмийн хувьслын онолд суурилсан үзэл баримтлалуудыг шүүмжлэн, бэлчээрийг нийгмээр ашигладаг шинжийг онцгойлон үзсэнийхээ үндсэн дээр Монголын уламжлалт нийгмийн байгууллыг “аппанаж” ба нутгийн нийгэмлэг гэсэн хоёр үндсэн тулгууртай гэж тайлбарлаад, Монголын уламжлалт нийгмийн талаар “Аппанаж коммунити” (appanage community) гэдэг ойлголтыг хэрэглэж, сонирхолтой санал дэвшүүлэв⁹. Тэрээр “Аппанаж нийгэмлэг (appanage community) хоёр талт шинж чанартай байдаг. Нэг талаас феод эсвэл аппанаж нь тодорхой язгууртанд үе удам залгамжлан харьяалагдахаар хуваарилагдсан тодорхой нутаг дэвсгэр болон хүмүүс бөгөөд орон нутгийн засаг захиргааны нэгж болдог. Нөгөөтэйгүүр, ийм аппанаж бүр нь хаалттай, корпорацийн нийгэмлэг (corporate community), өөрөөр хэлбэл аппанажийн нөөцөд эрх, гишүүнчлэлээ хадгалдаг, эдгээр эрхийг дотоод хүмүүсээр хязгаарладаг, гадны хүмүүстэй идэвхтэй харилцахыг хориглодог хүмүүсийн бүлэг юм”¹⁰ хэмээн “аппанаж нийгэмлэг”-ийг тодорхойлсон. Түүний судалгаанаас үзвэл Монголын засаг засаг захиргааны үндсэн нэгж болж байсан Их Монгол улсын үеийн “мянган”, улс төрийн бутралын үеийн “отог”, Манжийн үеийн “хошуу” нь газар нутаг дээр үндэслэн зохион байгуулагдсан засаг захиргааны үндсэн нэгж бөгөөд нутгийн хүн амаас бүрдсэн “хаалттай, корпорацийн нийгэмлэг” ажээ. Мянганы, отгийн, хошууны хүн ам нь бэлчээр, ус болон давс шүү зэрэг байгалийн баялгийг нийтээр ашигладаг, гадны буюу өөр мянган, хошууны хүнд хаалттай нийгэмлэг (community) хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг нутгийн “нийгэмлэг” бөгөөд аппанажийн захирагч, тухайлбал, мянганы ноён, хошууны ноён нь бэлчээрийн менежментийг хийдэг гэсэн саналыг дэвшүүлжээ. Монголын мянган, отог, хошуу нь бэлчээр ус, байгалийн нөөцийг “нутгийн нийгэмлэг” байдлаар дундаа ашигладаг, бэлчээрийн менежментийг нь “нутгийн нийгэмлэг”-ийн удирдагч (тухайлбал хошууны ноён) хийдэг гэсэн тайлбар нь марксист түүхчдийн шийдвэрлэж чадаагүй, нэг нутаг усныхан бэлчээрийг хамтран ашигладаг үзэгдлийг тайлбарлах өвөрмөц санал юм. Ийнхүү К.Этвуд нүүдлийг аппанаж нийгэмлэгийн нутаг дэвсгэрээр хязгаарласнаар Монголын уламжлалт эдийн засгийг газартай уялдуулах талаар том алхам хийж, номадизмыг эргэлзээнд оруулав. Гэвч тэрээр “аппанаж коммунити” дахь (мянган, отог, хошуу) газрыг малын бэлчээр гэсэн утгаар хэрэглэж, үүний хамт нэг нутгийнхан бэлчээр усыг нийгмээр хэрэглэдэг явдлыг аппанаж коммунитигийн үндсэн шинж болгосны улмаас нэг нутгийн малчид хоорондоо өвөлжөө ус булаалдах зөрчлийг зөвхөн засаг захиргааны нэгжийн удирдлагын бэлчээрийн менежментийн чиг үүрэгт хамааруулан тайлбарлахад хүрсэн юм. Малчид өвөлжөө бууцыг нийгмээр бус, ямар нэгэн үйлдвэрлэлийн нэгжээр үе залгамжлан эзэмшиж, ашиглаж, тэрхүү өвөлжөө бууцны байршил, түлш, бэлчээрийг бусдаас хамгаалан тэмцэлдэж

⁹ Atwood C., Banner, Otog, Thousand: Appanage Communities as the Basic Unit of Traditional Mongolian Society. *Mongolian Studies*, Vol. 34 (2012), pp. 1-76

¹⁰ Atwood C., Banner, Otog, Thousand: Appanage Communities as the Basic Unit of Traditional Mongolian Society. *Mongolian Studies*, Vol. 34 (2012), p. 2.

байсан явдал бэлчээрийг нийтээр эзэмших тухай К.Этвудын үзэл баримтлалтай бүрэн тохирохгүй байв.

К.Хамфри, Д.Снит нар “Мал аж ахуйг өрх айл (хувиараа буюу хэсэг бүлгээрээ) эзэмших буюу эрхэлдэг, харин газар нь нийтийн өмч байна. Гэхдээ нийгмийн “дээд” ангийнхан тухайлбал, хаад ноёд, эрх мэдэлтэн түшмэд болон сүм хийдийн жасын зүгээс бэлчээрийг хянах явдал байсан”¹¹ хэмээн К.Этвудтэй төстэй санааг хэлсэн байдаг.

Монголын уламжлалт нийгмийн байгуулал, уламжлалт эдийн засгийн байгууллыг судалсан урьд өмнөх судлаачдын нөр их хөдөлмөрийн үр дүнд ерөнхийдөө хоёр асуудал тодорхой болжээ. Үүнд, нэгдүгээрт, Монголын мал аж ахуйг гардан эрхлэгч малчид газрыг түүхэндээ өмчилж байгаагүй бөгөөд газар нь төрийн өмчид байв. Хоёрдугаарт, төрийн эрх мэдэл, язгууртнуудад олгох соёрхол газраар дамжуулан малчдын нүүдэллэх нутаг дэвсгэрийг хязгаарладаг.

Судлаачид монголын уламжлалт эдийн засгийн байгууллын үндсийг тодорхойлохын тулд газар ба малын гүйцэтгэх үүрэгт ихээхэн ач холбогдол өгч судалсаар ирэхдээ газрыг “бэлчээр” болгон ашигладаг гэдэгт ихээхэн анхаарал хандуулж байв. Урьд өмнөх судлаачид монголчуудыг нүүдэлчид хэмээн үзэж ирсэн буюу одоо ч тийнхүү үздэг тул Монголын уламжлалт болон орчин үеийн эдийн засгийн байгууллыг нүүдэлчдийн мал аж ахуй хэмээн тодорхойлж, түүн дэх газрын асуудлыг улирлын нүүдлийн үүднээс авч үздэг. Иймээс Д.Гонгор хүртэл хот айл ба нутгийн уялдаа холбоог тодорхой тэмдэглэсэн боловч газрын харилцааг түүгээр хязгаарлаж, харин нүүдлийн технологид анхаарлаа хандуулж байжээ. Эдгээр үзэл баримтлалууд номадизмд суурилсан учраас, нүүгээд явчихдаг хүмүүс газрыг бүлгээрээ ашиглахаас өөрөөр хувьд эзэмших харилцаа байх ёсгүй гэж үзэхэд эрхгүй хүрчээ. Гэтэл “хүйтний шимгүй” улирал өвөл, хаварт малын өвөлжөө бууц мал аж ахуйд бэлчээрээс дутахгүй чухал ач холбогдолтой байж, малчид өвөлжөө, хаваржаандаа жилийн ихэнхийг суурин сууж өнгөрөөдөг баримт тайлбарлагдахгүй үлдэж байв. Өөрийгөө “нүүдэлчин” хэмээн тодорхойлдог монгол малчин хэзээ ч байгаагүй бөгөөд өөрийгөө “малчин” хэмээн ухамсарлах малчдын ухамсар, судлаачдаас тэдэнд өгсөн “нүүдэлчин” хэмээх тодорхойлолт хоёр хоорондоо эрс тэс зөрсөөр байна.

Бид урьд өмнөх судлаачдын дэвшүүлсэн саналуудыг тоймлон үзсэнийхээ үндсэн дээр Монголын уламжлалт эдийн засгийн байгууллын үндсийг ахин авч үзэх, ингэхдээ номадизмд тулгуурласан үзэл баримтлалаас татгалзаж, малчин хүнийг малчин гэж харах, зөвхөн бэлчээр тойрсон асуудлаар газрын харилцааг хязгаарлах биш, харин өвөлжөө бууц (малын хот) ба малын бэлчээр хоёрт адилхан ач холбогдол өгөх ёстой гэсэн зарчмыг баримталсан болно.

Энэ үүднээс бид дараах арга зүйг санал болгож байна. Үүнд,

1. Монголын уламжлалт эдийн засаг дахь газрын хамрах хүрээг малд ашиглагддаг бэлчээрээр хязгаарлалгүй, малчны орон гэр оршин буй

¹¹ К.Хамфри, Д.Снит. *Нүүдэллэхүйн ёсон эцэслэх үү?: Өвөр Азийн нийгэм, хүрээлэх орчин*. Орчуулсан Ц.Очирбал. УБ., 2006. т. 3.

байршил болох малын хот газрын харилцаанд чухал үүрэгтэйг хүлээн зөвшөөрөх,

2. Малчид бол нүүдэлчид, байнга нүүдэллэдэг хүмүүс гэдэг номадизмаас түдгэлзэж, нүүдэллэх болон суурин мал маллагааг ижилхэн нэг технологи гэж үзэх,
3. Нэг жилийн дөрвөн улирлыг адилхан чухал ач холбогдолтой гэж үзэхээс татгалзаж, цаг уурын эрс тэс нөхцөл байдал, улирлын ялгаанд анхаарал хандуулах.

Энэхүү өгүүллээр Монголын уламжлалт эдийн засаг ямар зохион байгуулалттай байсан, түүний үндэс юу байсныг тодорхойлохыг зорив. Үүнд эдийн засгийн байгууллыг бүрдүүлэгч хувь хүн, өрх айл, хот айл, нутгийн захиргаа, төр зэрэг субъектууд, тэдгээрийн хоорондоо болон газартай харилцах өмчийн, эзэн хараатын, хөлсний хөдөлмөрийн, газар эзэмшлийн, газар ашиглалтын зэрэг харилцаанууд хамаарах боловч бидний хувьд зөвхөн эдийн засгийн үндсийг, тухайлбал өрх, хот айл, төрийн өмчийн газар, нутгийн захиргаа, газарт тулгуурласан мал аж ахуйн харилцааг хөндөх болно.

Тус өгүүлэлд Монголын уламжлалт эдийн засгийн байгууллын үндсийг дараах дэс дарааллаар авч үзнэ. (1) Малчин өрхүүдийн дангаар орших чадвар болох хамгийн цөөн малын хэмжээг тооцоолох, (2) Малын нэг хотонд байх боломжтой хамгийн их болон хамгийн бага малын тоог тооцоолох, (3) Малын нэг хотонд байх малыг хариуцаж, мал аж ахуйн өдөр тутмын үйлдвэрлэл явуулдаг, газартай шууд харилцдаг эдийн засгийн байгууллын үндсэн нэгжийг оновчтой тодорхойлох, (4) Төрийн өмчийн газраас мал аж ахуйд ашиглагдаж буй газрыг зориулалтаар нь ангилж, ангилал тус бүрийн ялгааг тодорхойлох, (5) Мал аж ахуй эрхлэгч үндсэн нэгж нь газрын харилцаанд хэрхэн оролцдог, газар өмчлөгч төртэй ямар харилцаанд ордгийг тодорхойлох.

Малчин өрхүүд мал сүргийг өмчлөгч мөн боловч мал сүргийг өрхүүд биш, харин мал аж ахуйн хотууд хариуцан үйлдвэрлэл явуулж, ингэснээр тэрхүү мал аж ахуйн хотууд эдийн засгийн байгууллыг бүрдүүлэгч үндсэн нэгж болдог байв. Монголын уламжлалт мал аж ахуйн үндсэн баялаг нь мал мөн боловч үйлдвэрлэлийн үүднээс авч үзвэл мал нь “сүрэг” гэсэн зохион байгуулалтаар газартай холбогддог. Сүргийн байгуулал шууд газартай бус, нутаг хэмээх газрын эдэлбэр хэсэгт тулгуурлана. Монголын уламжлалт эдийн засгийн байгуулал нь мал өмчлөгч өрхөөс үүссэн мал аж ахуйн хот, малаас үүссэн сүрэг, газар ашиглалтаас үүссэн нутаг, товчоор хот-сүрэг-нутаг гэсэн зохион байгуулалттай байв. Мал аж ахуйн хот ба сүрэг нь байнгын суурин цэг өвөлжөөгөөр дамжуулан нутагтай уягдаж, иймээс Монголын уламжлалт эдийн засгийн байгуулал тус бүр нэг өвөлжөө эзэмшсэн мал аж ахуйн хотуудаас бүрэлдэн тогтож, тэрхүү мал аж ахуйн хотууд нь язгууртан, баян, дундаж, ядуу малчин зэрэг янз бүрийн өрхүүдээс бүрдэж байжээ. Энэ эдийн засгийн байгууллын үндэс суурьт бүх газрыг өмчлөгч, Монголын газар нутаг, гол ус, уул нурууд, газрын хэвлий, ой мод, усгүй цөл, зэлүүд газрын дээд эзэн – хаан, түүнийг төлөөлөн, түүний соёрхлын

үндсэн дээр газрыг эзэмшигч засаг захиргааны нэгжүүд оршин байв. Товчхондоо, энэ өгүүллээр бид, Монголын уламжлалт мал аж ахуй бол Евразийн нүүдлийн мал аж ахуйгаас онцлог ялгаатай, хүйтний улирлын нутгийг үйлдвэрлэлийн нэгжүүдэд үнэгүй, хугацаагүйгээр эзэмшүүлдэг, төрийн өмчийн газар дээр суурилсан эдийн засаг юм гэсэн санал дэвшүүлж байна.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮНДСЭН НЭГЖ МАЛ АЖ АХУЙН ХОТ БОЛОХ НЬ

Монгол хэлний *хот* хэмээх үг нь үндсэн гурван утгатай: 1. Хонины хот, 2. Хот айл, 3. Хот суурин. Орчин үеийн монгол хэлэнд “хот айл” гэсэн ухагдахуун хэвшиж тогтсон боловч уламжлалт эдийн засгийн үед хамаарах архивын баримтуудад нэг хот айлыг “хот”, хоёр буюу түүнээс олон хот айлыг “хот айл, хот хүн” гэж нэрлэж ирсэн ба *хот айл* гэдэг нь уламжлалт эдийн засгийн үед *хотын* олон тоо байжээ. Иймээс энэхүү өгүүлэлд уламжлалт “хот” хэмээх ойлголтыг орчин үеийн хот айлаас ялгахын тулд *мал аж ахуйн хот* хэмээн тодруулж нэрлэв.

Мал аж ахуйн хотын түүхэн улбаа

Монголын мал аж ахуй судлаачид *өрхийг* мал аж ахуйн үндсэн нэгж хэмээн үзэж иржээ. Иймээс ч эдийн засгийн байгууллыг ихэнхдээ *өрх* дээр тулгуурлан тайлбарладаг. *Хот айлыг* онцгойлон анхаарсан судлаачид байдаг боловч *мал аж ахуйн хотын* эдийн засгийн үндсийг нүүдлийн мал аж ахуйтай холбон тайлбарлаж, харин газрын харилцаатай холбон тайлбарладаггүй. Харин Д.Гонгор *мал аж ахуйн хотыг* газартай холбогдогч үндсэн нэгж гэж үзээд, түүнийг нэг өтөг бууцанд оршин байгаа хэдэн *өрх* гэрийн нэгдэл гэж тодорхойлж, түүнийг газар ашиглагч субъект гэж үзжээ.¹²

Монголын уламжлалт мал аж ахуйн нөхцөлд *өрх* нь мал аж ахуйн хамгийн бага нэгж мөн боловч газартай тэр бүр шууд уялдаагүй юм. Хэрэв хоёр ба түүнээс дээш *өрх* хамтран хонин сүргээ малын нэг хотонд маллах нөхцөлд тэр хоёр *өрхийн* өмч, орлого, зарлага тусдаа байж, хөдөлмөрөө хоршиж үйлдвэрлэл явуулдаг бөгөөд тодорхой нэг байршилд хамт амьдарч, нутаг эзэмшлээр нэгдмэл болон хувирах тул тэр хоёр өрхөөс бүрдэж буй *мал аж ахуйн хот* нь үйлдвэрлэл явуулах зохион байгуулалт болон хувирдаг. Ноёны сүргийг хариулж буй *сүрэгчин өрх*, тэр атугай ноён өөрөө ч ямар нэгэн *мал аж ахуйн хотод* харьяалагдах замаар мал аж ахуйн үйлдвэрлэлд оролцдог.

Мал аж ахуйн хотыг үүсгэж буй анхдагч нь хонин сүрэг бөгөөд нэг хонины хот даган цуг мал маллагч өрхүүдийг нэг хотныхон гэдэг. *Хот* гэдэг нь хонины нэг сүрэг шөнийг хэвтэж өнгөрүүлэх цэгийг хэлнэ. Хонины мах, сүү, ноос, арьс нь монголчуудын үндсэн идээ, шүүс, хувцасны түүхий эд төдийгүй, ахуй амьдралд чухал үүрэгтэй бусад олон төрлийн бүтээгдэхүүнийг хониноос гарган авдаг. Монголын уламжлалт мал аж ахуйн тухайд хоньгүй хаан, хоньгүй малчин

¹² Гонгор, Д. Халх товчоон. II боть. УБ., 1978. т. 297.

байдаггүй, байх ч боломжгүй. Монголын Нууц Товчооны (цаашид МНТ гэж товчлох) 124-р зүйлд Чингис хааны хоньчин Дэгэй “шилэгү ирэг шөл болгож манагар бүү мэгүүдэсү, хоногт бүү хожигдсу” гэж өгүүлээд хоньчин болж, хааны ордны шүүсийг хариуцаж байв. Хонины нэг сүрэг нь өмчийн хувьд өрхийн өөрсдийн хонь ямаа, бусдын тавиул хонь ямаа, жасын хонь ямаа, ноёны хонь ямаа зэрэг янз бүр байж болох ч нэг сүрэг учир нэг л *малын хоттой* байна. Малаа сүрэглэн нэгтгэх, эсхүл нэг баян өрхийн малыг ядуу өрх нь хамтран маллаж идээ шүүс хүртэх замаар хамтран аж төрдөг айлуудыг нэг сүрэг адууны өрхүүд буюу нэг сүрэг үхрийн, нэг сүрэг тэмээний өрхүүд гэж үздэггүй, зөвхөн хонины хотоор нэгдсэн өрхүүд учир *нэг хотны өрхүүд* буюу *нэг хотны айл* гэж нэрийднэ. *Мал аж ахуйн хотыг* дотор нь ангилах боломжгүй, нэгдмэл сүрэгтэй, нэгдмэл арга ажиллагаатай тул дотроо хөдөлмөрийн хуваарь үүсгэнэ.

Мал аж ахуйн хот нь мал аж ахуйн хөгжлийн бүх үе шатанд, бэлчээрийн мал аж ахуй үүссэн үеэс эхлэн 1960 оныг хүртэл хонины нэг сүрэгт, түүний шөнө хэвтдэг нэг хотонд тулгуурласан мал маллах үндсэн зохион байгуулалтын нэгж байж ирсэн бололтой. Сяньби, Ухуаний талаарх хятад сурвалжид Ухуаний нийгмийн зохион байгуулалтын талаар тэмдэглэхдээ “хот айл”-ын талаар өгүүлсэн гэж судлаачид үздэг.

“Хожуу Хан улсын түүх”-ийн “Ухуаний шастир”-т:

“Зоригтой бөгөөд хэрэг маргааныг таслах чадвартай хүнийг сонгон их ахлагч болгоно. Үе дамжин залгасан ажил үйл гэж байхгүй. Хот айл (邑落 yiluo) болгон бага удирдагчтай (小帥 xiaoshuai), харин хэдэн зуу эсвэл мянган өрхөөс (落 luo) нэг бу/эзэмшил (一部 yibu) бүрдэнэ. Ахлагч (大人 daren) дуудахдаа мод сийлж (刻木 kemu) захидал болгон илгээнэ. Хэдийгээр бичиг үсэг байхгүй ч бу (部 bu)/эзэмшлийн олон нь түүнийг зүрхлэн зөрчихгүй. Овгийн нэр (氏姓 shixing) тогтворгүй, ахлагчийнхаа нэрээр ураг (姓xing) болгоно. Ахлагчаас доош тус тусдаа малаа маллан аж төрнө, биенээрээ туслуулдаггүй”¹³ хэмээжээ.

Хожуу Хань улсын түүхийн Ухуаний шастир дахь дээрх мэдээг судлаачид өөр өөрөөр орчуулж тайлбарлах нь буй. Хот айл буюу (邑落 yiluo), өрх буюу (落 luo), бүлэг/аймаг буюу бу (部 bu) гэдгийг юу гэж орчуулснаас хамаарч янз бүрээр ойлгох нь буй. Бид 落 luo гэдгийг өрх гэж, 邑落 yiluo гэдгийг *хот айл* гэж орчуулах нь монгол нутаг дахь нүүдэлчдийн хувьд тохирно хэмээн үзэж байна. Учир нь “邑落 yiluo болгон бага удирдагчтай” гэдэг нь *хот айлыг* хэлж буй хэрэг юм. “Харин хэдэн зуу эсвэл мянган өрхөөс (落 luo) нэг бу/эзэмшил (一部 yibu) бүрдэнэ” гэдгээс үзвэл 落 luo нь *өрхийг* буюу нэг айлыг хэлж байна. Монголчуудын уламжлал ёсоор “айл” гэж *хот айл* буюу хэд хэдэн өрхийг хэлдэг, харин нэг айлыг “өрх” гэдэг байсан. Малчдын зохион байгуулалтын томоохон бүлгийг булуу (部落 buluo) гэж хятад сурвалжид Сяньбийн үеэс нэрлэх болсныг судлаачид *аймаг* хэмээн орчуулж ойлгох болсноор нүүдэлчид овог аймгийн

¹³ 后汉书. 卷90. 乌桓鲜卑. 第2979页.

нийгэмтэй байсан гэдэг ойлголт түгэн дэлгэрэх болсон билээ. Гэтэл үнэн хэрэг дээрээ булуу (部落 buluo) гэж нүүдэлчдийн засаг захиргааны томоохон нэгж, эсвэл нэг язгууртны эзэмшлийг нэрлэж байсан хэмээн үзэж болно. Тиймээс и- бу (一部 yibu) гэдгийг эзэмшил гэж орчуулж болох юм.

Хот хэмээх үг нь хамгийн наад зах нь 13-р зууны үед өнөөгийнхтэй адил хонины хот, хот балгад гэсэн хоёр утгаар хэрэглэгдэж байжээ. МНТ-ы 124-р зүйлд “хонхогчиуд хоньдыг адуулж *хотон* дүүргэсү” хэмээн хонины хотыг шууд заан дурьдсан бол 195-р зүйлд “олон хоньд чоно үлдэж *хотонд* хүртэл үлдэж ирэх мэт” хэмээн мөн хонины хотыг өгүүлж байна. Галигийг дор сийрүүлвэл:

124. ...degei ügülerün silegü irge šülen bolqaju manaqar bu megüdesü qonoq-tur bu qojidasu alačqi’ut qoni<n>d-i adu’ulaju alam dü’ürgesü qongqočqi’ut qoni<n>d-i adu’ulaju **qoton** dü’ürgesü qo”olančar mawui büle’e bi qoni<n>t adu’ulaju qonjijasun idesü bi degei qoni<n>t adu’ulaba

195. ...tayang-qan jамuqa-dača asačču’u tede ya’ut olon qonit čino hüldeјü **qoton-tur** гүртеle hüldeјü iregü metü ede ya’ut haran teyin hüldeјü ayisai ke’en asaqba

Мөн тус үг МНТ-нд *хот суурин* гэсэн утгаар 247, 248, 272, 279-р зүйлүүдэд “хотод хотод балгадад”, “хотод хотод”, “хотод балгад нь”, “балгад хотдоо” хэмээн гарч байна. Монгол хэлний “хот” хэмээх үг нийт 11 утгатайгаас МНТ-нд түүний хамгийн түгээмэл хоёр утга болох *хонины хот хэвтэр*, *хот суурин* гэсэн үндсэн хоёр утга гарч буй бөгөөд сүүлийн найман зуун жилийн турш *хот* гэсэн үгийн үндсэн хоёр утгад ямар нэг өөрчлөлт ороогүй байна.

Хонин сүрэг бол монгол малын хамгийн таваарлаг төрөл бөгөөд малчдын үндсэн хүнс, дээл хувцас, сууцы ашиг шимээс бүрдүүлнэ. 13-р зуунд монголчууд өөрсдийгөө “эсгий туургатан улс” хэмээн оноон нэрлэж байсан нь хонины ноос оролцуулан хийдэг эсгий хичнээн чухал бүтээгдэхүүн байсныг илтгэнэ. Хонь зөвхөн хүнс, хувцас, сууцны эсгий төдийгүй, сүүний эх үүсвэрийн томоохон хэсгийг бүрдүүлдэг. *Хот* нь хоньтой салшгүй холбоотой. МНТ-нд хонхогчиуд хоньдоор *хотоо* дүүргэх, хоньдыг чоно *хотонд* хүртэл үлдэх гэсэн хэллэгүүдээс гадна 19-р зүйлд хонь чанах, 100-р зүйлд хонь хяргах, 118-р зүйлд хоньчид хургачид, 152-р зүйлд хоньчин, 181-р зүйлд сартагчин хонь, 189-р зүйлд үнээд хоньдоо саалгах, 234-р зүйлд адуучин, хоньчин, тэмээчин, үхэрчин, 280-р зүйлд шилэгү ирэг, зусаг, шүүсний хоньд гэсэн үгс гарч байгаа нь хонины махыг чанаж иддэг, ноосыг хяргаж эсгий хийдэг, ордны аж ахуйд хоньчин болон хургачин ялгарч төрөлжсөн, сартагчин хонь, хонхогчиуд хонь зэрэг төрөлтэй, хонийг ирэг, зусаг гэхчилэн нас, хүйсээр өнөөгийнхтэй адил ялгаварлан нэрлэдэг байсныг харуулна. Өөрөөр хэлбэл МНТ-ны мэдээнээс үзэхэд монголчуудын хонины аж ахуйд 13-р зуунаас хойш өнөөг хүртэл томоохон өөрчлөлт ороогүй байна. Иймээс хонины хот, түүнд тулгуурласан *хот* хэмээх мал аж ахуйн нэгж энэ үед байсан гэж үзүүштэй.

Дайчин улсын үеийн баримтад бүлэг хүнийг, тэдний малыг хэмжих үндсэн нэгж нь “хот” байв. 1791 онд холбогдох нэгэн бичигт “Агарын баруун этгээдэд суугаа Холч, Жамъян, Өөлд, Муухүүхэн нар таван хот улсын мал”, “Хөх усанд суугаа тайж Гомбо, тайж Түгж нар[ын] зургаан хот улсын мал” хэмээн дурьдсанд¹⁴ буй “хот” хэмээх нь нэг хонины хотонд цуг нутаглаж буй өрхүүдийг, товчоор бол мал аж ахуйн нэг хотыг зааж байна. Харин “хот айл, хот улс, хот хүн” хэмээх нь мал аж ахуйн хотын олон тоо байна. Мөн “хот улсын мал” гэдэг үгээр мал аж ахуйн хэд хэдэн хотод харьяалагдах мал сүргийг зааж байна.

Дайчин улсын үеийн “хот” хэмээх үгийн утгын түүвэр

Хугацаа	Үйл явдал	Тоо	Хэмжих нэгж
1765 он	Энэ жил өвлийн дундат сарын арван долооны өдөр засаг Дамиранжавын хошууны мэйрэн Жамба арван долоон цэрэгтэй ирж Гурвансайханд суусан Пунцаг Жигмид нарын зэрэг дөрвөн хот улсаас шар дөрөв, үнээ арьан дөрөв, ...Мөнхүү өвлийн сүүл сарын аравнаа мэйрэн Лхамжав, хүнд Гэндэн нар арван таван цэрэгтэй ирж Ихгазарын Гурван цагаан булаг зэрэг газраас Борнайн зэргийн гурван хотоос шар хоёр, үнээ арван хоёр... Мөн арван есөнд засгийн дүү туслагч тайж Дэрэм арван дөрвөн цэрэгтэй ирж Тэвшийн зэрэг газраас нэг хотын шар хоёр, үнээ дөрөв, Дорж нэг хотоос шар нэг, үнээ хоёр. Бүх үхрийн довтлогдсоноос ард цөм амь алдахад хүржээ.	Пунцаг, Жигмэд нарын зэрэг дөрвөн хот улс Борнайн зэргийн гурван хот Нэг хот Дорж нэг хот	Хот улс Хот
1790 он	Санж Баарины вангийн замаар хил болгоё гэж булаалдсан зүүн этгээдэд мөн бэйсийн хошууны туслагч, тавнан Доржийн зэрэг зургаан хот хүн эдүгээ нутаглан суув.	Зургаан хот хүн	Хот хүн
1791	...Гомбо тайж, Түгж нар зургаан хот айлын мал зургаан тэмээ нэг хонь бариад нааш явтал, ...Энэ зуны зургаа сард тайж Түгжийн зэрэг зургаан хот айл хөх усны зүүнтээ бууж. ...Холчийн хэлэх нь: Энэ жилийн зуны дундат сард, Муухүүхэн, Игва увс, Жамба гэцэл, Цэдэв бид таван хот хүн, ...Балайн худаг өөр манай хоёр хошуунаас суусан хэд хэдэн хот хүн мал урьд... ...Хөх усанд сууж мал барьсан манай хошууны зургаан хот.	Зургаан хот айл Таван хот хүн Хэд хэдэн хот хүн Зургаан хот	Хот айл Хот хүн Хот

¹⁴ Хувьсгалын өмнөх Монгол дахь газрын харилцаа, эмхэтгэсэн Цэ. Шархүү, Улаанбаатар: УХГ, 1975. 21-р тал.

1825	<p>Тогооч тайгам Дэлэгийг зарж Сайншандын гэдэг усны баруун хойт этгээд дэх хоёр дахь бууцнаа нутаглан, хиа Амгалан өвгөн нарын хоёр хот хүний нутгийг хэдэн удаа хөөж Амгалангийн суусан бууцанд тайж Тогооч хэдэн хот хүн нар буусанд Амгалан нар хөөсөн.</p> <p>Хиа Бүрэн, тавнан Гиваа, Баастын зэрэг дөрвөн хот гээд олон өрх хүн манай нутаг Цагаанбургасын Уу хар зэрэг газруудаар нутаглан буусан.</p> <p>Тогооч: Цагаанбургасны Ууд Хунтайж Хөдөө, хаиа Бүрэн нар хоёр хот олон өрх нутаглан суув. Амгалан: өвгөн бидний хоёр хот хүн мөн Шандны хойт хоёр бууцнаас нутаглан суутал..., өвгөн таны хоёр хоёр хот хүн суугаа бууц болбол манай нутаг тул даруй нүү гэхэд би чамд хөөгдөж нүүхгүй, нүүх цагтаа нүүнэ гэж уг өвөлждөг бууцнаа буусан хойно мийн нүүсэн бууцанд тайж Тогооч нар гурван өрх буусан тул очиж түүнийг хөөвөл.</p> <p>Амгалангийн мэдүүлэх нь: Тайгам Өвгөн манай хоёр хот тус нутаг Сайншандын баруун хойт этгээд дэх</p>	<p>Хоёр хот хүн Хэдэн хот хүн Дөрвөн хот олон өрх хүн Хоёр хот олон өрх Хоёр хот хүн Гурван өрх Хоёр хот</p>	<p>Хот хүн Хот олон өрх хүн Өрх Хот</p>
1827	<p>Гүн Равдандорж, хуяг Бааст нарын мэдүүлэг: Бид Бор өндөрийн ойр нутаглаж суухад да гүнтний хошууны захирагч Довчин, ард Майдар нарын хэдэн хот хүн ирж манай дэргэд нутагласан.</p> <p>Гүн Равдандоржийн хошууны Шажингийн мэдүүлэх нь: Шанагабулаг гэдэг газар нутаглаж суун атал да гүний хошууны Цэдэнжавын зэрэг хэдэн хот хүн нүүж ирэхэд уналга үгүй тул хол нүүж чадахгүй бага зайлж өгөмүй гэхэд хэрэгсэхгүйд зургаан морь хоёр хонуулаад өгсөн. Бүрэн нарын гурван хот хүнээс арван зургаан морь барилан нутгийг өнүүхэн зайлуулсан.</p>	<p>Хэдэн хот хүн Гурван хот хүн</p>	<p>Хот хүн</p>
1920 он	<p>Жаргалант өртөөний занги Данзан нараас өргөсөн бичиг: Манай өртөөний улаач нараас нэгэн зэргээр цухалдан мэдүүлж ирсэн нь: манай өртөөний нутаг Олон овооны Адагийн усны зэрэг шавь нар арван хэдэн хот айл нүүж ирж зоримгоор эзэрхэн түрэмгийлэх нь нүд үзэхэд илэрхий болжээ.</p>	<p>Арван хэдэн хот айл</p>	<p>Хот айл</p>
1919 он	<p>Мөнх-Очир ураг төрлийн хэдэн хоёр хот баялаг хөрөнгөтэй түшмэл</p>	<p>Хоёр хот</p>	<p>Хот</p>

Эх сурвалж: *Хувьсгалаас өмнөх Монгол дахь газрын харилцаа*, эмхэтгэсэн Цэ. Шархүү, Улаанбаатар: УХГ, 1975.

Хэсэг бүлэг хүнийг хэмжих үндсэн нэгж нь *өрх* байх учиртай боловч дээрх баримтын түүвэрт бараг ихэнх тохиолдолд бүлэг хүнийг хэмжих үндсэн нэгж нь *хот* байх бөгөөд *хот* бүрийг ахлагчаар нь нэрлэж, таван *хотны улс хүмүүс*, зургаан *хот улс* буюу зургаан *хотны хүмүүс* гэсэн утгаар тоочиж байна. Түүврээс үзэхэд Холч нарын таван *хот улс* буюу таван *хот айлын* хүмүүс, тайж Гомбо нарын зургаан *хот улс* буюу зургаан *хот айлын* хүмүүс нь бусдын хошууны өвөлжөөний нутагт нүүж орсон *мал аж ахуйн хотуудын* бүлэг юм. Иймээс газар, өвөлжөө бууцтай холбогдол бүхий мал аж ахуйн үндсэн нэгж нь дундаа хонины нэг хот бүхий нэг буюу хэд хэдэн өрх гэдгийг дээрх жишээ харуулж байна.

Зарим судлаач *хүрээ* гэдэг ойлголтыг мал аж ахуй эрхлэх зохион байгуулалтын үндсэн нэгж байсан бөгөөд *хүрээ* задарч *хот айл* хэмээх шатанд шилжсэн хэмээх санал дэвшүүлж ирсэн. Тухайлбал, Б.Я.Владимирцов Рашид ад Диний мэдээнд тулгуурлан монголчууд *хүрээгээр* нүүдэллэдэг байсан ба Чингис хааны үед нэгэнт *айлаар* нүүдэллэх болсон байв гэж үзсэн бий.¹⁵

Гэвч мал аж ахуйн үүднээс харвал *хүрээ* нь урт хугацааны турш мал аж ахуйн үйлдвэрлэлийг байнга, тогтвортой эрхлэн явуулах боломжгүй юм. Энэ талаар Ш.Нацагдорж тодорхой тэмдэглэсэн ба тэрээр *хүрээг* феодалын аж ахуйн гол мөхлөг, мөлжлөгийн гол хэлбэр байсан ч маш олон айлын малын бөөгнөрөл гэж үзэж болохгүй, энэ нь эдийн засгийн талаар даанч боломжгүй” гэж үзжээ.¹⁶

Хэрэв *хүрээ* нь нийгэм-эдийн засгийн үндсэн зохион байгуулалт гэвэл, энэ нь малчин *өрхүүдээс* бүрддэг гэж үзвэл, олон тооны *өрхийн* төвлөрөл нь малын томоохон хэмжээний бөөгнөрлийг үүсгэхэд эрхгүй хүргэнэ. Ялангуяа нэг *хүрээнд* байх хэд хэдэн хонин сүрэг нь тусдаа *хотуудад* ялгарч хэвтэх ямар ч боломжгүй юм. Иймээс *хүрээгээр* мал малласан нөхцөлд хонины хэт том нэг сүрэг үүсч, улмаар бэлчээрийн даац хүрэлцэхгүй болно. Саалийн улиралд тэрхүү олон мянган хонины хургыг өдөр болгон ялган авч, зэргэлдээх саахалт сүрэгт нийлүүлэх нь бараг боломжгүй үйл ажиллагаа юм. Хонийг хэдэн мянган толгойгоор сүрэглэсэн нөхцөлд бэлчээрийн даацаас шалтгаалан сааль эрхэлдэггүй отрын хэлбэр рүү эрхгүй шилждэг. Үүнд, социализмын үеийн 1000-2000-аар нь сүрэглэсэн тууврын хонин сүргийг жишээ болгон дурьдаж болно. Зун болон намрын улиралд ийм аварга сүрэг отрын аргаар орших боломжтой боловч өвөл ба хаврын улиралд ийм аварга сүрэг нь малын хөлийн зуд үүсгэж, өөрөө тэрхүү зудандаа үрэгдэх болно.

Хэрэв *хүрээ* нь нэг *хот айлын* хэмжээний цөөн хонь, үхэр, адуун сүрэгтэй гэж үзвэл *хүрээний* олон арав, магадгүй олон зуун хүний хүнсийг нэг хотны мал сүргүүд үйлдвэрлэх боломжгүй бөгөөд гаднаас хүнс авахад хүрч, улмаар аж ахуйн бие даасан нэгж байж чадахгүй болно.

Хүрээ нь мал аж ахуйн нэгж биш, харин ноёд язгууртны ордон, улс төрийн төвлөрөл гэсэн Ш.Нацагдорж нарын санал зөв юм. Мөн *хүрээ* нь тайван биш,

¹⁵ Б.Я.Владимирцов, *Общественный строй Монголов, Монольский кочевой феодализм*, Ленинград, Издательство Академии Наук СССР, 1934, 86-р тал.

¹⁶ Ш.Нацагдорж, Монголын феодализмын үндсэн замнал, *Эрдмийн бүтээлийн эмхэтгэл*, 2-р боть, Улаанбаатар, 2018, 49-р тал.

дайн байлдаантай үеийн цэрэг-аж ахуйн түр зуурын зохион байгуулалт байж болох юм. Иймээс *хүрээ* ба *мал аж ахуйн хот* гэсэн хоёр бүтцийг мал аж ахуйн хөгжлийн дараалсан үе шат гэж үзэх нь оновчгүй байна. *Хүрээ* нь нийгмийн буюу эдийн засгийн зохион байгуулалт биш, харин Ш.Нацагдорж тодорхойлж байсанчлан цэрэг дайны болон ноёны ордны үйлчилгээний чиг үүрэгтэй *өрхүүд* буюу цэргийн нэгжүүдийн гэрээс бүрддэг цэрэг-улс төрийн төвлөрөл байв. Харин *мал аж ахуйн хот* нь малын зүйл бүрийн тохиромжтой тоо толгойн хэмжээ бүхий сүрэгт тулгуурладаг аж ахуйн зохион байгуулалт байж, энэ хоёр зохион байгуулалт аль аль нь эрт, дундад үед өөр, өөр зориулалттайгаар зэрэгцэн оршиж байсан гэж үзүүштэй.

Өрхийн өмч ба малын тоо

Бид энэ зүйлд мал аж ахуйн хотыг бүрдүүлэгч *малчин өрхийн* бие даан орших чадварыг авч үзэх замаар *мал аж ахуйн хот* үүсэх урьдач нөхцлийг тодруулна. Үүнд, нэг *малчин өрх* бие даан оршин тогтнохын тулд өмчдөө байлгах малын хамгийн бага тоо болон, *өрхийн* дангаар орших чадварыг нэг *малчин өрхийн* мал сүрэг нэг жилд төлөөр өсөх хувь болон тухайн *өрхийн* нэг жилийн малын зайлшгүй зарлага дээр тулгуурлан тодорхойлно. Эдгээр үзүүлэлтүүдийг бид ХХ зуунд хамаарах тоон мэдээллүүдээс тооцоолон гаргах болно.

Өмч бол шийдвэр гаргах эдийн засгийн эрх мэдэл юм. Монголын бүх мал тодорхой тоо хэмжээний доод, дээд хязгаар бүхий *сүрэгт* хуваагдан оршдог бол *сүрэг* нь ямар нэгэн өмчийн хэлбэрт хамаарч, мал өмчлөгч хүмүүс *сүргийн* тоо хэмжээ, нутаглах газар, зарцуулах хөдөлмөр, орлогын хуваарилалт зэрэг эдийн засгийн шийдвэрийг гаргадаг. Уламжлалт эдийн засагт *улсын сүрэг, хааны сүрэг, язгууртны сүрэг, сүм хийдийн сүрэг*, ардын мал сүрэг зэрэг өмчлөлийн хэлбэрүүд байсан ч эдгээрээс сүргийг бүхэлд нь буюу хэсэгчлэн өмчилдөг хамгийн ерөнхий хэлбэр нь хааны, язгууртны, ардын зэрэг анги давхраануудад нийтлэг байх *өрх* билээ. Иймээс Монголын уламжлалт эдийн засгийн хамгийн бага нэгж бол *өрх* юм. *Өрх* гэж нэг гэрт хамт амьдарч буй, нэгдмэл санхүүтэй бүлэг хүнийг хэлнэ. *Өрх* нь мал сүргийг өмчилж, өмчийн шийдвэрийг бие даан гаргана.

Өрх нь эдийн засгийн нэгж тул бие даан оршиж, орлого, зарлагаа өөрөө хариуцна. Мал аж ахуйн орлого малын тоо толгой, малын төрөл, нутаг, бэлчээр, уур амьсгал, *өвөлжөө* зэрэг олон хүчин зүйлээс шууд хамаарна. Үүнээс *малчин өрхийн* оршин тогтнох эсэхийг шийдэх хүчин зүйл бол өмчлөх малын тоо юм. Монголын уламжлалт эдийн засаг хонь, ямаа, адуу, үхэр, тэмээ гэсэн таван зүйлийн мал дээр тулгуурлан оршиж байсан бөгөөд тэдгээр малын зүйлүүд нь хоорондоо тодорхой харьцаатай байдаг. *Сүргийн* агуулах амьтны тоо толгойн хувьд хамгийн олон нь хонь, ямаа, түүний удаад нь адуу, үхэр, хамгийн цөөн нь тэмээ байна.

Хүннү, Сяньби, Жужаны аж ахуйг дагнан судалсан Г.Сүхбаатар “Хүннүгийн сүрэгт хамгийн олон нь бог мал (хонь, ямаа), дараа нь адуу, үхэр, хамгийн сүүлд тэмээ орж байна” хэмээгээд сүргийн энэ бүтэц Хүннүгээс Сяньби, Жужанаар

дамжин Их Монгол улсад уламжилсан хэмээн үзжээ. Сүргийн энэ бүтэц нь Монгол орны байгаль-цаг уурын онцлогт тохирсон, байгалийн шалгарлаар шалгагдсан бүтэц бөгөөд хэдэн мянган жилийн турш уламжлагдсан хэмээн үзэж болох юм. Тэрээр *сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй* Хүннүгийн үед үүссэн гэдэг үзэл баримтлалыг дэвшүүлээд “Сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй гэдэг нь тухайн байгаль-газар зүйн өвөрмөц нөхцөлд таван төрлийн малыг маллагааны нарийн технологийн үндсэн дээр үржүүлэн аж ахуйн үндсэн салбар болгон, аж ахуйн талаар цогцолбороор нь ашиглаж, ан, зарим талаар багахан тариаланг туслах чанарын аж ахуйн байдлаар ашигладаг нүүдлийн мал аж ахуй юм”¹⁷ хэмээн тодорхойлсон. Малын зүйл хоорондын энэ харьцаа Хүннү улсын үеэс эхлэн бараг өөрчлөлтгүйгээр ХХ зууны эхэн үе хүртэл уламжлагдаж иржээ. Иймээс бид ХХ зууны дүн мэдээг уламжлалт мал аж ахуйн тухайд хэрэглэхэд онолын хувьд боломжтой юм.

Малын өсөлтийн үндсэн тоо нь хээлтэгч мал, түүнээс хүлээн авах төлийн тоо билээ. ХХ зуунд Монголын бүх малын дотор ойролцоогоор 9-12 сая толгой буюу 50 орчим хувь нь хээлтэгч мал байв. Таван зүйлийн малыг дундажлан үзвэл, 100 эхээс дунджаар 48 төл,¹⁸ жил тутам улсын хэмжээнд 4-6 сая төл бойжуулж байв. Үүнийг 150 толгой малтай өрхөөр жишээ болгон авч үзвэл, 150 толгой малын дотор 75 хээлтэгч мал байж, түүнээс 37 төл бойжуулж, зарлага ба хорогдол тооцоогүй малын бохир өсөлт нэг жилийн хугацаанд 37 байна. Үүнд тулгуурлан жил бүрийн дундаж өсөлтийн хувийг тооцоолвол дараах байдалтай.

Малын тоо:	M
Хээлтэгч малын тоо:	$X = M/2$
Төлөөр өсөх хувь:	$B = X/2$ буюу $B = M/4$

Мал сүрэг нь нэг жилд нийт тооныхоо $1/4$ -тэй тэнцэх төл бойжуулдаг буюу ойролцоогоор төлөөр өсөх бохир өсөлтийн хувь нь ойролцоогоор 25 байна. Энэ бохир өсөлт нь малчин өрхийн бүх хэрэглээ, эрсдэл туулах чадвар, ашгийн үндэс болно. Хэрэв өрхийн хэрэглээ, малын зүй бус хорогдлын нийлбэр малын тооны 25 хувиас байнга хэтэрвэл тухайн өрх 4-8 жилийн дотор үгүйрнэ.

Мал сүргийн өсөлтийн эсрэг талд хорогдол бий. Хорогдлыг үндсэн таван төрөлд хуваах ба үүнд идэш, татвар, чоно, зуд, өвчин хэмээн авч үзнэ. Мал сүргийн бохир өсөлт нь хорогдлоосоо тоогоор илүү бол мал өсч, харин хорогдлоосоо тоогоор бага бол малын тоо хорогдоно.

Ган, зудгүй хэвийн нөхцөлд малын хорогдлын үндсэн хэсэг өрхийн хэрэглээ ба татвар байна. Малчин өрхүүд 1949 оны байдлаар 21.8 сая малтай байсан бөгөөд 1950 онд 6.6 сая төл бойжуулж, 6.2 сая мал хорогдуулжээ. Хорогдлыг дотор нь задлан авч үзвэл, өрхийн хэрэглээнд 3 сая, улсын бэлтгэл буюу татварт

¹⁷ Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980. т. 215.

¹⁸ Үндэсний статистикийн хорооны цахим хуудас, www.1212.mn 2025.11.24.

2.2 сая мал зарцуулж,¹⁹ зуднаар 0.45 сая, өвчнөөр 0.46 сая, чононд 0.05 сая мал үхүүлжээ.²⁰ Бидний энэ жишээнд буй улсын бэлтгэл нь 1941 оноос БНМАУ-д бий болсон албан журмын худалдан авалтыг хэлж буй бөгөөд уламжлалт эдийн засагт ийм өндөр түвшний татвар байгаагүй тул малын хорогдол үндсэндээ өрхийн хэрэглээнээс бүрдэж байв.

Өрхийн хэрэглээ гэж өрх өөрийн өмчийн малаас авч ашиглаж буй бүтээгдэхүүний нийлбэрийг ойлгоно. Дундаж өрхийн нэг жилийн хэрэглээг идэшний мал, сүү, түүхий эд гэсэн гурван ашиг шимээр бүрдүүлдэг. Идшэнд мал хэрэглэснээр өмчилдөг малын нийт тооноос хасагдах бол сүү, ноос зэрэг ашиг шимийг хэрэглэснээр малын тооноос хасагдахгүй. *Өрхийн хэрэглээ* нь өрхийн гишүүдийн тоон дээр үндэслэдэг. И.Майскийгийн тооцоолсноор 1918 оны байдлаар нэг монгол өрх дунджаар 4.3 хүнтэй.²¹ А.Д.Симуковын тооцоолсноор 1930-аад онд хөдөөний нэг өрх дунджаар 3.7 хүнтэй байв²². Түүнээс хойш малчин өрхийн ам бүлийн тоо байнга буурсан бөгөөд 2024 оны байдлаар Монгол улсад 195.8 мянган малчин өрхөд 308,746 малчин байсан бөгөөд нэг өрхөд 1.6 хүн ногдож байна.²³ Энэ нь өрхийн томоохон хэсэг болох сургуулийн насны хүүхдүүд болон өндөр настнууд ихэнх нь сумын төв дээр суурин амьдрах болсонтой, нөгөөтэйгүүр малчдын тоог 16 нас хүрсэн хүмүүсээр авах болсонтой холбоотой юм. Малчин өрхийн ам бүлийн тоо янз бүр байж болох ч дунджаар авч үзвэл Монголын уламжлалт нийгэмд нэг малчин өрх 3-5 хүнтэй байв.

Нэг малчин өрхийн 3-5 хүний нэг жилийн шүүс, идээ, гэр сууц, хувцасны хэрэглээ, зарцуулах материалын хэмжээ уламжлалт нийгэмд нийтлэг, адил төстэй шинжтэй төдийгүй нэг өрхийн нэг жилд хэрэглэх идэшний малын тоо нь өмчилдөг малын тооноос үл хамааран харьцангуй тогтмол байв. Мэдээж олон мал бүхий чинээлэг өрхүүд үүнээс олон малыг зарцуулж байсан боловч зарцуулсан малын дотроос идэшний малын тоо нь бусад бүлгийнхэнтэй ойролцоо байв.

Нэг малчин өрхийн 4-5 хүн нэг жилийн хугацаанд мал аж ахуйд ажиллахад сүү татарсан хүйтний улиралд өөрийн ба бусдын өмчийн малаас тодорхой тооны мал идэх зайлшгүй шаардлагатай байдаг. Өрхийн хэрэглээний дотроос мал аж ахуй эрхлэхэд гардаг малын зайлшгүй зарлага буюу идэшний малыг тусгайлан авч үзэх нь зүйтэй. Өрхийн зарлага нь хөрөнгө чинээний байдлаас хамаарч харилцан адилгүй бөгөөд малчин өрх малчин хэвээр оршин тогтнохын тулд жил бүр малаасаа зарцуулдаг хамгийн бага зарлагыг малын зайлшгүй зарлага гэнэ. И.Майский монгол малчин өрхийн төсвийн зарлагыг судлахдаа малын зайлшгүй

¹⁹ Улсын албан журмын бэлтгэл нь албадлагын шинж чанартай байсан талаар дэлгэрэнгүйг Н.Алтантөгс, Анхдугаар таван жилийн төлөвлөөний жилүүд дэх малчдын ядуурал ба улсын бэлтгэл, *Historia Mongolarum*, XIII, Fasc. 6, 119-139-р талд үз.

²⁰ МУҮТА. Ф-8, Д-2, ХН-658. т.95

²¹ И.Майский, *Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр)*, Улаанбаатар, 2005, 36-р тал.

²² А.Д. Симуков, *Труды о Монголии и для Монголии*, Том 1, Осака: Государственный музей этнологии, 2007. 242-р тал.

²³ Үндэсний статистикийн хорооны цахим хуудас, www.1212.mn . 2025.11.23.

зарлагыг 12 хонь, 1 үхэр, 1 адуу идшэнд хэрэглэж буй хэмээн тооцжээ.²⁴ Үүнийг хонин толгойд шилжүүлвэл 24 болох юм. Тэгвэл 1951 онд Улсын төлөвлөгөөний комиссын судалгаагаар нэг өрх дунджаар 12 малыг идшэнд хэрэглэдэг гэж үзэж байв.²⁵ Үүнийг 1 үхэр, 1 адуу, 10 хонь гэж үзээд хонин толгойд шилжүүлвэл 22 орчим хонин толгой болох юм.

Малчин өрхийн идэшний малыг хонин толгойгоор дундажлан тооцож гаргахын тулд 1950, 2015, 2024 онуудын статистик мэдээлэлд үндэслэн дараах хүснэгтийг боловсруулав. Үүнд малчин өрхийн тоо гэдэгт мал бүхий өрхийг хамруулаагүй, идшэнд хэрэглэсэн малын тоонд бусад зүйлд зарцуулсан мал багтаагүй, мөн хонин толгойд шилжүүлэхдээ адуу 7, үхэр 5, тэмээ 9, ямаа 0.9 хоньтой тэнцдэг уламжлалт баримжааг авч ашиглав.

Нэг малчин өрхийн мал аж ахуйн суурь зарлага буюу идэшний малын тоо

	1950	2015**	2024 он
Малчин өрхийн тоо, мянга	210.0*	216.7	195.7
Өрхийн идшэнд хэрэглэсэн малын тоо, мянган толгойгоор	3011.3	3287	3224.6
Адуу, мянга	186.8	93.2	128.3
Үхэр, мянга	205.1	179.2	234.1
Тэмээ, мянга	39.2	8.4	10.5
Хонь, мянга	1636.6	1522.6	1629.7
Ямаа, мянга	743.3	1483.6	1222.0
Мянган хонин толгойгоор	4982	4481.84	4892.6
Нэг өрхийн идэшний хэрэглээ, хонин толгойгоор	23.7	20.7	24.9

Эх сурвалж: ҮСХ, Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга, 2024.
<https://www.nso.mn/uploads/1762921380671-Agriculture%202024%20report.pdf> ;
 МУҮТА. Ф-8, Д-2, ХН-658. 95-101-р хуудас.

* 1952 онд 210 орчим мянган ардын аж ахуйтан байсныг 1950 оны малчин өрхийн тоонд дүйцүүлэн авав.

** Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар, Хөдөө аж ахуйн салбар 2015, Улаанбаатар, 2016.

Холбоос: https://www.nso.mn/uploads/0g0aWgNWI0irv7OOt9uROo1lRo0f9wagpR6cPl_.pdf . 2025.12.09.

Дээрх хүснэгтээс үзэхэд сүүлийн 70 орчим жилд нэг малчин өрх 20-25 хонин толгойтой тэнцэх малыг хүнсэндээ зарцуулж байгаа нь И.Майскийгийн 1918 оны тооцоо, Улсын төлөвлөгөөний комиссын 1951 оны тооцоог тус тус баталж байна. Иймээс бид нэг монгол малчин өрхийн нэг жил хүнсэндээ зайлшгүй хэрэглэх мал

²⁴ И.Майский, *Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр)*, Улаанбаатар, 2005, 166-р тал.

²⁵ МУҮТА. Ф-8, Д-2, ХН-658. т.103-104

буюу Монголын уламжлалт мал аж ахуйн нэг жилийн малын зайлшгүй зарлага 20-25 хонин толгой байсан гэж үзнэ.

Малчин өрх бие даан оршин тогтнож, үргэлжлүүлэн мал аж ахуйгаа хөтлөн явуулахын тулд малын зайлшгүй зарлагаас цөөнгүй төл бойжуулдаг байх ёстой. Бид өмнө тооцоолсон малын 25 хувийн бохир өсөлт ба 20-25 хонин толгой малын зайлшгүй зарлагад тулгуурлан нэг малчин өрх бие даан оршин тогтнохын тулд өөрт өмчлөх ёстой малын хамгийн бага тоог тодорхойлж.

А.Д.Симуков 1930-аад оны эхэн үед хийсэн судалгаандаа тулгуурлан Монголын хангайн бүсийн малчин нэг өрх бие даан аж ахуй эрхлэхийн тулд хамгийн багадаа 10-12 үхэр, мөн 40-50 хонь, 6-10 ямаа, 5-6 адуутай байх ёстой гэж үзжээ.²⁶ Үүнийг хонин толгойд шилжүүлвэл, 160 орчим болох юм. Тэрээр энэ тооцоог малын ашиг шим дээр тулгуурлан тооцсон бөгөөд харин жил тутамд идшэнд зарлагад мал болон шинээр бойжуулдаг төлийн тоонд тулгуурлан үзвэл арай өөр тоо гарах юм.

1960-1990 онд БНМАУ-д оршин байсан сум-нэгдлийн тогтолцооны үед хувийн малыг өсгөхгүй хязгаарлахын тулд нэгдлийн нэг малчин өрхийн хувийн өмчид байх малыг хангай газарт 50 толгой мал, говийн бүсэд 75 толгой малаар хязгаарлаж байсан нь хувийн малын зайлшгүй зарлагын хэмжээг ашиглан хувийн малын жилийн өсөлтийг өрхийн зайлшгүй зарлагатай нь ойролцоо байлгах арга байв. Энэхүү хангайн бүсийн хязгаарлалт 50 толгой малыг хонь 25, ямаа 10, адуу 3, үхэр 12 гэсэн харьцаагаар хонин толгойд шилжүүлвэл 115 орчим, говийн бүсийн хязгаарлалт 75 толгой малыг хонь 45, ямаа 10, адуу 6, үхэр 12, тэмээ 2 хэмээн үзэхэд 174 орчим хонин толгой мал болох юм.

Малчин өрх ган, зудгүй хэвийн нөхцөлд, татварын уламжлалт орчинд нэг жилийн хугацаанд малын зайлшгүй зарлага ойролцоогоор 20-25 хонин толгой мал байх ба үүнийг нөхөхийн тулд жил бүр 20-25-аас доошгүй төл бойжуулдаг байх ёстой. Хонин толгойгоор 20-25 төл нь нийт сүргийн дунджаар 25 хувь байх тул ойролцоогоор 80-100-гаас доошгүй хонин толгой малтай нөхцөлд малчин өрх бие даан орших боломжтой байна. Иймээс нэг малчин өрх жил тутмын малын зайлшгүй зарлага нөхөхийн тулд хамгийн багадаа 80-100 хонин толгой малтай байх ажээ. 100 хонин толгой малыг хангайн бүсэд зонхилдог дөрвөн зүйлийн малд жишээ болгон хуваавал, 40 хонь (40 хонин толгой), 10 ямаа (9 хонин толгой), 3 адуу (21 хонин толгой), 6 үхэр (30 хонин толгой), нийт хонь, ямаа, адуу, үхэр дөрвөн зүйлийн 59 толгой мал юм.²⁷

²⁶ А.Д. Симуков, *Труды о Монголии и для Монголии*, Том 1, Осака: Государственный музей этнологии, 2007. 298-р тал.

²⁷ 1 тэмээ 9 хоньтой, 1 адуу 7 хоньтой, 1 үхэр 5 хоньтой, 1 ямаа 0.9 хоньтой тэнцэнэ. https://mongoltoli.mn/search.php?opt=1&ug_id=164941 2025.12.08.

Малчин өрхийн дангаар орших чадвар, хонин толгойгоор

Малын тоо	Нэмэгдэх төлийн тоо	Малын зайлшгүй зарлага	Зөрүү	Нэг өрхөөр аж ахуй эрхлэх чадвар	Өсөн нэмэгдэх боломж	Ган, зудын эрсдэл
100-аас бага	25-аас бага	25	0-ээс бага	Чадваргүй	Хорогдох	Эрсдэл даахгүй
100	25	25	0	Чадваргүй	Тогтворгүй өсөх	Эрсдэл даахгүй
100-600	25-150	25	+1-ээс +125	Чадвартай	Алгуур өсөх	Эрсдэл даах
600-1200	150-300	25	+125-аас +275	Тохиромжгүй	Хурдацтай өсөх	Эрсдэл даахгүй
1200-аас дээш	300-аас дээш	25	+275-аас дээш	Тохиромжгүй	Хурдацтай өсөх	Эрсдэл даахгүй

Малчин өрхийн өмч мал сүрэг нь хонин толгойгоор 100-гаас цөөн байх нөхцөлд мал аж ахуй эрхлэхэд шаардлагатай малын зайлшгүй зарлагыг тухайн өрх өөрийн төлөөр нөхөж чадахгүй, энэ утгаараа эдийн засгийн хувьд бие даан оршин тогтнох чадваргүй байна. Үүнийг ядуу малчин өрх гэж үзнэ. Ядуу малчин өрх нь ганц гэрээр бие даан аж төрөх чадваргүй бөгөөд ганцаар аж төрвөл жил бүр малаа идшэнд хэрэглэсээр үгүйрэх болно.

Малчин өрхийн өмч мал сүрэг нь хонин толгойгоор 80-100 орчим байх нөхцөлд тухайн малчин өрх хэсэг хугацаанд малын зайлшгүй зарлагаа шинэ төлөөр нөхөх замаар оршин тогтнож чадах боловч байгалийн эрсдэл ба татварын ачааллыг даах чадваргүй бөгөөд татвар өсөх, хөнгөн зуд тохиох зэрэг анхны эрсдлээр оршин тогтнох чадвараа алдаж, малын зайлшгүй зарлага нь шинэ төлийн тооноос давна. Үүнийг тогтворгүй малчин өрх гэж үзнэ. Тогтворгүй малчин өрх нь хэвийн нөхцөлд ганц гэрээр амьдрах чадвартай боловч эрсдэлд мэдрэг, мөн илүүдэл бүтээгдэхүүн гаргаж чадахгүй тул бодит байдал дээр бие даан дангаар орших чадваргүй.

Малчин өрхийн өмч мал сүрэг нь хонин толгойгоор 100-гаас олон бол тухайн өрхийн аж ахуй нь татвар нэмэгдэх, ган, зудыг туулах зэргээр бага болон дунд зэргийн эрсдлийг туулах чадвартай байх бөгөөд зуд, дайны нөхцлөөс бусад хэвийн үед малын залшгүй зарлагаас давсан илүүдэл бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Үүнийг тогтвортой малчин өрх гэж үзнэ.

Тогтвортой малчин өрхийг малын өсөлтийн хурдацаар нь хоёр хуваана. Нэгдүгээрт, нэг малчин өрхийн маллаж чадах малын дээд хэмжээн дотор буюу ойролцоогоор 100-600 хүртэлх хонин толгой малтай нөхцөлд тухайн малчин өрхийн мал сүрэг алгуур өсч, дунд зэргийн эрсдлийг даах чадвартай байх бөгөөд ганц гэрээр амьдрах буюу эсхүл өөрсдийн аж ахуйн бага хэмжээний илүүдэл бүтээгдэхүүнд тулгуурлан ядуу малчин өрхтэй нэг хот болон амьдарна.

Хоёрдугаарт, нэг малчин өрхийн маллаж чадах боломжит дээд хэмжээ буюу 600 толгойгоос илүү малтай малчин өрх чинээлэг ангилалд хамаарах ба мал сүрэг

нь хурдацтай өсч, нэг малчин өрхийн 3-5 хүний ажиллах хүч хангалтгүй болж эхлэх тул бие даан ганц гэрээр амьдрахад тохиромжгүй байна.

Ажиллах хүч, өвөлжөөний даацаас хоёр буюу түүнээс олон дахин хэтэрсэн мал бүхий малчин өрхийг баян өрх гэх ба баян өрх бүх малаа нэг хотонд маллах боломжгүй тул зүйлээр нь тусгайлан сүрэглэж, сүрэгчин хөлсөлж, улмаар *мал аж ахуйн хэд, хэдэн хотод* тулгуурласан *сүргийн аж ахуй* үүснэ. *Сүргийн аж ахуйн* хамгийн хөгжингүй хэлбэр бол хааны *ордны аж ахуй* юм. Сонирхолтой нь, энэхүү *сүргийн аж ахуйг* XX зуунд социалистууд сэргээн хэрэглэж байв. 1960-1990 оны хооронд БНМАУ-д оршин байсан *сум-нэгдлийн тогтолцооны* үед нэгдлийн өмчит малыг тодорхой тоогоор, нэг төрлөөр сүрэглэн “суурь” гэдэг зохион байгуулалтаар, хөлсний малчин хариуцан маллаж байлаа.²⁸ Энэ бол социалистуудын зохиосон шинэ зохион байгуулалт биш, харин Монголын уламжлалт эдийн засагт уламжилж ирсэн ноёд, баячуудын *сүргийн аж ахуй* хөтлөх зохион байгуулалтыг социалист өмчийн харилцааны нөхцөлд нэрийг нь өөрчлөн хэрэглэсэн явдал юм.

Малчин өрхүүд ийнхүү өмчилж буй мал сүргийн тоо болон бие даан орших чадвараар 100-гаас цөөн хонин толгой малтай, бие даан орших чадваргүй ядуу, 100-600 хонин толгой малтай, бие даан орших чадвартай дундаж, 600-гаас олон хонин толгой малтай, бие даан орших чадваргүй баян гэсэн ялгаатай бүлэгт хуваагдах ба эдгээр бүлгийн ихэнх нь аж ахуйгаа бие даан ганц өрхөөр, зөвхөн өөрийн өмчийн мал сүрэгт тулгуурлан хөтлөн явуулахад тохиромжгүй. 100-600 хонин толгой малтай малчин өрхүүд дангаар орших чадвар харьцангуй сайн байх бол 100-аас цөөн буюу эсхүл 600-аас олон хонин толгой малтай өрхүүд дангаар орших чадвар бага юм. 100-аас цөөн хонин толгой малтай өрх малын зайлшгүй зарлагыг нөхөн үйлдвэрлэж чадахгүй тул дан өөрийн өмчийн малаар сүрэг байгуулан оршин тогтнох чадваргүй. Харин 600-аас олон хонин толгой малтай өрх нь дан өөрийн өмч малаар ганц өрхөөр амьдарсан нөхцөлд тухайн өрхийн ажиллах хүч хүрэлцэхгүй, бэлчээрийн даац хэтэрч, улмаар эрсдэлд өртөмтгий, ганц өрхөөр оршин тогтноход тохиромжгүй болдог.

Монгол малчид улирлын зөрүүг гарган нэг жилд хэдэнтээ нүүдэллэдэг. Өрх нүүдэллэхэд хөсөг шаардлагатай боловч ядуу өрхүүд ихэнх нь хөсөг дутагдалтай буюу огт хөсөггүй байх явдал байх тул *мал аж ахуйн хотод* нэгдсэнээр уналга хөсөггүй ядуу өрхүүд хоттойгоо цуг нүүдэллэх боломжтой болно. Энэ нь нүүдлийн технологио хамтран ашиглаж буй шийдэл байв.

Нэг малчин өрх нэг жилд дунджаар 300 хувин сүү малаасаа сааж хэрэглэдэг нь дулааны улирлын үндсэн хүнс болдог бөгөөд²⁹ чинээлэг ба баян малчин

²⁸ Сум-нэгдлийн тухай дэлгэрэнгүйг Н.Алтантөгс нар, *Сум-нэгдлийн тогтолцоо: малчин өрх, нэгдэл, улс*, Улаанбаатар: Соёмбо принтинг, 2023; Н.Алтантөгс, П.Дэлгэржаргал, БНМАУ-ын сум-нэгдлийн тогтолцоо, *Historia Mongolarum*, Том. XX, Fasc. 1, 5-18-р тал. <https://journal.num.edu.mn/HistMon/article/view/5583/4744>; Altantugs, N., & Delgerjargal, P. (2025). Sum-Negdel: Administrative and Cooperative System in the Mongolian People's Republic. *Inner Asia*, 27(2), 190-209. <https://doi.org/10.1163/22105018-12342722> -д үз.

²⁹ И.Майский, *Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр)*, Улаанбаатар, 2005, 166-р тал.

өрхүүдэд өөрсдөө хэрэглэж дуусахааргүй илүүдэл сүүн бүтээгдэхүүн үүсдэг. Тэдгээр чинээлэг ба баян өрхүүд энэхүү хэрэгцээнээс илүү гарсан сүүн бүтээгдэхүүн дээрээ тулгуурлан үгээгүй ба ядуу малчин өрхтэй *мал аж ахуйн хот* болох замаар дутагдаж буй ажиллах хүчийг нэмэгдүүлдэг.

Иймээс Монголын янз бүрийн бүлгийн малчин өрхүүдийн бие даан оршиход тохиромжгүй энэ байдал нь *мал аж ахуйн хот* хэмээх өөрийн өвөрмөц зохион байгуулалтыг үүсгэжээ.

Хөдөлмөр хэмнэх эрмэлзэл

Монголын уламжлалт мал аж ахуйн ажиллах хүч нь дэлхийн бусад уламжлалт эдийн засгуудын адил өрхүүдээс бүрдэж байв. Ихэнх малчин өрхүүд насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүн, мөн хүүхдүүдээс бүрдэнэ. Адуу маллах, тээвэрлэх зэрэг биеийн хүч шаардсан ажлуудыг насанд хүрсэн эрэгтэй хүн, сааль эрхлэх ажлыг насанд хүрсэн эмэгтэй хүн, төл маллах ажлыг хүүхэд тус тус хийнэ.

Мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалт нэг хүний хөдөлмөрт бус, хамтын хөдөлмөрт, өрх хоорондын хамтын ажиллагаанд үндэслэнэ. Хонин сүргийг өдөр, өдрөөр ээлжлэн нэг өдөрт нэг хүн хариулж, хишиг өдөр хэмээнэ. Хонины хишигтэй хүн тэр өдөртөө хүндлэгдэж, идээ, шүүсийг илүү хүртэнэ. Уламжлалт мал аж ахуйн бүтээгдэхүүний өртгийг бүрдүүлдэг үндсэн зүйл бол мал маллахад зарцуулах хөдөлмөр буюу ажиллах хүч бөгөөд хүн/өдөр гэсэн нэгжээр хэмжихэд тохиромжтой. Нэг хонь хариулах, 500 хонь хариулах нь ижилхэн 1 хүн/өдөр гэсэн хэмжээний хөдөлмөр зарцуулна. Нэг хотонд байх өрхийн тоо олон байх тусам нэг өрхөөс хонь маллах хөдөлмөрийг хэмнэдэг. Нэг хотонд байх хонины тоо олон байх тусам хонь маллах хөдөлмөрийг мөн адил хэмнэнэ. Холимог өмчит сүргийг өдөр, шөнийн нөхцөлд халуун, хүйтний улирлаар нэг өдөрт бэлчээрт нэг хүн хариулдаг байдлаар үр ашигтай зохион байгуулах үйл ажиллагаа нь *мал аж ахуйн хотын үүсэл* юм.

Өрхүүд *мал аж ахуйн хотод* нэгдсэнээр хөдөлмөрийг хэрхэн хэмнэдгийг дараах хувилбаруудаар тооцож үзье. Өрхийн нэрсийг зохиомлоор оруулав.

Хувилбар	Мал аж ахуйн хотын ахлагч	Өрх	Өрхийн ам бүлийн тоо	Хотын хүн амын тоо	Хотын сүргийн тоо, х.т.	Малын зайлшгүй зарлагын нийлбэр, х.т.	Хөдөлмөр зарцуулалт, хүн/өдөр
1	Балдан	Балдан	4	4	600	25	365
2	Дорж	Дорж	5	5	100	25	365
3	Галуут	Галуут	3	3	5	25	365
4	Балдан	Балдан	4	7	605	50	182
		Галуут	3				182
5	Дорж	Дорж	5	8	105	50	182
		Галуут	3				182

6	Балдан	Балдан	4	9	700	50	182
		Дорж	5				182
7	Балдан	Балдан	4	12	705	75	122
		Дорж	5				122
		Галуут	3				122

Дээрх тооцооллоос үзэхэд 2, 3-р хувилбар буюу 100 х.т. малтай Дорж, 5 х.т. малтай Галуут нарын ганц өрхөөр үүсгэсэн хотууд, 5-р хувилбар буюу Доржийн ахалж, Дорж, Галуут нарын хоёр өрхөөс бүрдсэн 105 х.т. малтай хот малын зайлшгүй зарлагаа нөхөж чадахгүй тул орших боломжгүй байна. 1-р хувилбар буюу Балдан 600 х.т. малтай ганц өрхөөр хот болон орших боломжтой боловч тэгсэн нөхцөлд Балдангийн өрх зөвхөн хонь хариулахад 365 хоног зарцуулах тул мөн л тохиромжгүй хувилбар юм. Харин 4-р хувилбар буюу Балдан ахлагчтай Балдан, Галуут нарын хоёр өрх нэг хот, 6-р хувилбар буюу Балдан ахлагчтай Балдан, Дорж нарын хоёр өрх нэг хот, 7-р хувилбар буюу Балдан ахлагчтай Балдан, Дорж, Галуут гурван өрх нэг хот болсон гурван нөхцөлд мал аж ахуйн хот нь малын зайлшгүй зарлагаа хангаж чадахаас гадна нэг жилийн хугацаанд нэг өрхөөс хонь хариулахад хамгийн бага буюу 182-122 хүн/өдөр зарцуулахаар байна. Ялангуяа 7-р хувилбар нь 5 малтай нэн ядуу Галуутын өрхөд ч, 100 малтай Доржид ч, 600 малтай Балданд ч хамгийн ашигтай хувилбар юм. Галуут нэг жилд 122 өдөр хонинд явж, дулааны улиралд Балдангийн өмчийн малын сүүн бүтээгдэхүүний илүүдэл хэсгийг хэрэглэж, хүйтний улиралд өөрсийн өмчийн 5 малыг идшэнд хэрэглэлгүй Балдангаас идэшний мал авч хэрэглэнэ. Балдан жилийн 365 хоногийн 122 хоногийг хонинд зарцуулж, үлдсэн хоногуудад малаа Дорж, Галуут нараар маллуулж, оронд нь малын ашиг шимийн илүүдлээсээ хоёр өрхийг хангаж, жил тутам 150 орчмоор өсөх сүргээсээ Дорж, Галуутад дутагдах идэшний малыг зохих хэмжээгээр өгч тусална. Ингэснээр өрх тус бүр 243 хүн/өдөр хэмнэх бөгөөд энэ 243 хүн/өдрийг хөлсөөр ажил хийх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, жин тээх, ан гөрөө хийх, худалдаа хийх зэрэг өөр бусад салбарт зарцуулах боломж бүрдэнэ. Иймээс Монголын уламжлалт мал аж ахуйд нэг хотонд аль болох олон өрх, аль болох олон хонийг нэг дор сүрэглэн хамтран амьдрах эрмэлзэл оршиж иржээ. Гэвч энэ нь нөгөө талаас *мал аж ахуйн нэг хот* оршин буй тухайн бэлчээрийн даацаар хязгаарлагдаж байв. Энэхүү *мал аж ахуйн нэг хотонд* байх малын доод, дээд тоогоор хязгаарлагдсан бүтцийг *сүргийн байгуулал* гэнэ.

Сүргийн байгуулал

Монголчууд малыг нэг хоёроор маллахгүй, харин малын зүйл тус бүрээр биологийн шинж чанарт нь тулгуурлан зориуд ухамсартайгаар байгуулсан *сүрэг* дээр тулгуурлан маллана. Амьтны *сүрэг* гэж нэг зүйлийн амьтад бүлэглэн амьдрах үзэгдлийг хэлнэ. *Сүрэг* дотоод бүтэцтэй, нэг буюу хэд хэдэн альфа бодгальтай, байгалийн нөөцийг цуг хэрэглэдэг, хоорондоо мэдээлэл дамжуулах

аргатай байна. Хонин сүрэг хонь, ямаа гэсэн хоёр зүйлийн малаас, харин адуу, үхэр, тэмээн сүрэг нь зөвхөн тухайн зүйлийн малаас бүрдэж, таван зүйлийн малаар дөрвөн төрлийн сүрэг үүснэ. Улаанбаатар хотоос орон нутгийг зорин гараад бид адуу, үхэр, хонь бэлчиж буйг сонирхон ажиглахдаа эн тэргүүн малыг биш, харин *сүргийн байгууллыг* олж хардаг. *Сүргийн байгуулал* нь улирлын эрс тэс цаг уурын нөхцөлд байгалийн ба биологийн хүчин зүйлд тулгуурлан гэршүүлсэн амьтны зүйлийг хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр ашигтай адуулах зорилготой уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалт юм.

Сүрэг нь нэг буюу хэд хэдэн өмчлөгчийн малаас бүрдэх боловч эцсийн өмчлөгч нь *сүргийг* хариулдаг байх албагүй. Өөрөөр хэлбэл *сүрэг* олон өмчлөгчийн малаас бүрдсэн холимог төлөвт оршдог. Нэг *сүрэг* дэх мал зөвхөн нэг өрхийн өмчөөс бүрдсэн нөхцөлд хүртэл өрхийн өмч нь дотроо задран гишүүдийн өмчөөс бүрддэг бөгөөд нөхрийн, эхнэрийн, хүүхдүүд тус бүрийн зүсэлж өмчилсөн малыг агуулдаг. Нэг *сүргийг* хариулж буй малчин хүн тухайн *сүрэгт* буй өөрийн өмчийн малыг илүү анхаарч хариулах боломжгүй, харин өөрийн ба бусдын мал багтсан нэг *сүргийг* л хариулдаг. Иймээс мал өрхийн өмч боловч тэдгээр мал нэгдэн бий болж буй нэг *сүрэг* нь өмчийн хувьд холимог шинжийг агуулна. Ноёны адуучин ноёны адуун *сүрэгт* хувийн ганц гүүгээ багтаан адуулна. Говийн ганц айлын тэмээн *сүрэгт* хамгийн багадаа бусдын нэг тэмээ багтан *сүрэглэнэ*. Иймээс Монголын уламжлалт өмчийн бодит амьдрал дээрх зохион байгуулалт ямагт холимог шинжийг агуулж, тодорхой нэг холимог өмчийн *сүрэг* нь мал аж ахуйн тодорхой нэг *хотод* харьяалагддаг. Ингэснээр цөөн малтай өрхүүдийн өмчилдөг мал *мал аж ахуйн нэг хотын сүргийн* нэг хэсгийг бүрдүүлэх бол баян өрхүүдийн өмчилдөг мал хэд хэдэн *мал аж ахуйн хот* дамжин тарж байршина. Хувийн өмчид биш, олон өмчлөгчтэй *сүрэгт* тулгуурлах, аливаа *сүрэг* нь *мал аж ахуйн нэг хотод* харьяалагдах явдал нь Монголын уламжлалт мал аж ахуйн эдийн засгийн байгууллын чухал онцлог юм.

Иймээс Монголын уламжлалт эдийн засгийн байгууллыг судлахад өрхийн малын тооноос гадна нэг *хотонд* байх *сүрэг* тус бүрийн тоо, түүний хамгийн бага болон хамгийн их хэмжээг тодорхойлох явдал зайлшгүй шаардагдана. Ингэснээр бид *мал аж ахуйн хот* оршин тогтнодог эдийн засгийн ба биологийн нөхцөлийг хамтад нь ойлгоно.

Мал аж ахуйн хотын сүргийн тоо толгойн хэмжээ нь *өрхийн* малын тооноос ялгаатай ойлголт юм. Малчин өрхийн малын тоо нь малын зайлшгүй зарлага ба төлийн тооны зохист харьцаанаас дээш хязгааргүй байж болох бол мал аж ахуйн нэг хотын *сүргийн* хэмжээ нь хөдөлмөр зохион байгуулалтаас шалтгаалсан *хамгийн бага утга* болон байгалийн нөөцөөр хязгаарлагдсан *хамгийн их утга* гэсэн хоёр хязгаартайгаараа ялгаатай.

Өрх ба мал аж ахуйн хотын малын хэмжээ, хөдөлмөр зарцуулалтын харьцуулалт

	Өрх	Мал аж ахуйн хот
Малын хамгийн бага хэмжээ, хонин толгой	100	100
Малын хамгийн их хэмжээ, хонин толгой	Хязгааргүй	1200
Зарцуулах хөдөлмөрийн хэмжээ, хүн/өдөр	365	183-аас бага

Малыг *сүрээглэх* хамгийн бага хэмжээ нь өрхийн малын хамгийн бага тоотой адил юм. Энгийнээр бол, хонин толгойгоор 100-600 малтай малчин өрх ганц өрхтэй мал аж ахуйн хот үүсгэн нутаглах боломжтой. Гэвч ийм нөхцөлд тухайн өрх уналгаар гачигдах, байгалийн эрсдэлд өртөх, хоёр дахин их хөдөлмөр зарцуулах зэрэг сөрөг талыг даван туулах шаардлагатай болдог. Иймээс ганц гэрээр мал аж ахуй эрхлэх нь говийн бүсээс бусад бүсэд ховор байв.

Мал аж ахуйн хот үүсэх эдийн засгийн нөхцөлд тулгуурлан нэг *хотын сүргийн* хамгийн бага хэмжээг авч үзье. Ингэхдээ үгээгүй өрх, хонин толгойгоор 50 малтай ядуу өрх, 200 малтай дундаж өрх, 500 малтай чинээлэг өрх, 3000 малтай баян өрх гэсэн таван өрхөөс хоёр өрхтэй хот айл үүсэх хувилбар тус бүрийн *сүргийн хэмжээ* ямар байхыг доорх хүснэгтэд харуулав.

Хоёр өрхөөс бүрдэх мал аж ахуйн хотын сүргийн хамгийн бага хэмжээ, хонин толгойгоор

	Үгээгүй өрх	Ядуу өрх	Дундаж өрх	Чинээлэг өрх	Баян өрх
Үгээгүй өрх (0)	0	50	200	500	3000
Ядуу өрх (50)	50	100	250	550	3050
Дундаж өрх (200)	200	250	400	700	3200
Чинээлэг өрх (500)	500	550	700	1000	3500
Баян өрх (3000)	3000	3050	3200	3500	6000

Хоёр өрхтэй хотын нэг жилийн малын зайлшгүй зарлага 50 хонин толгой болно. Иймээс *мал аж ахуйн хот* хэлбэрээр хөдөлмөр хэмнэхийн тулд хотын сүргийн хэмжээ нь хамгийн багадаа 400 хонь байна. Иймээс үгээгүй өрх, ядуу өрх, дундаж өрхүүд хот айл болон хамт амьдрах нөхцөлд хотын сүргийн тоо 400 хонь хүрэхгүй тул эдийн засгийн нөхцөлгүй бөгөөд энэ тоонд хүрэхийн тулд хот нь нэг чинээлэг буюу баян өрхөөр толгойлуулсан нэг үгээгүй буюу ядуу өрх гэсэн багадаа хоёр өрхөөс бүрдэх ажээ. Харин дундаж өрх нь бидний авч үзэж буй жишээн дээр 400 хоньтой тул харьцангуй бие даасан байдлаар мал аж ахуйн хотод оролцоно.

Мал аж ахуйн хотыг бүрдүүлэгч өрхүүд ижилхэн 100-гаас цөөн малтай ядуу өрх, эсхүл ижилхэн 600-гаас олон малтай баян буюу чинээлэг өрх байх нөхцөлд аль аль өрхөд ашиггүй бөгөөд ижил түвшний өрхүүд цугтаа хот айл болон хамт нутаглах эдийн засгийн шалтгаан байхгүй. Харин нэг талаас бие даан орших чадваргүй ядуу өрх, эсхүл 100 орчим малтай эрсдэл давах чадваргүй дундаж өрх,

нөгөө талаас 600-гаас дээш мал бүхий чинээлэг буюу баян өрхүүд нэг мал аж ахуйн хотод нэгдэн амьдрах эдийн засгийн зайлшгүй шаардлага оршдог. Иймээс хотыг бүрдүүлэгч өрхүүд хөрөнгө чинээгээр харилцан адилгүй байж, чинээлэг буюу баян өрхийн 600-гаас дээш мал, ядуу буюу дундаж өрхийн 100 хүртэлх мал нэгдэн *хотны сүрэг* болж, үүнээс улбаалан *нэг хотны сүрэг* хонин толгойгоор 400 буюу түүнээс дээш байх болно.

Тэгвэл хотын сүргийн хамгийн их хэмжээ хязгааргүй байж болохуйц харагдана. Дээрх хүснэгтээс үзэхэд хотын хувилбаруудаас хөдөлмөрийг хамгийн их хэмнэх хувилбар нь тус бүртээ 3000 хонин толгой мал бүхий хоёр баян өрх хамтран хот болж, 6000 хонин толгой бүхий нэг хотны томоохон *сүрэг* үүсгэх явдал байна. Гэвч Монголын уламжлалт эдийн засагт ийм том *сүрэг* байсангүй. 2013 онд А.Камимурагийн судалгаагаар хот айлын нэг өрхийн мал 402-595 хонин толгой, харин нэг хот айлын сүргийн нийт тоо 556-1086 хонин толгой байна.³⁰ Мөн түүнчлэн бэлчээрийн даац, *өвөлжөөний* багтаамж нь сүргийн тоо толгойн дээд хэмжээг хязгаарлан тогтоодог. Иймээс 3000 хонин толгой малтай хоёр баян өрх нэгдсэн нөхцөлд 6000 хонин толгой сүрэгтэй нэг *мал аж ахуйн хот* биш, харин тус бүр 1200 хонин толгой сүрэгтэй, янз бүрийн хөрөнгө чинээтэй өрхүүдийг хамтатгасан хамгийн багадаа таван тусдаа *мал аж ахуйн хот* үүсгэх болно.

Иймээс *хот* бол ямар нэгэн сайн дураар хөдөлмөрөө хоршсон төрөл садан, найз нөхдийн холбоо биш, харин малын зайлшгүй зарлага, хөдөлмөр хэмнэх зүй тогтол, нүүдэллэх унаа хөсөг, мал аж ахуйн илүүдэл бүтээгдэхүүн, бэлчээрийн даац дээр суурилсан, хөрөнгө чинээгээр ялгаатай малчин өрхүүд маш тодорхой зорилгын дор нэгдсэн эдийн засгийн зохион байгуулалт юм. Энэ зохион байгуулалтын үндсэн шинж нь малын зайлшгүй зарлагаа нөхөх чадвартай байх, хөдөлмөр зарцуулалтыг хамгийн бага түвшинд байлгах, хөрөнгө чинээгээр ялгаатай өрхүүд харилцан дутуугаа нөхөх, сүргийн тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах гэсэн хоорондоо зөрчилтэй эдийн засгийн ашиг сонирхлуудын уулзвар юм.

Монголын уламжлалт нийгмийн зохион байгуулалтын хамгийн бага нэгж, мал сүргийг өмчлөгч субъект нь *өрх* боловч үйлдвэрлэлийг зохион байгуулах үндсэн нэгж нь *өрх* биш, харин *мал аж ахуйн хот* байв. *Мал аж ахуйн хот* ба *сүргийн байгуулал* нь газар, түүнийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцаанаас хамааран оршиж байдаг тул бид *мал аж ахуйн хот* ба *сүргийн байгууллаас* газартай үүсгэдэг харилцааг авч үзэх ёстой.

ГАЗАР УУ, НУТАГ УУ? НУТАГ – ТҮҮХЭН ОЙЛГОЛТ БОЛОХ НЬ

Монголын уламжлалт аж ахуй эрхлэгч малчид ихэвчлэн Хангай, Хэнтийн уулс, Орхон, Туул, Онон, Хэрлэн дөрвөн голын ай саваар нягтран төвлөрч, харин дорнодын хээр тал, Их нууруудын хотгор, говийн бүс нутгаар сийрэг нутаглана.

³⁰ Kamimura, A. (2013). Pastoral Mobility and Pastureland Possession in Mongolia. In: Yamamura, N., Fujita, N., Maekawa, A. (eds) *The Mongolian Ecosystem Network. Ecological Research Monographs*. Springer, Tokyo. https://doi.org/10.1007/978-4-431-54052-6_14

Монголын малын тоо толгой, малчин өрхийн хүн амын тоо түүхийн ихэнх хугацаанд ямар нэгэн хэмжээнд баригдаж байсан бөгөөд судлаачдын таамаглаж буйгаар өнөөгийн монгол газарт амьдарч ирсэн малчдын тоо түүхэндээ 1 саяас хэтэрч байсангүй. 20-р зуунд малчин өрхийн хүн амын тоо 600-800 мянган хооронд хэлбэлзэж байсан бол 21-р зуунд ч энэ тоо хэвээр байна. Монгол улсад 1992-2024 онд малчин өрхийн тоо 145-195 мянга, харин 16-аас дээш настай малчин иргэдийн тоо 280-360 мянга, түүнд хүүхдийг оруулвал 600-800 мянган хооронд хэлбэлзэж байна.³¹ Энэ бол нийт нутаг дэвсгэртэй харьцуулахад мал аж ахуй эрхлэх боломжтой *нутаг* хязгаарлагдмал хэмжээтэй байдагтай холбоотой юм. Энэ зүйлд бид Монголын уламжлалт эдийн засгийн тулгуур ойлголт *газар* ба *нутаг* хоёрын ялгааг тодорхойлж, нутаг хэмээх ухагдахууны түүхэн үндсийг хөндөнө.

Нутаг хэмээх үгийг монгол хэлний их тайлбар тольд 1. Төрж өссөн, оршин суух газар орон, 2. Буурь, бууц хэмээн хоёр утгатай гэжээ.³² Бидний авч үзэж буй *нутаг* нь дээрх тольд дурьдсан хоёр утгын аль алинд хамаарах боловч түүний нийтлэг шинж болох газартай холбогдох талыг нягтлан үзэх болно. *Нутаг* нь бэлчээрээс илүү өргөн, газраас илүү явцуу, нутаг дэвсгэр дотор багтдаг, төрөлх нутаг буюу уугуул нутгаас одоо цагт хэрэглэгддэгээрээ ялгаатай тусдаа бие даасан ойлголт юм. *Нутгийг* зөвхөн мал аж ахуй эрхэлж буй хүмүүс дээр хэрэглэх ба Улаанбаатарт нутагтай, Сэлэнгээр нутагладаг тариачин гэх зэргээр хэрэглэдэггүй.

Монгол газар өргөн уудам боловч аж ахуйн үүднээс харвал газар бүхэн, бэлчээр бүхэн *нутаг* болж чаддаггүй. Энэ талаар газарзүйч Д.Базаргүр мал аж ахуйтай уялдуулан нилээн нарийн тодорхойлсон нь:

*Геоэкологи, биоэкологи хоёрын харилцан үйлчлэлийн экологийн цагаригийг алив амьтны экологийн зохистой нутаг гэнэ. Бэлчээрийн малын экологийн зохистой нутаг нь байгалийн олон хэв шинжээс хамаарч бэлчээрийн малын биоэкологи шаардлагыг жилийн дөрвөн улирлын туршид бүрэн хангана. Тодруулбал, бэлчээрийн малын экологийн зохист нутгийн дөрвөн улирлын бүс нутгууд нь тодорхой хугацааны давтамжаар нэг бүс нутаг нь бэлчээрийн малд эерэг нөхцөлтэй болоход нөгөө гурав нь сөрөг болох зүй тогтол ээлжлэн явагдана.*³³

Мөн түүнчлэн, Д.Гонгор *газар, дэвсгэр, нутаг* хэмээх гурван ойлголтыг тусад нь тодорхойлж,³⁴ газар ашиглагч үндсэн нэгж бол *хот айл* хэмээн үзэж байв. Тэрээр “монголчуудын газар өмчийн эрх, эзэмшил эдэлбэрийн бүхүйлэн явцыг туйлын товчоор харуулж болох нь “нутаг” (нунтуг) “нүүдэл” (нэ’үдэл)

³¹ www.1212.mn

³² <https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D0%BD%D1%83%D1%82%D0%B0%D0%B3#>

³³ Д.Базаргүр, *Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй (Монголын нүүдэлчдийн жишээгээр)*, газарзүйн ухааны докторын диссертаци, Улаанбаатар: МУШУА-ийн Газарзүйн хүрээлэн, 1996, 55-р тал.

³⁴ Гонгор, Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. 304-р тал..

хэмээх хоёрхон үг болно. Өөрөөр хэлбэл, “нутаг” хэмээн газар шороог, “нүүдэл” гэж түүнийг ашиглах арга хэлбэрийг хэлнэ. Иймээс “нутаг”, “нүүдэл” хоёр бол монголчуудын нүүдлийн амьдралын тодорхой дүр төлөв, газрын харилцааны үндсэн шинж тэмдгийг илэрхийлнэ”³⁵ гэж үзжээ.

Монголын уламжлалт нийгмийн эдийн засгийн үндэс нь *газар* мөн боловч газар нь дангаараа биш, мал сүргээр дамжиж, түүнтэй холбогдож байж үйлдвэрлэл явагдаж, материал баялаг бүтээгддэг онцлогтой. Өөрөөр хэлбэл, *газар* нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн эдэлбэр (бэлчээр, ус, өвөлжөө, хаваржаа) болж байж эдийн засгийн үндэс, үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл болдог ажээ. Монгол хэлэнд чухам энэ шинжийг *нутаг* гэж заадаг бөгөөд энэхүү үгээр *хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг* илэрхийлнэ. *Газар* бүхэн *нутаг* байх албагүй, суурин газар бол *нутаг* биш, зөвхөн малчдын аж төрөн сууж буй тэр газрыг л *нутаг* гэнэ. Энэ утгаараа хот суурин, тариан талбай, ойн сан, эсхүл хүнгүй зэлүүд газар зэрэг газрууд *нутаг* биш юм. Монголын уламжлалт эдийн засгийн тухайд аливаа бүх *газар* дээр бус, харин мал аж ахуйн *нутаг* дээр суурилсан газрын харилцаа үүссэн бөгөөд *нутаг* ашиглахтай холбогдон үүсэх харилцааг газрын харилцаа буюу *нутаг эзэмшлийн харилцаа* гэж үзнэ.

Газар эдэлбэрийн энэ онцлог шинжийг харуулсан түүхэн баримт, мэдээ сэлтийг сурвалжаас хайн олох, үүнд анхаарал хандуулах нь бидэнд онцгой чухал хэмээн үзэж байна. Иймээс бид газар, мал, малчны харилцааг нарийн харуулсан “нутагтан”, “нутаглах”, “нутаглуулах”, “нутагчин” хэмээх хэллэгт анхаарал хандуулж, “нутаг” гэдэг ойлголтыг газраас салган тусгайлан авч үзэв.

Нутаг гэдэг ухагдахууны түүхэн байдлыг авч үзвэл эн тэргүүн МНТ-той холбогддог. Бид МНТ дахь *нутаг* хэмээх үгийн хэрэглээг шинжилж, өнөөгийнхтэй харьцуулах замаар түүний түүхэн шинжийг тодорхойлжээ.

МНТ-д *нутаг* ба *нутаг* язгуураас үүссэн үг 24 удаа гарч байна. МНТ-д тодорхой тэмдэглэгдсэн *нутаг* хэмээх үг нэгдүгээрт, аж төрөн суух газар, хоёрдугаарт, эзэмшил газар, гуравдугаарт гэрийн буурь гэсэн гурван утга агуулагдаж байна.

Нутаг – аж төрөн суух газар

Зүйлийн дугаар	Өгүүлбэр	Үг	Үгийн утга
118	temüjin jamuqa qoyar amaralduyun niken hon nökö'e hon-u jarim amaralduju tere aqsan nuntug-ača niken üdür newüye ke'eldüjü jun-nu teri'ün sara-yin harban jirgo'an-a hula'an tergel üdür newüba temüjin jamuqa qoyar qamtu terged-ün urida yavuju ayisurun jamuqa ügülerün temüjin anda anda a'ula siqan bawuya adu'učin bidan'u alačuq-a gürtügei qol-tur siqan bawuya qoni<n>çit quriqaçit bidan-u qo'olai-a gürtügei ke'eba	Байсан нутаг	Оршин суух газар

³⁵ Гонгор, Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. т. 235.

219	...sorqan-sira čila'un čimbai kö'üd-iyer-iyen bolun ügülerün soyurqa'asu nuntu[q] darqalasu merkid-ün qajar selengge-yi nuntuqlaju darqalasu basa busu soyurqal činggis-qahan medetügei ke'eba te'ün-tür činggis-qahan ügülerün merkid-ün qajar selengge-yi nuntuqlaju nuntuq ba darqalatqun-gü uruq-un uruq-a gürtel qorčila'ulju ötökle'üljü darqalatqun	Нутаг дархлах Нутаглах	Нутаг дэвсгэр олгох Оршин суух
234	qorčin turqa'ud-un nuntuq ji'arun yisün-te'e бүкidei-tan qorčin alčidai ögöle aqutai-tan turqa'ut ordo-yin bara'un ete'et yabutuqai ke'eba	Хорчин, турхагуудын нутаг заах	Ордны баруун этгээдэд явах
242	...da'ritai gereyit-lu'a bolulčaba ke'en nidün'ü ečine ečitgeya ke'ebesü bo'orču muqali sigi-qutuqu qurban ügülerün ö'er-ün qal-iyen sönö'egü metü ö'er-ün ger-i'e[n] ebdegü metü sayin ečige-yin činu geri'es qaqča abaqa činu qočorču amu ker tebčigü inu ese uqaqšan-tur бүтүгеи sayin ečige-yin činu nilqa nuntuq hūni butaragulčaju atuqai ke'ekdejü qabar-ača hūni qangsitala qaqas kelelekdejü je deli ke'en sayin ečige-yi setkižü bo'orču muqali sigi-qutuqu qurban-u kelen-tür amurliba-je	Нялх нутаг	Есүхэй баатрын багын нутаг

Эх сурвалж: Rachewiltz, I., *Index to The Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972.

Хүснэгтэд буй түүврээс үзэхэд “тэр байсан нутгаас”, “буусан нутагт”, “Турхагуудын нутаг зааруун”, “нялх нутаг” гэсэн үгс аж төрөн суух газар гэсэн утгатай байна.

Нутаг – эзэмшил газар

Зүйлийн дугаар	Өгүүлбэр	Үг	Үгийн утга
65	nu'un kö'üt manu nuntuq qarayu ökin kö'ün manu öngge üjekdeyü	Нутаг харах	Нутаг дэвсгэр сахих
207	činggis-qahan qorči-da ügülerün... qorči medejü erdiš qudus hoi-yin irgen-tür gürtel nuntuq darqalan nuntuglaju hoi-yin irgen-i daru'ulun qorči tümen medetügei ke'en jarliq bolba	Нутаг дархлах Нутаглах	Нутаг дэвсгэр олгох Оршин суух
255	činggis-qahan jarliq bolurun qolba'aratala ya'un bui ötötgen eke a'ui bui müret usut olon bui salqu sitü nuntuq a'utkin qari daru'ulun salqaya ke'e'et	Нутаг агуутгах	Нутаг дэвсгэр тэлэх
279	...basa ulus irgen-e nuntuq usu qubiyaju ögüye nuntuq nuntu[q]la'ulqui-a minqat minqad-ača nuntu'učin ilqaju qarqa'asu bolqu-yu basa čöl qajar-a görö'esün-eče busu ülü amui irgen-e a'ui-a saqut čanai ui'urtai qoyar nuntu'učin-i teri'ülejü čöl-ün qudu'ut eri'üljü qasituqai	Нутаг ус	Нутаг дэвсгэр

219	...sorqan-sira čila'un čimbai kö'üd-iyer-iyen bolun ügülerün soyurqa'asu nuntu[q] darqalasu merkid-ün qajar selengge-yi nuntuqlaju darqalasu basa busu soyurqal činggis-qahan medetügei ke'eba te'ün-tür činggis-qahan ügülerün merkid-ün qajar selengge-yi nuntuqlaju nuntuq ba darqalatqun-gü uruq-un uruq-a gürtel qorčila'ulju ötökle'üljü darqalatqun	Нутаг дархлах Нутаглах	Нутаг дэвсгэр олгох Оршин суух
-----	---	---------------------------	-----------------------------------

Эх сурвалж: Rachewiltz, I., *Index to The Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972.

Түүвэрт эзэмшил газар гэсэн утгатай “нуган хөвүүд маань нутаг харьюу”, “нутаг дархлан”, “нутаг дархалсу”, “нутгаа дархлагтун”, “нутаг агуутган” гэсэн үгс байна.

Нутаг – гэрийн буурь

Зүйлийн дугаар	Өгүүлбэр	Үг	Үгийн утга
72	arqa-ča eden-i ekes kö'üd-i nuntug-tur gejü newütkün	Нутагт гээх	Гэрийн буурь
74	tayiči'ut aqa de'ü hö'elün-üjin-ni belbisün-ni kö'üt ücüget ekes kö'üd-i nuntuq-tur gejü newükdejü	Нутагт гээх	Гэрийн буурь
114	uduyit-merkit dürberün buluqan maqalaitu maral-un qodun qudusutu ilkin jarqaq usun-u buluqun jalqaqsan de'eltü tabun nasutu kücü neretü nidün-dür-iyen qaltu kö'üken-i bidan-u čeri'üt nuntuq-tur qočoruqsan-i olju avčiraју hö'elün-eke-de sauqa abču otču ökba	Нутагт хоцрох	Гэрийн буурь
119	...tayiči'ut-un besüd-ün nuntuq-tur niken ücügen kökөcü neretü kö'ün-i nuntuq-tur qočoruqsan-i bidan-u'ai abu'at irejü hö'elün-eke-de ökba	Нутагт хоцрох	Гэрийн буурь
135	tatar-un qorqalaqsan naratu-sitü'en-e bawuqsan nuntuq-tur talaqui-tur niken ücügen kö'üken-i ge[k] sen-i bidan-u čeri'üt nuntuq-ača olju'ui	Буусан нутагт талах	Гэрийн буурь
137	јürkin-ü nuntuq-ača boro'ul neretü ücügen kö'üken-i abčiraју hö'elün-eke-de a'ulčan ökba	Нутаг	Гэрийн буурь
138	hö'elün-eke mer[ki]d-ün nuntuq-ača oldaqsan gücü neretü kö'üken-i tayiči'ud-un dotora besüd-ün nuntuq-ača oldaqsan kökөcü neretü kö'üken-i tatar-un nuntuq-ača oldaqsan sigiken-qutuqu neretü kö'üken-i јürkin-ü nuntuq-ača oldaqsan boro'ul neretü kö'üken-i ede dörben-i ger dotora teji'erün hö'elün eke kö'üt-te'en üdur üjegü-yin nidün söni sonosqu-yin čikin ken-e bolqaqu-yu ke'en ger dotora teji'eba	Нутгаас олодох	Гэрийн буурь

149	...tarqutai-kiriltuq yeke dawu-'ar de'ü-ner kö'üd-iyen qailaju kelelerün sirgü'etü namayi alan buyu alan bara'asu üküksen amin ügei beye minu abçu otçu yeki'üjei ta namayi ala'ai üdü'üi-e öter qaritqun temüjin namayi ülü alaqu temüjin-i ücügen çaq-tur nidün-dür-iyen qaltu ni'ur-dur-iyen geretü büle'e ke'en ejen ügei nuntuq-tur qoçorçu amui ke'en abura otçu abçiraju surqa'asu surqu metü buyu	Нутагт хоцрох	Гэрийн буурь
214	kököcü ta dörben-ni irgen-ü nuntuq-aça köser-eçe olju köl-dür-iyen dürüjü kö'üçilen asaraju	Нутгаас олох	Гэрийн буурь

Эх сурвалж: Rachewiltz, I., *Index to The Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972.

Гэрийн буурь гэсэн утгатай “нутагт гэж”, “нутагт хоцорсныг”, “нутгаас олжухуй”, “Жүрхиний нутгаас”, “нутгаас олдсон”, “нутагт хоцорч”, “нутгаас хөсрөөс олж” гэсэн үгс байна.

Нутагтан

Зүйлийн дугаар	Өгүүлбэр	Үг	Үгийн утга
249	...gücü ögürün nunji nuntuqtan nödüksen balaqasutan bui-je	Нунж нутагтан	Тангудыг суурьшмал нутагтайг заасан
265	...nödüksen balaqasutan nunji nuntuqtan bui nödüksen balaqasu-ban ü'ürçü ülü otqun tede nunji nuntug-iyen gejü ülü otqun tede ...aşa gambu ügülerün da'aringqu üges bi ügülelü'e edö'e ber bö'esü ta mongqol qatquldu'a surçu qatquldusu ke'e'esü bi bürün alaşai nuntuqtu terme gertü teme'en açi'atu buyu alaşai joriju nadur iretkün tende qatqulduya	Нунж нутагтан Нунж нутаг Алшаа нутаг	

Эх сурвалж: Rachewiltz, I., *Index to The Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972.

Нутаг гэдгээс үүссэн *нутагтан* гэсэн нэр үг МНТ-д “нунж нутагтан” хэмээн хоёр удаа гарч байгаа ба зөвхөн Тангуд хүмүүсийг зааж байгаа нь “нунж” тэмдэг нэрээр илэрхийлсэн газарт аж төрдөг хүн, оршин суудаг хүн гэсэн хэлбэртэй ба суурин аж төрдөг гэсэн утгатай. *Нутагтан* гэдэг үгийг МНТ-д *эсгий туургатны* тухайд хэрэглээгүй.

Нутаглах

Зүйлийн дугаар	Өгүүлбэр	Үг	Үгийн утга
1	Cinggis-qahan-nu huja'ur De'ere tenggeri-eče jaza'atu töreksen börte-čino aju'u gergei inu qo'ai-maral aji'ai tenggis ketüljü ireba onan-müren-nü teri'ün-e burqan-qaldun-na nuntuqlaju töreksen batačiqan aju'u	Нутаглах	Оршин суух
89	tende neyileldjü otču burqan-qaldun-u ebür-e gürelgü ditora senggür-qoroqan-u qara-žirügen-ü kökō-na'ur nuntuqlaju aqiu-tur tarbaqat küčügür alaju iden büle'e	Нутаглаж ахуй	Оршин суух
96	senggür-qoroqan-ača newüjü kelüren-müren-ü teri'ün bürgi-ergi-de nuntuqlan bawuju čotan eke- yin sitkül ke'en qara buluqan daqu abčiraju büle'e	Нутаглан буух	Оршин суух
207	činggis-qahan qorči-da ügülerün... qorči medejü erdiš qudus hoi-yin irgen-tür gürtele nuntug darqalan nuntuqlaju hoi-yin irgen-i daru'ulun qorči tümen medetügei ke'en jarliq bolba	Нутаглах	Оршин суух
219	...sorqan-sira čila'un čimbai kö'üd-iyer-iyen bolun ügülerün soyurqa'asu nuntu[q] darqalasu merkid-ün qajar selengge-yi nuntuqlaju darqalasu basa busu soyurqal činggis-qahan medetügei ke'eba te'ün-tür činggis-qahan ügülerün merkid-ün qajar selengge- yi nuntuqlaju nuntuq ba darqalatqun-gü uruq-un uruq-a gürtele qorčila'ulju ötökle'üljü darqalatqun	Нутаглах	Оршин суух
278	...kebte'ül-eče nuntu'učin yabuju ordo bawultuqai e'üten ča'ada kebte'ül e'üdečin bayituqai ...ede jirin kesi'üt ordo-yin jewün ete'et nuntuqlaju kesik orotuqai ...ede jirin kesi'üt ordo-yin bara'un ete'et nuntuqlaju kesik orotuqai ke'eba	Нутаглах	Хишигтний байршил
278	...kebte'ül-eče nuntu'učin yabuju ordo bawultuqai e'üten ča'ada kebte'ül e'üdečin bayituqai ...ede jirin kesi'üt ordo-yin jewün ete'et nuntuqlaju kesik orotuqai ...ede jirin kesi'üt ordo-yin bara'un ete'et nuntuqlaju kesik orotuqai ke'eba	Нутаглах	Хишигтний байршил

Эх сурвалж: Rachewiltz, I., *Index to The Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972.

Нутаглах хэмээх үйл үг МНТ-д үндсэн гурван утгатай байна. Үүнд:

Нэгдүгээрт, МНТ-д Бөрт чоно тэнгис гэтэлж ирээд Онон мөрний тэргүүнээ Бурхан халдун уулнаа *нутаглаж* буй, мөн түүнчлэн “Сэлэнгийг нутаглаж” хэмээн *нутаг дэвсгэр* заасан нь байнга амьдрах газар болгосон утга агуулж байна. *Нутаглах* хэмээх үг өнөөдөр ч энэ утгаар, дөрвөн улирлын байршлыг хамтатгасан газар гэсэн утгаар хэрэглэгддэг билээ.

Хоёрдугаарт, “Хар зүрхний Хөх нуурт нутаглаж ахуйд”, “Бүрги эрэгт нутаглан бууж”, “Ордын зүүн этгээдэд нутаглаж”, “Ордын баруун этгээдэд нутаглаж” хэмээн бичсэнээс үзэхэд “нутаглах” хэмээх үг тодорхой нэг улирлын шинжтэй байршлыг зааж байна.

Гуравдугаарт, ноёны эзэмшил нутаг дэвсгэр гэсэн утгатай байна.

Ер нь орчин цагийн монгол хэлэнд ч монгол хүн Улаанбаатар зэрэг төв суурин газарт амьдрах, оршин суухыг *нутаглах* гэдэггүй, энэ нь зөвхөн малчдын тухайд хэрэглэгддэг. МНТ-д Бөрт чоныг Бурхан халдунаа *нутагласан* хэмээн бичсэн ба Бөрт чоно тодорхой нэг газарт “нутаглаж” буй учраас түүний үндсэн аж ахуй МНТ-ны зохиогчийн үеийнхээс ялгаагүй мал аж ахуй байжээ.

Нутаглуулах

Зүйлийн дугаар	Өгүүлбэр	Үг	Үгийн утга
279	...jūk jüg-ün minqat minqad-ača ge'üt qarqaju sa'a'at sa'ari<n>čintan-i adu'ula'at nuntu[q]čitan-i orosin tölet qarqaju unuqučin boltuqai ...basa ulus irgen-e nuntuq usu qubiyaju ögüye nuntuq nuntu[q]la'ulqui-a minqat minqad-ača nuntu'učin ilqaju qarqa'asu bolqu-yu basa čöl qajar-a görö'esün-eče busu ülü amui irgen-e a'ui-a saqut čanai ui'urtai qoyar nuntu'učin-i teri'ülejü čöl-ün qudu'ut eri'üljü qasituqai	Нутагчид Нутаг ус Нутаг нутаглуулах Нутагчныг тэргүүлэх	Мянгатын албан тушаал Нутаг дэвсгэр Нутагчид цөлд худаг хаших

Эх сурвалж: Rachewiltz, I., *Index to The Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972.

МНТ-д нэг удаа гарч буй “нутаглуулах” нь нутаглахын бусдаар үйлдүүлэх хэв бөгөөд “нутаглах”-тай утга ижил байна.

Нутагчин

Зүйлийн дугаар	Өгүүлбэр	Үг	Үгийн утга
232	kebte'ül-eče nuntu'učin yabuju ordo ger bawultuqai ke'eba	Нутагчин явах	Ордон буулгах
279	...jūk jüg-ün minqat minqad-ača ge'üt qarqaju sa'a'at sa'ari<n>čintan-i adu'ula'at nuntu[q] čitan-i orosin tölet qarqaju unuqučin boltuqai ...basa ulus irgen-e nuntuq usu qubiyaju ögüye nuntuq nuntu[q]la'ulqui-a minqat minqad-ača nuntu'učin ilqaju qarqa'asu bolqu-yu basa čöl qajar-a görö'esün-eče busu ülü amui irgen-e a'ui-a saqut čanai ui'urtai qoyar nuntu'učin-i teri'ülejü čöl-ün qudu'ut eri'üljü qasituqai	Нутагчид Нутаг ус Нутаг нутаглуулах Нутагчныг тэргүүлэх	Мянгатын албан тушаал Нутаг дэвсгэр Нутагчид цөлд худаг хаших

278	<p>...kebte'ül-eče nuntu'učin yabuju ordo bawultuqai e'üten ča'ada kebte'ül e'üdečin bayituqai ...ede jirin kesi'üt ordo-yin jewün ete'et nuntuqlaju kesik orotuqai ...ede jirin kesi'üt ordo-yin bara'un ete'et nuntuqlaju kesik orotuqai ke'eba</p>	Нутагчин Нутаглах	Ордны албан тушаалтан Хишигтний байршил
-----	--	----------------------	--

Эх сурвалж: Rachewiltz, I., *Index to The Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972.

Нутагчин хэмээх албан тушаал МНТ-ы 232, 278, 279-р зүйлүүдэд гарч байгаа нь мянгатын эзэмшил нутаг дэвсгэр, ордын нутаглах газрыг эрхлэн хөтлөгч хүнийг зааж байна.

МНТ-нд *нутагтай* холбоотой үгс олноор байх бөгөөд өнөөдөр ч монгол хэлэнд эдгээр нь утга хэвээр хэрэглэгдэж байна. Ялангуяа орчин цагийн монгол хэлэнд түгээмэл хэрэглэгддэг “нутаг ус” гэсэн хоршоо үг “нутаг ус хувааж өгье” хэмээн эзэмшил газар гэсэн утгаар хэрэглэгдэж байжээ. Мөн түүнчлэн нутаг дэвсгэр гэсэн утгыг товчоор *нутаг* хэмээн хэрэглэсэн байна.

Манжийн Дайчин улсын үеийн архивын баримтуудад *нутаг* хэмээх ойлголт өөрчлөлтгүй хэвээр хэрэглэгдэж байв. 1765 онд нэгэн хошууны засаг ноён “Тагцхүү дорд ард гэгч *нутагт* итгэж аж төрөх” хэмээн монгол хүний амьдрах үндэс нь *нутаг* болохыг тэмдэглэжээ.³⁶

Эдгээр баримт нь “нутаг” гэдэг ойлголт нутаг дэвсгэр, улирлын нутаг, гэрийн буурь гэсэн гурван утгаар Монголын уламжлалт мал аж ахуйд гүн бат, ямар нэгэн өөрчлөлтгүйгээр хамгийн наад зах нь 800 зуун жилийн турш хэрэглэгдэж ирснийг тодорхой харуулах бөгөөд ерөөс энэхүү үг мал аж ахуй, монгол хэл хоёртой хамт зэрэг үүссэн монгол хэлний эрт цагийн, уугуул ойлголт болох нь тодорхой. Товчхондоо, *нутаг* бол Монголын уламжлалт мал аж ахуйд газрыг илэрхийлэгч үндсэн ойлголт ба уламжлалт эдийн засгийн байгуулалд *нутаг* нь хувиршгүй тогтмол үүрэг гүйцэтгэж иржээ.

Малын зохион байгуулалт болох *сүрэг*, малчин өрхүүдийн зохион байгуулалт болох *мал аж ахуйн хот* гэсэн байгууллауд улсын газрын ихэнх хэсэг болох *нутаг* дээр оршин тогтнох явдал Монголын уламжлалт эдийн засгийн байгууллын үндсэн мөн чанар юм. Иймээс бид уламжлалт эдийн засгийн үндсэн байгууллыг тайлбарлахын тулд *нутгийг* хэн нэгэн эзэмшдэг эсэх, хэрэв эзэмшдэг бол *нутгийг* нийтээр эзэмшдэг үү, эсвэл тодорхой нэг бүлэг эзэмшдэг үү гэдэг асуудлыг авч үзэх ёстой. Хязгаарлагдмал нөөц дээр хүмүүсийн хооронд эдийн засгийн харилцаа үүсдэг. Газар нь хязгаарлагдмал нөөц учир түүнийг хэн нэгэн өмчилж, хэн нэгэн эзэмшиж, хэн нэгэн үйлдвэрлэлд ашиглаж, улмаар газрын түрээсийн харилцааг үүсдэг.

³⁶ *Хувьсгалын өмнөх Монгол дахь газрын харилцаа*, эмхэтгэсэн Цэ. Шархүү, Улаанбаатар: УХГ, 1975. 9-11-р тал.

Нутаг эзэмшил гэж байдаг эсэхийг тогтоохын тулд *нутаг* нь хязгаарлагдмал нөөц мөн эсэхийг тодруулах шаардлагатай. Хэрэв *нутаг* нь хязгааргүй нөөц бол түүнийг эзэмших харилцаа үүсэхгүй бөгөөд зөвхөн ямар нэгэн хязгаарлагдмал нөөцийн тухайд л түүнийг өмчлөх, эзэмших харилцаа хүмүүст үүсдэг.

Нутаг бол МНТ дахь нутаг дэвсгэр гэдэг утгаараа монголын уламжлалт эдийн засгийн байгууллын суурь, үндсэн тогтмол хүчин зүйл бөгөөд хязгаарлагдмал, солигддоггүй шинж чанартай. Монгол малчид ган, зуд тохиох зэрэг бүх нийтийг хамарсан онцгой үйл явдал гарахаас бусад нөхцөлд *нутаг* сольж нүүхгүй, мянган, отог, хошуу, сум зэрэг тодорхой нэг нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн дотор тогтвортой нутаглана. Бусад хошууны *нутагт* нутагласнаас үүссэн маргаанд занчигдаж нас барсан Сандавын хэрэг лавтайяа 18-р зуунд гэхэд хотууд бусад хошууны *нутагт* зөвшөөрөлгүй нутаглах хориотой байсныг харуулна.³⁷

Нутаг дэвсгэрийн нэгж даван нүүх нөхцөлд энэ нь энгийн улирлын нүүдэл биш, харин шилжин суурьшилт болон хувирдаг. Манжийн үед нэгэн миграцийн жишээ тэмдэглэгдэн үлдсэн нь, 1758 онд Сайн ноён, Засагт хан хоёр аймгийн *нутгийг* баруун тийш хөдөлгөн гэр харуултай нийлүүлж, суларсан *нутагт* Түшээт ханы хошуудаас нутаглуулахаар шийдвэрлэсэнд Түшээт хан, шавь нар, гүн Цэдэнсампил, Цэвдэндорж нарын дөрвөн хошуу шилжин нутаглахаар хөдөлсөн боловч бусад нь нүүж *нутаг* султгаагүй учир хүйтний цаг болж, ачилга уналгагүй ардыг орхих, хэд хэдэн хошуу өнгөртөл нүүхэд хөрөнгө малыг барах, амь зууж чадахгүй өлсөх сарнихад хүрэх эрсдэл учирчээ.³⁸ Түшээт хан аймгийн дөрвөн хошуу *нутгаа* солин шилжин суурьшихад (migration) ийнхүү харьяат ард нь сарнин бутрах, улмаар хошуу оршин тогтнох эсэхэд тулсан эрсдэлтэй учирч байгаа нь нүүдэлчдийн тухай түүхчдийн төсөөллөөс огт өөр бөгөөд малчин хүн ам газартай шууд бусаар харилцаж, харин газрын нэг хэсэг болох оршин буй *нутагтайгаа* шууд, салшгүй уялдаатай байна.

Дээр өгүүлсэн хүн, мал, *нутаг* гурвын бат бөх хамаарал нь *нутаг эзэмшил* ямар нэг байдлаар оршиж байсныг харуулна. Үүнээс хоёр асуулт урган гарна. 1. *Нутаг* бүхэлдээ хэн нэгний эзэмшил үү, аль эсхүл түүнийг хэн нэгэн хэсэгчлэн эзэмшдэг үү? 2. *Нутаг* нь газар гэдэг утгаараа төрийн өмч боловч мал аж ахуйд зориулсан эдэлбэр гэдэг утгаар нь *нутгийг* хэн эзэмшиж байсан бэ? МНТ-д гардаг Бурхан халдуны эзэн Бурхан босгосон Шинч баян урианхай нутаг эзэмшигч үү, эсвэл Шинч баян урианхай болон Бурхан халдунд нутаглагч малчид цугтаа Бурхан халдун *нутгийг* хамтран эзэмшигчид үү?

Энэ асуултыг тодруулахын тулд бид *нутгийг* дулаан ба хүйтэн улирал, өдөр ба шөнийн хэмнэл гэсэн уур амьсгалын циклүүдэд хувааж, өвөлжөө-хаваржаа ба зуслан-намаржаа нь *мал аж ахуйн хот* ба *сүрэгтэй* хэрхэн уялдахыг авч үзье. Үүний тулд уур амьсгалын циклийг товч тодорхойлно.

³⁷ *Хувьсгалын өмнөх Монгол дахь газрын харилцаа*, эмхэтгэсэн Цэ. Шархүү, Улаанбаатар: УХГ, 1975. 18-р тал.

³⁸ *Хувьсгалын өмнөх Монгол дахь газрын харилцаа*, эмхэтгэсэн Цэ. Шархүү, Улаанбаатар: УХГ, 1975. 6-р тал.

УУР АМЬСГАЛЫН ЦИКЛ: ДУЛААНЫ БА ХҮЙТНИЙ НУТАГ

Монголын газар зүйн нөхцөл, уур амьсгалын онцлог Евразийн бусад тал нутгаас хүйтэн, эрс тэс юм. Монгол улсын нутаг дэвсгэрт жилийн дундаж агаарын хэм +0.8, хүн ам, мал төвлөрсөн хангайн бүсэд -0.2 хүйтэн байдаг бол ижил өргөрөгт орших Казахстаны нутаг дэвсгэрт жилийн дундаж агаарын хэм +6.6, харьцангуй хүйтэн умард бүс нутагтаа +3.9 хэм дулаантай.³⁹ Энэхүү агаарын 3-6 хэмийн зөрүүтэй байдал нь Евразийн хээр тал нутаг дахь мал аж ахуйн ялгаатай байдлыг үүсгэж, Монголын уламжлалт эдийн засгийн байгууллын онцлогийг тодорхойлдог. Энэ онцлог харьцангуй хүйтэн, эрс тэс уур амьсгалын циклтэй холбоотой бөгөөд энэ циклүүд нь *хотын сүрэгт* тохирох *нутгийн* хэмжээг хязгаарладаг.

Уур амьсгалын хэлбэлзлийг агаарын хэмийн өөрчлөлтөд тулгуурлан жилийн цикл, хоногийн циклээр ангилна. Агаарын хэмийн жилийн өөрчлөлтийг Х.Гантөмөрийн үйлдсэн Архангай аймгийн Түвшрүүлэхийн сангийн аж ахуйгаар жишээ болгон авч үзье.

Түвшрүүлэхийн сангийн аж ахуйн жилийн дөрвөн улирлын цаг уурын онцлог үзүүлэлт

	Өвөл			Хавар		Зун			намар	
	Эхэн үе	Тэгим хүйтэн үе	Сүүлч үе	Эхэн үе	Сүүлч үе	Эхэн үе	Аагим халуун үе	Сүүлч үе	Эхэн үе	Сүүлч үе
Хэм	-5 -15	-15- аас доош	-15 -5	-5 0	0 +10	+10 +15	+15 дээш	+15 +10	+10 0	0 -5
Эхлэх, дуусах хугацаа	10-3 12-25	12-25 2-9	2-9 3-25	3-25 4-20	4-20 5-28	5-28 7-2	7-2 8-1	8-1 8-31	8-31 10-15	10-15 11-3
Үргэлжлэх хоног	50	45	45	25	35	35	30	35	45	20
Нийт үргэлжлэх хоног	140			60		100			65	
Салхины хурд, м/сек	1.3-2.0			5-10		1.4- 2.6			2-3.5	

Эх сурвалж: Х.Гантөмөр, *Монгол орны байгалийн янз бүрийн бүсэн дэх сум, САА-н бэлчээр ашиглалтын газарзүйн онцлог*, Газарзүйн ухааны дэд эрдэмтний зэрэг горилох бүтээлийн гар бичмэл, Улаанбаатар, 1984. 64-р тал.

³⁹ <https://globaldatalab.org/geos/table/surfacetempyear/KAZ+MNG/?levels=1+4&interpolation=0&extrapolation=0> . 2025.12.14.

Нутгийн уур амьсгалын жилийн циклийг эдийн засгийн үүднээс агаарын хэм, өдрийн урт, ургамлын ургалтад үндэслэн дулаан, хүйтэн хэмээн хоёр ангилна.

Д.Гонгор монголчуудын уламжлалт мал аж ахуйд өвөл хаврын болон зун намрын улирлын чанартай маллагаа, түүнд тохирсон нутаг бэлчээр чухал болох талаар “мал аж ахуйн үйл ажиллагаанд ... нэгэн он жилийн гортиг хүрээнд авч үзвэл “сэргэлт” ”бууралт”-ын хоёр чиглэл хандлагатай бөгөөд энэ нь дахин давтагдах шинжтэй ажээ. ... цаг улирлын эрхшээлээс уялдан шалтгаалсан мал аж ахуйн эергүү сөргүү дээрх хоёр хандлагыг зохицуулж өвөл хаврын “бууралт”-ын үед мал сүргийг онд мэнд оруулах, зун намрын “сэргэлт”-ийн үед аль болох сайн тарга хүч авахуулж чадал төгөлдөржүүлэхэд тэдний үйл ажиллагааны гол чиглэл орших бөгөөд үүнд “нутаг” шийдвэрлэх рольтой нь мэдээж билээ”⁴⁰ хэмээн оновчтой тодорхойлсон байдаг. Ялангуяа уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийг сэргэлтийн зун намрын улирал, бууралтын өвөл хаврын улирал гэсэн хоёр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гэсэн түүний саналыг анхаарч үзэх нь чухал юм.

Дулаан улиралд хаврын сүүл хагас, зун, намрыг тооцох бөгөөд энэ үе нь хөрсөн дээр байнгын тэгээс дээш хэмтэй, өдөр урт, ногоон буюу эсхүл хангалттай хэмжээний борог өвстэй, бэлчээрийн өвс нийт малд хүртээмжтэй, бүрэн шимтэй байна. Дулаан улирал 5-р сарын сүүлчээр эхэлж, 10-р сарын сүүлчээр төгсөж, ойролцоогоор 165 орчим хоног үргэлжлэнэ.

Хүйтэн улиралд өвөл, хаврын эхэн хагасыг тооцох бөгөөд ихэнхдээ тэгээс доош хэмтэй, өдөр богино, цасан бүрхүүлд дарагдсан борог өвстэй буюу эсхүл дөнгөж ногоо соёолсон, бэлчээрийн өвс нийт малд хүрэлцэхээргүй бага, шимт чанаргүй байна. Хүйтэн улирал 10-р сарын сүүлчээр эхэлж, 5-р сарын сүүлчээр дуусч, ойролцоогоор 200 хоног үргэлжлэнэ. Дулаан ба хүйтэн улирлын хугацаа мэдээж Монгол газрын байгалийн бүслүүр, тухайн жилийн цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалж янз бүр байх ч ерөнхий дундаж хугацаа үүнээс хол зөрөхгүй.

Мал аж ахуйн эдийн засгийн богино цикл бол хоног юм. Хоногийг өдөр, шөнө хэмээн ангилах бөгөөд үйлдвэрлэлийн ялгаатай зориулалттай. Өдөр малыг байгальд бэлчээрлүүлж услах, саах, ноослох, төхөөрөх зэрэг үйлдвэрлэлийн бүх үйл өрнөх бол шөнийн цагт адуунаас бусад малыг *хотонд* хонуулах хоёр үндсэн давтамжтай үйлдвэрлэл явуулна. Ингэснээр мал сүргийг өдрийн *бэлчээр*, шөнийн *хот* гэсэн хоёр циклээр маллана.

Уур амьсгалын нэг жилийн дулаан-хүйтэн цикл, нэг хоногийн өдөр-шөнийн цикл нь мал аж ахуйн *нутгийг* тодорхойлж, *дулааны нутаг*, *хүйтний нутаг* гэсэн жилийн хос цикл, *өдрийн бэлчээр*, *шөнийн хот* гэсэн хоногийн хос циклийг үүсгэдэг. Уур амьсгалын хэлбэлзлээс үүссэн эдгээр хоёр хос цикл нь нутаг дотор *бэлчээр* ба *хотын* хөдөлгөөнт тохируулгыг шаардана. Ийнхүү уур амьсгалын эрс тэс циклүүдээс шалтгаалж *мал аж ахуйн хот*, түүний *сүргийн нутаг* нь улсын нийт нутаг дэвсгэрийг хамрах боломж байдаггүй учир улсын нийт нутаг дэвсгэр нь *нутаг* болон *зэлүүд газар* гэж хоёр хуваагдаж байв.

⁴⁰ Д.Гонгор. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. т. 236.

Нутгийг дотор нь *бэлчээр* ба *хот* хэмээн ерөнхийлөн ангилж үзүүштэй. Мал аж ахуйн хотын *сүрэг* өдөр бэлчих тул *бэлчээр* нь хоногийн циклийн өдрийн циклд хамаарна. *Бэлчээр* нь нутгийг бүрэлдүүлэгч хэсгүүд дотроос хамгийн их судлагдсан салбар билээ. *Бэлчээр* гэдэг нь хүний оролцоогүйгээр ургасан байгалийн ургамал, ус бүхий газрыг хэлнэ. Хүний оролцоогүй учир *бэлчээр* мал аж ахуйн хамгийн бага өртөгтэй тэжээл болдог. *Бэлчээрийг* дулааны ба хүйтний хэмээн үндсэнд нь жилийн хоёр шатанд хуваана.

Малын хот гэж мал шөнө хэвтэж хонох бууц, хашаа хороо болон малчин өрхийн гэр сууц байрлаж буй нутгийн нэг байршлыг хэлнэ. *Малын хот* нь нутгийн нэг хэсэг ба уур амьсгалын цикл, бэлчээрийн даацыг харгалзсан хэд хэдэн байршилтай. *Мал аж ахуйн хот* эдгээр байршил хооронд нутаг сэлгэхийг *улирлын нүүдэл* гэдэг. *Малын хотонд* малын хэвтэр, хашаа хороо, малчдын гэр сууц оршиж, шөнө мал хэвтэж хонохоос гадна сааль эрхлэх, идэш төхөөрөх, хонь ноослох, гар урлал хийх зэрэг мал аж ахуйн ихэнх үйлдвэрлэл өрнөдөг. *Хот* нь дулааны ба хүйтэн улирлаар ялгаатай шинж чанартай.

Дулааны нутаг эзэмшил

Дулааны улиралд зун ба намрыг хамруулах ба энэ хугацаанд *бэлчээр* ногоон ургамалтай байх тул шимт чанар өндөр. Дулааны улиралд *бэлчээр хотын* нийт сүрэгт харьцангуй хүртээмжтэй байж, харин усан хангамж чухалд тооцогддог. Монгол газар усаар ховор тул томоохон гол мөрөн, булаг шандыг даган дулааны улирлын бэлчээр оршино.

Түвшрүүлэх сумаар жишээ болгоход дулаан улирал ногоо цухуйх 4-р сарын 20-ноос эхэлж, өвс хагдрах 11-р сарын 3 хүртэл дунджаар 165 хоног үргэлжлэнэ. Дулааны улирлын хотыг *зуслан*, *намаржаа* гэнэ. Дулааны улиралд хот нь ялаа шумуулгүй, сэрүүн, усанд дөхүү газарт байрлах ба гэрийн буурьгүй шинэ голдуу зүлгэн дээр буудаг.

Монголын уламжлалт эдийн засаг дулааны улиралд идэвхтэй, хөдөлгөөнтэй байдаг. МНТ-ны 70-р зүйлд хавар Амбагай хааны хатад Өрбэй, Сохатай нар Ихсийн газарт үнэр гаргаж тахилга үйлдэж, тэр үеэр тахилгаас Өэлүн хоцорч маргаан үүсгэхэд нутагт гээн нүүжээ. Нүүхдээ Өэлүний аж ахуйг бараг тэр чигт нь авч одсон байна. Тахилгын дараа нүүж буй үйл явдал нь хүйтэн улирлын төгсгөл, дулаан улирлын эхлэл, *өвөлжөөний* орчим орших *хаваржаанаас зуслан* руу хөдлөх хаврын сүүл үеийг зааж байгаа бөгөөд одоо ч ногоо ургах энэ үеэр малчид зусландаа нүүцгээдэг. Хавар Чингис хаан мөн Жамухатай анд барилдаж, Хэрэйдтэй ургийн холбоо тогтоох зэрэг үйл эрхэлж байсан нь *ордны аж ахуй* хүйтний улирлаас дулааны улиралд шилжиж, идээ, шүүс элбэгшин улс төрийн ба язгууртны хэлхээ холбоо зузаатгах харилцаа идэвхждэг байсныг харуулна. Зуны тэргүүн сарын 16-ны улаан тэргэл өдөр бол мал ногоонд цадах үе бөгөөд монголчууд энэ үеэр хэд хэдэн хэлбэрийн тахилга үйлдэж, аян дайнд мордох нь ч байв. Намрын улирал бол аян дайн, ан гөрөөний улирал юм. Дулаан улирлын

сүүлийн хагас намар цагт малчин монголчуудын агт морь таргалж, мал сүрэг тарга тэвээргээ авч гүйцэх бөгөөд нүүдлийн байдлаар *өвөлжөөний* бүс нутаг руу дөхөн намаржина. МНТ-нд намар цагт Чингис хаан Татар, Мэргид, Тангудтай байлдаж байв. Хэрэв дайн дуусахад намар орой болсон бол дайтаж эзэлсэн нутагт өвөлжинө.

Монголын уламжлалт аж ахуйд дулааны улирлын *нутаг* нь тухайн засаг захиргааны нэгжид харьяалагдах *хотууд* дунд нийтийн шинжтэй байв. Д.Базаргүрийн судалснаар, дээр үед малчид нь ихэвчлэн *зуслан*, *намаржааны* дундын *нутагтай* байж хангай, тал хээр, говийнхон тэр *нутгийг* хамтран эсвэл ээлжлэн ашигладаг уламжлалтай байсан. Жишээлбэл, Архангай аймгийн Өгийнуур сумын *нутаг* нь дээр үед засаг захиргааны таван хошууны, сүүлийн үед 6 сумдын *зуслан намаржааны нутаг* байжээ. Ийм нутаг дээр 1956 онд Өгийнуур сум байгуулсан цагаас хойш таван жил тутамд тохиолдох их, бага зудад мал нь хорогдож, сум-нэгдлийн 7 дарга арга хэмжээ авахуулж, ажлаасаа халагдаж, зарим нь шүүхэд шилжсэн байна.⁴¹

Дулаан улирлын *бэлчээрийг* нийтээрээ ашигладаг байв. Иймээс дулааны улирлын *хотын* байршил чухамдаа хязгааргүй гэж тооцож болно. Дулааны улиралд бэлчээрийн даац хүйтний улирлынхаас хавьгүй өндөр тул нэг усыг бараадсан хотууд олон арваараа “Хаяа багтахаараа бууж, хамар хатгахаараа иднэ” хэмээн хонь нийлэхээргүй зай барин ойр шахан буух нь хэвийн үзэгдэл юм. “Зуслангаар хавчигдах явдал орон нутагт хэрэв онцын их ган гачиг эс болохул бараг тохиолдохгүй ажээ”.⁴² Мөн өвөл тус тусын *өвөлжөөнд* өвөлжсөн хотууд *зусланд* цуг буун хонин сүргээ нийлүүлэн *зуслангийн хот* үүсгэх нь бий. Эсхүл цуг нэг *өвөлжөөнд* өвөлжсөн хотын өрхүүд тус тусын зусдаг *зуслан* руу салж тусдаа дулаан улирлын хот үүсгэн зусах, намаржих хэлбэр ч бий. Дулааны улиралд нүүдэл олширч, өвөлжин нүүлгүй суурьшсан малчид дулааны улиралд *нүүдэлчин* болон хувирна. Дулааны улирлын хот бол бүрэлдэхүүн, байршлын хувьд тогтворгүй, нүүдэллэгч, хувьсагч шинжтэй юм. Дулааны улирлын хот төл өсгөх, малын тарга тэвээрэг авахуулах, ногоон бэлчээрийг аль болох сэргэгээр нь, өдрийн гэгээг бүрэн ашиглаж идүүлэх, сааль эрхлэх, идээ хураах, ноослох ба эсгий хийх, хужир мараанд хүртүүлэх зэрэг олон зорилготой.

Дулаан улирлын хот нь тогтворгүй, хөдөлгөөнтэй, хүртээмжтэй, нийтийн шинж чанараараа монголын уламжлалт эдийн засгийн *нүүдэлчин* шинжийг илэрхийлдэг. Иймээс дулааны нутагт хувийн *зуслан* байгуулагддаггүй.

Хүйтний нутгийн хөдөлгөөнгүй шинж

Хүйтний улирлын *нутгийг* авч үзэх үндсэн асуудал бол *өвөлжөө* нь малчдын жилийн дөрвөн улирлын нэг буудал уу, эсвэл жилийн амьдралын циклийг зохицуулагч үндсэн байршил уу гэдгийг тодруулахад оршино.

⁴¹ Д.Базаргүр, *Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй (Монголын нүүдэлчдийн жишээгээр)*, газарзүйн ухааны докторын диссертаци, Улаанбаатар: МУШУА-ийн Газарзүйн хүрээлэн, 1996, 88-р тал.

⁴² Гонгор Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. 302-р тал.

Өвөлжөөний чухал, үндсэн үүргийг судлаачид аж ахуйн талаас нь тэмдэглэсээр ирсэн юм. Д.Гонгор “малчин хүнд нутаг усны тухай бодоход юуны өмнө өвлийг өнгөрүүлэх өвөлжөө хэмээх ухагдахуун аяндаа төрөгдөх болно” хэмээжээ.⁴³ Өвөл, хаврын бүс нутагт малчид нь хамгийн удаан сууж, байгалийн бэрхшээлтэй хүнд үеийг өнгөрөөдөг тул энэ хоёр бүс нутгийг нийлүүлэн малчдын нутагшилтын “голомт бүс нутаг” гэж нэрлэх санал зарим судлаачаас гаргаж байв.⁴⁴

Японы монгол судлаач М.Онуки “Нүд дасах тусам онгоцноос тээр доор үргэлжлэх нэл цагаан өнгөтэй нүд алдам өргөн эх газар дээр мэнгэ мэт жижиг толбо болон бүрэлзэх өвөлжөөний айлууд уулын завсар, суга, жалгаар энд тэнд тодрон харагдана. Сэтгэл зүрх догдлон хөдөлж чанга хашгирмаар санагдав. Хүн-байгалийн харилцааны явцад бий болсон хүмүүсийн гайхамшигт эр зориг, мятаршгүй гэсвэр хатуужил, оюун ухаан үр дүн нүдний өмнө дэлгэгдэнэ” хэмээн *өвөлжөөг* онцгойлон дүрсэлж байлаа.⁴⁵ Гэвч ихэнх түүхч, судлаачид монголчуудыг *нүүдэлчин* гэж үздэг учир *өвөлжөөг* тухайлан авч үзэлгүй, жилийн дөрвөн улирлын өвлийн улирлын түр буудал гэж тайлбарлаж иржээ.

Монголын уламжлалт мал аж ахуйд хүйтний улирлын *нутаг* нь дулааны улирлынхаас өөр шинж чанартай. Хүйтний улиралд бэлчээрийн ургамал шимт чанараа алдаж, борог өвс үлдэж хоцордог тул малын биологийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй. Бэлчээрийн ургамлын шимт чанар нь *өвөлжөөний* бүс нутагт тавь орчим хувь, *хаваржааны* бүс нутагт 20 орчим хувь нь хадгалагдан үлдэж, бас ургамлын шимт чанар нь 2-3 дахин, шингэх протейн 6-10 дахин, микро элемент 1-3 дахин буурдаг.⁴⁶ Иймээс хүйтний улирлын *бэлчээрийн* хүрэлцээ туйлын хязгаарлагдмал байж, улмаар мал шаардлагатай шим тэжээлээ авч чадахгүйд хүрч, энэ байдал даамжирвал мал доройтож, аж ахуйд үхэл хорогдол нүүрлэдэг.

Өвөлжөө, хаваржаа нь хүйтний улирлын *бэлчээртэй* нэг дор оршиж, *мал аж ахуйн хотын сүрэг* өдөр нь бэлчээрт, шөнө нь *өвөлжөөнд* хэвтэнэ. Хүйтний улиралд бэлчээрээс хангалттай тэжээл авч чадаагүй мал сүрэг шөнө малын хотонд хүйтэн агаар, салхины нөлөөнд хэвтдэг. Монгол газар цельсийн -15-аас доош хэмтэй үе 45 хоног үргэлжилж, энэ үед шөнөдөө -30 хэмээс илүү хүйтрэнэ. Монголын хүн, мал төвлөрсөн төвийн бүс нутагт хөрсний гадарга дээр 1-р сард -43-аас -48 хэм хүйтэн болдог.⁴⁷ Монгол газрын салхины горим нь баруун хойд зүгийн салхины давталт 54 хувь⁴⁸ буюу баруун хойд зүгийн салхи голлон

⁴³ Гонгор Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. 302-р тал.

⁴⁴ Д.Базаргүр, *Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй (Монголын нүүдэлчдийн жишээгээр)*, газарзүйн ухааны докторын диссертаци, Улаанбаатар: МУШУА-ийн Газарзүйн хүрээлэн, 1996. т. 56.

⁴⁵ М.Онуки, *Нүүдлийн мал аж ахуйн нийгмийн орчин үе*, Осака: Такацуки-Бүнкo, 1990. 10-р тал.

⁴⁶ Д.Базаргүр, *Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй (Монголын нүүдэлчдийн жишээгээр)*, газарзүйн ухааны докторын диссертаци, Улаанбаатар: МУШУА-ийн Газарзүйн хүрээлэн, 1996, 56-р тал.

⁴⁷ Х.Гантөмөр, *Монгол орны байгалийн янз бүрийн бүсэн дэх сум, САА-н бэлчээр ашиглалтын газарзүйн онцлог*, Газарзүйн ухааны дэд эрдэмтний зэрэг горилох бүтээлийн гар бичмэл, Улаанбаатар, 1984. 55-р тал.

⁴⁸ Х.Гантөмөр, *Монгол орны байгалийн янз бүрийн бүсэн дэх сум, САА-н бэлчээр ашиглалтын*

салхилдаг. Шуургатай шөнө салхины хурд 20 м/с, агаарын хэм -43 байхад хээр хонож буй малын арьсан дээр -69.9 хэм хүйтэн мэдрэгдэнэ⁴⁹. Хавар мал төллөж, нийт сүрэг тэжээлийн дутагдалд автан турах үеэр салхи 15 м/с-ээс хүчтэй болох тохиолдол нэг сард 5-7 удаа тохионо. Хавар агаарын хэм -15 байхад 20 м/с хурдтай шуурга шуурсан нөхцөлд турж эцсэн мал, дөнгөж төрсөн төлийн арьсан дээр -30 хэмийн хүйтэн мэдрэгдэнэ. Мал турсан хаврын улиралд, шөнийн хүйтэнд шуурах үеэр малын үхэл хорогдол хамгийн их үедээ хүрнэ. Хүйтний улиралд тодорхой давтамжтайгаар зуд тохиодог ба тухайн жилийнхээ дулааны улиралд ган болохтой давхцах нь түгээмэл. Одоогоор мэдэгдэж буй хамгийн эртний зуд Хүннү улсын үед тэмдэглэгджээ. Өвлийн ид хүйтнээр цас их орж цагаан зуд болох, хавар цас хайлж хөлдөн дэлхий хуяглан төмөр зуд тохиох, эсхүл огт цасгүйн улмаас өвсгүйдэн харын зуд нүүрлэх зэрэг олон төрлийн зуд бий. Зуд их тохивол оторлон нүүх боловч бүх нутгийг хамарсан зуд болвол отрын нутаг хүрэлцэхгүй болж, үй олон мал сүрэг үхэж хорогдоно.

Газрын хотгор, гүдгэр нь салхи шуурга, цаг уурын үзэгдэл, агаарын хэмийн өөрчлөлтийн нөлөөг бууруулж, үхэл хорогдлоос сэргийлнэ. Д.Базаргүрийн хийсэн судалгаанаас жишээ авахад, зөвхөн нэг жирийн уул гэхэд өвлийн цагт дөрвөн өөр нөхцөлийг агуулдаг.⁵⁰ Уул, толгод баруун хойд зүгийн салхины нөлөөг бууруулж, малын хотон дотор -70 хэмийн хүйтэн үүсэхээс хамгаална. Баруун хойноос салхилах салхины нөлөөг бууруулахын тулд малчид уул, толгодын өвөр болон зүүн талд, нар эрт тусах байршилд *өвөлжөө*, *хаваржаагаа* байгуулдаг. Иймээс *өвөлжөө* нь салхи хаах байгалийн саад, эсхүл томоохон уулын амны мухарт, нөмөрт оршдог. Мөн түүнчлэн уулархаг нутгийн сахлаг өвстэй бэлчээр нь өвөл хаврын цастай зутруу үед бэлчээрийн нөөц ихтэй байдаг учраас өвөлд уулын бэлчээр голлон ашиглагдана.⁵¹ Төв аймгийн Баян-Өнжүүл суманд хавсарга салхитай хаврын улиралд хүчтэй цасан шуурга өвөлд уул хоорондын хөндийгөөр болдог тул малчид өвөл хаврын улиралд уулын хажуу өвөр, толгодлог гадаргад нутагладаг байна.⁵² Ж.Самбуу “Хүйтэн салхины тусгал ихтэй газрын *өвөлжөө бууцанд* буудалласан айлын уур утаа нь салхинд эрс

газарзүйн онцлог, Газарзүйн ухааны дэд эрдэмтний зэрэг горилох бүтээлийн гар бичмэл, Улаанбаатар, 1984. 55-р тал.

⁴⁹ Агаарын хэм дэх салхины нөлөөллийг АНУ-ын Далай ба агаар мандлын үндэсний захиргааны цахим хуудсан дахь Wind Chill Calculator ашиглан тооцоолов. https://www.weather.gov/epz/wxcalc_windchill. 2025.11.20.

⁵⁰ Д.Базаргүр, *Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй (Монголын нүүдэлчдийн жишээгээр)*, газарзүйн ухааны докторын диссертаци, Улаанбаатар: МУШУА-ийн Газарзүйн хүрээлэн, 1996, 75-р тал.

⁵¹ Х.Гантөмөр, *Монгол орны байгалийн янз бүрийн бүсэн дэх сум, САА-н бэлчээр ашиглалтын газарзүйн онцлог*, Газарзүйн ухааны дэд эрдэмтний зэрэг горилох бүтээлийн гар бичмэл, Улаанбаатар, 1984. 157-р тал.

⁵² Х.Гантөмөр, *Монгол орны байгалийн янз бүрийн бүсэн дэх сум, САА-н бэлчээр ашиглалтын газарзүйн онцлог*, Газарзүйн ухааны дэд эрдэмтний зэрэг горилох бүтээлийн гар бичмэл, Улаанбаатар, 1984. 157-р тал.

цохигддог. Харин энгэр нөмөрлөг газрын утаа нь эгц дээш гарч байх жишээтэй” хэмээн *өвөлжөөний* нэгэн ховор онцлог шинжийг онцлон тэмдэглэж байв.⁵³

Өвөлжөө нь Монголын уламжлалт эдийн засагт *хаваржаагаа* багтаадаг байв. МНТ дээр өвөлжих, зусах гэдэг үг байгаа боловч хаваржих гэдэг үг гардаггүй. Мөн Манжийн үеийн архивын баримтуудад *хаваржаа* гэдэг үг *өвөлжөө* ба *зуслантай* харьцуулвал маш цөөн тохиолддог, харин “өвөл хаврыг өнгөрүүлдэг хуучин өвөлжөө бууц”⁵⁴ хэмээн *өвөлжөө*, *хаваржааг* хамтатган тэмдэглэх нь түгээмэл байв. Социализмын үеийн сум-нэгдлийн тогтолцооноос өмнө *өвөлжөө* нь хаваржаагаа агуулдаг, *өвөлжөөнөөс* хаваржаанд нүүдэггүй, харин ойрхон зайлж буудаг, *хаваржаа* нь бие даасан тусгай нутагт ордоггүй, өвөлжөөндөө тооцогддог байжээ. Өөрөөр хэлбэл уламжлалт эдийн засгийн үеийн ихэнх малчид дөрөв биш, харин хоёроос гурван улирлын нутагтай байв.

Өвөлжөө нь малчин өрх улирлын нутгууд дотроос нэг газраа хамгийн удаан нутаглан суух байршил юм. Архангай аймгийн Түвшрүүлэх сумын жишээг ахин харвал, өвөл 140 хоног, хавар 60 хоног, хүйтний улирал нийт 200 хоног үргэлжилж байна. Уламжлалт эдийн засаг дахь малчин өрх нэг жилийн 365 хоногоос 200 хоногийг *өвөлжөө*, түүний ойр байх *хаваржаанд* өнгөрүүлнэ. Харин дулааны улирал 165 хоног үргэлжлэх ба энэ хугацаанд хамгийн багадаа хоёр, түүнээс дээш удаа улирлын нутаг сэлгэнэ.

Өвөлжөө нь нүүлгэх боломжгүй, орхин одох л боломжтой. *Өвөлжөө* нь бууцан давхарга дээр тогтдог, газар зүйн олон хүчин зүйлийн цогц байгалийн өгөгдөл юм. Иймээс хүйтний улирлын нутаг, тэрхүү нутгийн гол цэг болох *өвөлжөө* нь шинээр бий болдоггүй, устаж алга болдоггүй. Хүйтний улиралд *өвөлжөөг* шууд дурын байршилд байгуулах нь тохиромжгүй. Хэрэв шууд хөлдүү газарт малыг хонуулвал өвлийн шөнө мал доороосоо дулаан алдаж, хайрагдана. 1785 онд холбогдох нэгэн бичигт “[тэр] миний дацангийн сүрэг хонь хадгалж суусан Гомбо лугаа айл буун түүний хонийг хөөж, хөдөө цасан дээр хонуулж хэдэн хонь үхүүлээд өөрийн хонийг түүний өтөгт хонуулсан”⁵⁵ хэмээн цасан дээр хоносноос хонь үхсэн тухай тэмдэглэжээ. Мөн *өвөлжөөнд* нь өөр малчин хүч түрэн буусны улмаас өвсөөр тасалдаж гуч гаруй тэмээ үхсэн 1883 оны жишээ бий.⁵⁶ *Өтөг* буюу *өвөлжөө бууц* нь мал шөнийн хүйтнийг өнгөрүүлэх боломжтой ганц цэг ба хээр хөдөө цасан дээр хэвтэж хоносон мал үхэж хорогдоно. Иймээс хэрэв зайлшгүй шинэ *өвөлжөө* үүсгэх шаардлага тулгарвал жилийн өмнөөс урьдчилан бэлтгэж, тодорхой давтамжтайгаар мал хэвтүүлж бууц үүсгэдэг. Д.Гонгорын тэмдэглэснээр, “өтөг хэмээн уул газрын онгон хөрсөн дээр хүний хөдөлмөрийн үр дүнд хэдэн үе давхарга тогтсон хүн мал аль нэгэн үе буюу тухайн цагт суурьшин тогтворжсон хот айлын нутаглах буурь бууцыг нэрлэж

⁵³ Ж.Самбуу, *Мал аж ахуй дээрээ яахиж ажиллах тухай ардад өгөх сануулга сургаал*, Улаанбаатар: БНМАУ-ын хэвлэл, 1945, т. 47.

⁵⁴ *Хувьсгалаас өмнөх Монгол дахь газрын харилцаа*, Улаанбаатар: УХГ, 1975. 113-р тал.

⁵⁵ *Хувьсгалаас өмнөх Монгол дахь газрын харилцаа*, Улаанбаатар: УХГ, 1975. 97-р тал.

⁵⁶ *Хувьсгалаас өмнөх Монгол дахь газрын харилцаа*, Улаанбаатар: УХГ, 1975. 196-р тал.

байжээ.”⁵⁷ Бууц нутаг нь хөрсөн дээр малын баасны өнжмөл давхарга үүссэн газрыг хэлэх бөгөөд бууцыг цэвэрлэж, үхэр, хонин сүргийг шөнө бууцтай хөрсөн дээр хэвтүүлж, ингэснээр доороос хайрагдах эрсдлийг бууруулна.

Өвөлжөөг дуртай цагтаа сэлгэж, нүүлгэх боломжгүй тул малчин өрхийн нутагладаг нутгийн доторх суурин цэг байж, улмаар дулааны улиралд байрлах нутгийн хязгаарыг *өвөлжөөнд* үндэслэн төлөвлөнө. Иймээс монгол малчин бол жилийн дөрвөн улиралд өвс, ус даган нүүдэллэн аж төрөгч *нүүдэлчин* ард түмэн биш, харин хүйтний улиралд үндсэн суурин нутаг *өвөлжөөндөө* суурин амьдарч, дулааны улиралд үндсэн байршлаа орхин *зуслан, намаржаагаар* түр нүүдэллэж, улмаар хүйтний улирлын эхээр үндсэн байршилдаа эргэн ирж нутагладаг *малчин* ард түмэн юм.

Өвөлжөө нь байгаль, цаг уурын хүчин зүйлсэд тулгуурладаг тул газарзүй, байгаль, цаг уурын нөхцөлд томоохон өөрчлөлт орохоос нааш хот айлын өвөлжихөд тохиромжтой байршил шинээр бий болдоггүй, устаж алга болдоггүй. Өөрөөр хэлбэл өнөөдөр буй удам дамжсан *өвөлжөөнүүд* ихэнх нь урьд өмнөх түүхийн турш, Монгол нутагт хүмүүс бэлчээрийн мал малласаар ирсэн цаг хугацааны турш оршсоор ирсэн гэсэн үг билээ.

Өвөлжөөний тоо хэмжээ ба даац

Өвөлжөө нь нэн хязгаарлагдмал шинжтэй, *мал аж ахуйн хот* нь өвөлжөө, хаваржаанд хүйтний улирлын турш суурин байрлах тул өвөлжөөний тоо хэмжээг багцаагаар таамагласан нөхцөлд бид нэг өвөлжөөнд ногдох өрх, малын тоог дунджаар тооцоолж болно. Харин дулааны улирлын хотын байршил хөдөлгөөнтэй, малчид салж нийлж нутаглах нь элбэг тул өвөлжөөтэй адил тоолох боломжгүй. Д.Гонгор “манай оронд хэдэн мянган хот-өтөг бууц байх нь цөм өөртөө харьцангуй хэмжээт нутгийн гол цэг болж байсан ба одоо ч түүний ул улбаа тасраагүй байна” хэмээн Монголд хэдэн мянган өвөлжөө байсан гэж таамаглажээ.⁵⁸ Бид өвөлжөөний тоо хэмжээг багцаалахын тулд ХХ зуунд өвөлжөөн дээр баригдсан саравчтай хашааны тоог ашиглана.

Уламжлалт мал аж ахуйд хотууд өвөлжөөндөө саравчгүй хашаа барих явдал байсан ба саравчтай хашаа хороо улс даяар тун цөөхөн байв. А.Д.Симуковын бүртгэснээр 1933 оны байдлаар БНМАУ-ын хэмжээнд нийт 30,159 саравчтай хашаа байсан ба үүнээс ихэнх нь Сэлэнгэд байжээ.⁵⁹

Харин ХХ зууны дунд үеэс эхлэн бараг бүх өвөлжөөнд хашаа барьжээ. Бүх төрлийн малын хашаа 1962 онд 33.8 мянга, 1970 онд 47.1 мянга, 1980 онд 60.2 мянга болон нэмэгдэж⁶⁰, сум-нэгдлийн тогтолцооны үед бүх өвөлжөөнд саравчтай

⁵⁷ Гонгор Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. 300-р тал.

⁵⁸ Гонгор Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. 298-р тал.

⁵⁹ А.Д. Симуков, *Труды о Монголии и для Монголии*, Том 1, Осака: Государственный музей этнологии, 2007. 307-р тал.

⁶⁰ https://www.1212.mn/mn/statcate/table-view/Historical%20data/Agriculture/DT_NSO_0100_01T016.px. 2025.12.09.

хашаа, бүх хаваржаанд саравчгүй хашаа байгуулснаар өнөөгийн Монгол малчдын *өвөлжөөний* дүр төрх бүрэлдэн тогтжээ. Ийнхүү саравчтай хашаа нь *өвөлжөөг*, саравчгүй хашаа нь *хаваржааг* илэрхийлдэг болов.

1990 оны байдлаар нийт 30 сая малын багтаамж бүхий 66.2 мянган малын хашаа байснаас саравчтай хашаа буюу *өвөлжөө* 63.2 хувийг (41.8 мянга), саравчгүй хашаа буюу *хаваржаа* 14.4 хувийг (9.5 мянга) тус тус эзэлж байжээ. 1990 оны байдлаар 74 мянган малчин өрх, 16-аас дээш насны 147.5 мянган малчин, 25.8 сая мал байв.⁶¹

Улмаар сүүлийн жилүүдэд механикжсан хадлангийн нөлөөгөөр шинэ газар өвөлжөө байгуулах явдал олширч, улмаар саравчтай хашааны тоо эрс өсчээ. 2015 оны байдлаар 66.8 сая малын багтаамж бүхий 209 мянган малын хашаа тоологдсоноос саравчтай хашаа буюу өвөлжөө 40.1 сая малын багтаамжтай 119.1 мянга, саравчгүй хашаа буюу хаваржаа 20.6 сая малын багтаамж бүхий 56.4 мянга тус тус тоологджээ. 2015 онд 153.1 мянган малчин өрх, 55.9 сая толгой мал байжээ.⁶² Нэг өвөлжөөнд 1.2 өрх, 469.3 толгой мал оногдож байна.

Өвөлжөөний даац

	1990	1992	2015
Нийт өрх	74.0	143.4	153.1
Нийт мал	25800	25694.1	55900
Нийт саравчтай хашаа буюу өвөлжөө	41.8	47.7	119.1
Нэг өвөлжөөнд ногдох өрх	1.77	3	1.2
Нэг өвөлжөөнд ногдох мал	617	538.6	469.3

Эх сурвалж: www.1212.mn

Дээрх хүснэгтээс үзэхэд 1990-2015 оны хооронд 25 жилд нэг өвөлжөөнд 1.2-3 өрх нутаглаж, 469-617 толгой мал буюу хонин толгойгоор ойролцоогоор 1200 орчим мал байрлаж байна.

2015 оны байдлаар Өвөрхангай аймаг 15 мянган малчин өрхтэй, эдгээр малчин өрх 10 мянган өвөлжөө, хаваржаатай байна.⁶³ Мөн онд өөр аймгийн харьяалалтай ердөө 12 малчин өрх Өвөрхангай аймгийн нутагт өвөлжөө, хаваржааны газар ашиглаж байсан нь өвөлжөө, хаваржааг бусад аймгийн харьяатад ашиглуулах явдал бараг байдаггүйг харуулах нэг жишээ юм. Өвөрхангай аймгийн нэг өвөлжөөнд 1.5 өрх өвөлжиж буй нь байгалийн бүслүүрээс шалтгаалан нэг *өвөлжөөнд* өвөлжих өрхийн тоо харилцан ялгаатай байдгийг харуулж байна. 2017-18 оны байдлаар Говь-Сүмбэр аймгийн Малахын аймаг дундын отрын бүст өвөлждөг өрхүүд нийт 16 мянган толгой малтайгаас

⁶¹ 1992 оны мал тооллого, <https://www.nso.mn/uploads/livestock1992.pdf> . 2025.12.09.

⁶² МҮСХ, *Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2024 он*, Улаанбаатар, 2025, 9, 76-р тал. <https://www.nso.mn/uploads/1762921380671-Agriculture%202024%20report.pdf> . 2025.12.09.

⁶³ Ш.Эрдэнэчимэг, *Өвөлжөө, хаваржааны газар эзэмшил, өмчлөлийн асуудлыг шийдвэрлэнэ, Монцамэ*, <https://www.montsame.mn/mn/read/6937> 2025.11.17-ны байдлаар.

хамгийн их нь 1100, хамгийн бага нь 125, дунджаар 400-600 толгой малтай байна.⁶⁴

А.Д.Симуковын судалснаар, 1930-аад онд Архангай аймгийн нэг нутагт буй өрхүүдийн дотор ганц айлаар нутагладаг айл бараг байгаагүй, харин 2-4 өрхтэй хот 31 хувь, 5-6 өрхтэй хот 36 хувь, 7-10 өрхтэй хот 31 хувийг эзэлж, ихэнх өрхүүд *хот айлаар* нутаглаж байжээ.⁶⁵ Тэрээр “хотоны” хэмээн хот айлыг онцгойлон авч үзэж, *нүүдэлчид* ба *хотууд* гэсэн хоёр ойлголтыг зэрэгцүүлэн хэрэглэж байв. Өнөө үед мал аж ахуйн хотод байх өрхийн тоо харьцангуй цөөрсөн бөгөөд А.Камимурагийн 2013 оны судалгаагаар Төв аймгийн Эрдэнэ сумын Өгөөмөр баг, Баян-Өнжүүл сумын Цээл баг, Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Хондот багуудын нэг хот айлд 1.66-2.05 өрх байв.⁶⁶ *Өвөлжөө* нь өнөө цагт 0.07 га хэмжээтэйгээр малчин өрхийн эзэмшилд очсон тул тооны хувьд 1990 оныхоос олширч, нэг өвөлжөөн дэх өрхийн тоо цөөрчээ. Харин *сум-нэгдлийн* үед өвөлжөөний тоо хамгийн ихдээ 60 мянга хүрч байв. XX зууны тухайд өвөлжөөний дундаж тоо 40-60 мянга орчимд хэлбэлзэх ба Монголын нутаг дэвсгэрт ийм тооны өвөлжөө түүхийн турш оршиж ирсэн гэж үзүүштэй. Нэг өвөлжөөнд дунджаар 2-оос дээш өрх нутаглах бол сүргийн даац 540 орчим буюу хонин толгойгоор 1200 орчим сүрэг ногддог. Өвөлжөөний тоо, өрх, сүргийн даацад тулгуурлан таамаглахад, өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэрт түүхийн турш 40-60 мянган өвөлжөөнд 80-120 мянгаас дээш 180 мянга хүртэл тооны өрх, 376-846 мянган малчин хүн ам, 21.6-32.4 сая толгой мал өвөлжиж иржээ.

ӨВӨЛЖӨӨНД СУУРИЛСАН ГАЗРЫН ХАРИЛЦАА

Өвөлжөөг хувьд эзэмших эдийн засгийн хэрэгцээ шаардлага

Өвлийг амьд мэнд давж өнгөрүүлэхийг монголчууд “онд орох” гэнэ. Онд мэнд орох тухай анхны бодит мэдээлэл МНТ-д “он гарах” гэсэн хэлбэрээр үлдэж хоцорчээ. Алунгуа эхийг үгүй болсны дараа Бодончир мунхаг өөрийн ах нарт гадуурхагдаад Ононы Балжун аралд гөрөөс авлан амь зууж өвлийг хүнд хэцүү давсныг МНТ-ны 26-р зүйлд “...өөрийн хоолноосоо харцгайгаа тэжээлдэн тэр он гарав. Хавар болж, нугад галууд ирэв” хэмээн тэмдэглэжээ. Одоо ч монгол малчид хоорондоо “Онд мэнд оров уу?” хэмээн мэндчилдэг. Иймээс өвлийг өнгөрүүлдэг, он гаргадаг өвөлжөө нь нутгийн хөдөлгөөнгүй байршил, тулгуур цэг, нутгийн үүсэл болохоос гадна он тооллын ч үүсэл болдог.

⁶⁴ Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны цахим хуудас, <https://otor.gov.mn/backend/files/z9BuSpIX9VTWmRB.pdf>. 2025.11.17.

⁶⁵ А.Д. Симуков, *Труды о Монголии и для Монголии*, Том 2, Осака: Государственный музей этнологии, 2007. 497-р тал.

⁶⁶ Kamimura, A. (2013). Pastoral Mobility and Pastureland Possession in Mongolia. In: Yamamura, N., Fujita, N., Maekawa, A. (eds) *The Mongolian Ecosystem Network. Ecological Research Monographs*. Springer, Tokyo. https://doi.org/10.1007/978-4-431-54052-6_14

Ногоо цухуйх хүртэл хугацаанд малчид байгальтай орших, эс оршихын төлөө тэмцэлдэнэ. Баруун хойд зүгээс хавсарга тавьсан хаврын хүйтэн шөнүүдийг малын хорогдолгүйгээр давж шинэ ногоотой золгох явдал бол малчны нэг жилийн амьдралын циклийн хамгийн том тэмцэл байдаг. Чухам ийм байгалийн нөхцөлд малчин хүний барих үндсэн “зэвсэг” бол хүйтний улирлын хот буюу *өвөлжөө* юм.

Эрт үед ч, өнөө үед ч, хэрэв өвөлжөөгүй *хот* байвал өвлийг давж чадахгүй, өөрөөр хэлбэл тухайн *мал аж ахуйн хот* буурч доройтон, эцэстээ мөхнө. Хүйтний нутаг нь хязгаарлагдмал, суурьшмал, тухайн аж ахуй оршин тогтнох эсэхийг шийдвэрлэдэг нутаг байна. Хүйтний нутаггүй, өвөлжөө бууцгүй *мал аж ахуйн хот* нь Монголын эрс тэс уур амьсгалтай нутаг дэвсгэр дээр цыгануудын адилаар ийш тийш нүүдэллэн тэнэх байдлаар оршин тогтнох боломжгүй.

Энэхүү байгалийн хатуу ширүүн сорилтод малчид хариулахын тулд хүйтний улирлын бэлчээрийг дулааны улиралд хэрэглэхгүй байх, бусдын сүргээс хүйтний улирлын бэлчээрээ хамгаалах зайлшгүй хэрэгцээ шаардлага үүсчээ. Тийм ч учраас *зусланг* бус, *өвөлжөөг* үе дамжин эзэмшиж, ашигладаг ба *өвөлжөө* булаацалдах явдал малчдын доторх үндсэн зөрчил байдаг. Иймээс малчин хүн *өвөлжөөгөө* үе дамжин эзэмшдэг, өвөлжөөг булаацалдан заргалддаг. Өвөрхангай аймагт өвөлжөөний *нутаг* дээр үүссэн маргааны улмаас хүн амины хэрэг гарч байжээ.⁶⁷ *Өвөлжөөг* нутаг усаараа нийтээр бус, харин тодорхой нэг *мал аж ахуйн хот* эзэмших, тухайн эзэмшлээ нутгийн захиргаагаар баталгаажуулах явдал мал аж ахуйн хотуудын оршин тогтнох зайлшгүй нөхцөл байв. Өөрөөр хэлбэл, мал аж ахуйн хот нь өөрийн эзэмшил *өвөлжөө бууцтай* байдаг ажээ.

Өвөлжөө эзэмшигч

Д.Гонгор “аливаа хот нь амьдралын явц ба хэв заншлаар баримжаалагдсан хэмжээт дэвсгэр газарт хамаарагдаж, түүний гортиг хүрээнд эргэлдэнэ. Бид чухам үүнийг нь хот айлын нутаг хэмээн нэрлэж байна. Өөрөөр хэлэхүл монголчууд газрыг хот хотоор эзэмшин эдэлбэрлэнэ. Иймээс хот нь монголын газар нутгийн ашиглалтын анхан шатны үр хөврөл болно” хэмээн уламжлалт эдийн засаг дахь газартай холбогдогч үндсэн нэгжийг мал аж ахуйн хот гэж үзсэн нь тухайн цаг үедээ шинэлэг тайлбар байв.⁶⁸

Д.Гонгор бусдын өвөлжөөнд гуйж буусан өрхийг “хавчуур айл” гэдэг талаар мэдээлж, үүндээ үндэслэн мал аж ахуйн хотууд *өвөлжөөг* эзэмших хандлагатай болсон гэж тайлбарлаж байв.⁶⁹ Гэвч тэрээр уламжлалт эдийн засгийг номадизмын үүднээс харж байсны улмаас *өвөлжөө эзэмшлийг* эртний хүйн үеийн газар эдэлбэрийн нийтийн шинжтэй ул улбааг санагдуулдаг ба газрыг хот айлын тогтолцоогоор ашиглан боловсруулах нь энгийн хоршооллын гэмээр хамтын

⁶⁷ Ш.Эрдэнэчимэг, Өвөлжөө, хаваржааны газар эзэмшил, өмчлөлийн асуудлыг шийдвэрлэнэ, *Монцамэ*, <https://www.montsame.mn/mn/read/6937> 2025.11.17-ны байдлаар.

⁶⁸ Гонгор, Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. т. 297.

⁶⁹ Гонгор Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. 301-р тал.

шинжтэй, иймээс ч хот айл нь нутаг-нүүдлийн хөршийн хүй мөн гэж үзээд өвөлжөөтэй холбогдолтой газрын харилцааны асуудлыг цааш гүнзгийрүүлэн судлалгүй орхисон юм.⁷⁰

Өвөлжөөний эзэмшигчийг тодорхойлохын тулд юуны өмнө дундад зууны монголчууд *өвөлжөөг* хувьд эзэмшдэг байсан уу гэж асуух нь зүйд нийцнэ. Бид МНТ-ны мэдээг нягтлах замаар тухайлбал Чингис хаан өөрийн тогтмол *өвөлжөө* эзэмшдэг байсан эсэхийг тодруулж болно. Эрт, дундад үеийн монголчууд өвөл, хаврыг хэрхэн өнгөрүүлж байсан талаар Монгол хүний бичсэн Монголын түүхийн сурвалжуудаас хамгийн эртнийх нь МНТ билээ. Энэ талаар МНТ-ны зохиогч бидэнд зарим тодорхой мэдээ бичиж үлдээжээ. МНТ-ы 26, 148, 151, 153, 187, 198, 265-р зүйлүүдэд он гарах, өвөлжих зэрэг өвлийг өнгөрүүлэх үйл явдал гарч буй. 26-р зүйлд Бодончир мунхаг ах, дүүгээс салж Ононы Балжун аралд өвсөн гэр барьж суугаад, чонын гуунд хоргоосон гөрөөс харваж идэх зэргээр харцагайгаа тэжээж, он гаргажээ. Тэрээр өвлийн хугацаанд төдийгүй, хавар ахыгаа өөрийг нь хайж иртэл хаа нэг тийшээ нүүгээгүй.

МНТ-д өвөлжсөн газрын нэрийг тодорхой дурьдсан дөрвөн үйл явдал байна. Үүнд, 148-р зүйлд, Чингис хаан Тайчуудыг хядаж, улс иргэнийг нь хөдөлгөн ирээд Хуба хаяад өвөлжсөн. 151-р зүйлд Чингис хаан Тоорил ханг улсаа алдаад тусламж эрж ирэхэд нь гувчуур гувчиж хүрэн дотроо оруулж тэжээн, тэр өвлөө зэргээр нүүж мөн Хуба хаяад өвөлжсөн байна. 187-р зүйлд Жүрхэн, Баатудыг дагуулан хуваагаад тэр өвөл Авжиа хөдөгэрт өвөлжжээ. 198-р зүйлд Чингис хаан мэргэдийн үлдэгдлийг нэхэж явахад өвөл болж, Алтайн өвөрт өвөлжсөнийг дурьдсан байна.

Зүйл	Утга	Үг	Өмнөх үйл явдал	Дараагийн үйл явдал
148	... Тайчуудыг ургийн ураг хүртэл үнсээр хийсгэн хядав. Улс иргэнийг нь хөдөлгөж ирж Чингис хаан Хуба хаяад өвөлжив.	Өвөлжив	Тайчуудыг дарав	Дэрсүдэд байхад Жаха хамбу нөхцөж, мэргидийг няцаав.
151	...ke'en ong-qan-a qubčiri qubčiju ökcü güre'en dotara oro'ulju teji'eba tere übül jerge-'er newüjü činggis-qahan quba-qaya-yi übüljeba	Өвөлжив	Тоорилыг хүрээндээ оруулж тэжээв	Тоорилд Хэрэйдийн эрхийг буцаан авч өгөв.
187	čisutu tonog abuqči jirgin-ba'atud-i jisüjü qubiyaju gürgeldün yadaba kereyit irge tedüi qoru'aju tere übüл abji'a-ködeger-i übüljeba	Өвөлжив	Жүрхэн, Баатудыг жишин хуваасан	-

⁷⁰ Гонгор Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978. 303, 306-р тал.

198	toqto'a qudu čila'un kō'üd-iyer-iyen čö'en beyes dayijju qaruqsan-i činggis-qahan nekeju altai- yin ebür-e übüļjeju hüker jil qabur arai-iyar dabaju odu'asu...	Өвөлжиж	Мэргэдийн үлдэгдлийг нэхэж байв.	Хавар нь Мэргидийн үлдэгдлийг үргэлжлүүлэн нэхэхээр Арайгаар давав.
-----	---	----------------	--	--

Эх сурвалж: Rachewiltz, I., *Index to The Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972.

МНТ-д “өвөлжих” гэдэг үйл үг ямар нэгэн дайн тулаантай холбоотой гарч байгаа нөхцөлд Хуба хаяа, Абжиа хөдэгэр, Алтайн өвөр хэмээн өвөлжсөн газрын нэрийг шууд заасан бөгөөд энэ жилүүд нь Тайчуудыг дарсан, дүүгээсээ зугатаж ирсэн Тоорил ханг хүрээндээ оруулж тэжээсэн, Жүрхэн, Баатудыг дарсан, Мэргэдийн үлдэгдлийг нэхсэн дайны үйл явдлууд байна. Хуба хаяа нь Тайчуудын ноёдын өвөлжөө, харин Абжиа хөдэгэр нь Жүрхэн, Баатудын ноёдын өвөлжөө болов уу. Харин Алтайн өвөр нь цэргүүдийн хамт тархан өвөлжсөн бүс нутгийг заах ба аян дайны үеэр өвөл болоход Чингис хаан дайсныг мөрдөн хөөхөө завсарлан хөдөлгөөнгүй өвөлжиж байжээ. Намрын сүүл, өвлийн эхээр дайн дуусмагц Чингис хаан шинэ дагуулж авсан улсын нутаг дэвсгэр дотор орших өвөлжөөнд өвөлжиж буй буюу эсхүл хэрэв он дамнасан холын аян дайн бол өвөл болмогц цэрэгтэйгээ суурин өвөлжөөд хавар дайныг үргэлжлүүлж байна. Эдгээрээс үзэхэд Хуба хаяа, Абжиа Хөдэгэр, Алтайн өвөр гэсэн энэ гурван байршил нь лавтайяа Чингис хааны өөрийн өвөлжөө биш юм. МНТ-ны зохиогч Чингис хааны дайн байлдааны улмаас бусад газарт өвөлжсөн үйл явдлыг онцгой ховор үйл явдал болгон газрын нэрийг цохон дурьдаж байна.

Чингис хааны нэр нь тодорхойгүй газарт өнгөрүүлсэн хэд хэдэн өвлийг МНТ-ны зохиогч мэдээлжээ. 153-р зүйлд нэр тодорхойгүй газарт өвөл өвөлжиж, хавар, зуныг өнгөрөөгөөд нохой жилийн намар Чингис хаан татар лугаа байлдан ялжээ. 177-р зүйлд өвөл мөн нэр тодорхойгүй газарт өвөлжиж байтал Ван хан тусламж гуйж ирсэнд хүрээндээ оруулж тэжээгээд, хойтон намар нь Мэргидтэй байлджээ. 265-р зүйлд нэр тодорхойгүй газарт өвөлжиж, хойтон намар нь Тангудын аян дайнд морджээ.

Зүйл	Утга	Улирал	Өмнөх үйл явдал	Дараах үйл явдал
26	идэхүй идээн үгүй арун. Чонын гуунд хоргоосон гөрөөс мярааж харваж алж идэлдээд чонын идсэнийг тэмгэлдэж идээд өөрийн хоолдоон харцгайгаан тэжээлдэн тэр он гарав.	Он гарав	Урагт эс тооцогдон одож Онон уруудаж Балжун арал хүрэв.	Хавар болж, нугас галуу ирэв.
153	Тэр өвөл өвөлжиж нохой жил намар нь Чингис хаан Цагаан татар, Алчи татар, Дутаут татар, Алухай татар тэд Татарт Далан нөмөргөс байлдаж хаггалдохуйн урьд Чингис хаан засаг өгүүлэлдрүүн...	Өвөлжиж	Хэрэйдийн хямрал	Нохой жилийн намар Татартай байлдав.
177	...тэр өвөл чамайг хүрээн дотор оруулж тэжээв зэ. Өвөл өвөлжиж зусаж намар нь Мэргид иргэний Тогта бэхид морилж Хадиглиг нурууны Мөрүцэ сэгүй хаггалдаж Тогта бэхийг Баргужин төхөм зүг үлдэж	Өвөлжиж	Тоорилыг хүрээндээ оруулж тэжээсэн	Намар нь Мэргидтэй байлдав.
265	Тэр өвөл өвөлжиж Тангуд иргэд морилё хэмээн шинэ тоо тоолж нохой жил намар Чингис хаан Тангуд иргэнд морилон... Зуур өвөл Арбухын олон хуладыг авлаваас...	Өвөлжиж	Сартуулын аян дайнаас буцаж ирэв.	Хавар, зундаа шинэ тоо тоолж, намар нь Тангудтай байлдав.

Эх сурвалж: Rachewiltz, I., *Index to The Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972.

Эдгээр нь намар хүртэл нь ямар нэг дайн тулаангүй өнгөрсөн тайван сарууд байна. 153-р зүйлд тэр өвөл өвөлжиж, нохой жил намар нь Татарт морилсон гэсэн мэдээллээс бид өвөл, хавар, зуны улиралд Чингис хаан дайн хийгээгүй, харин татартай хийх дайнд бэлдэж байсныг харж болно. Мөн 265-р зүйлд Тангудтай хийх дайнд намар мордсон бөгөөд Сартуулын дайнаас ирсэн өмнөх өвлийн улирлыг “өвөл өвөлжиж” хэмээн дурьдсан боловч газрын нэрийг дурьдаагүй. Ямар нэг газрын нэр бичилгүйгээр өвлийн улирлыг өнгөрүүлсэн болохыг заасан эдгээр мэдээ нь МНТ-ны зохиогч газрын нэр дурьдах шаардлагагүй *өвөлжөөг*, өөрөөр хэлбэл Чингис хааны өөрийн үндсэн *өвөлжөөг* бичсэн байна. Чингис хааны *өвөлжөө* чухам хаана байсан нь тодорхойгүй ч, МНТ-ны зохиогчийн хувьд Чингис хаан өөрийн гэсэн үндсэн нэг буюу хэд хэдэн өвөлжөөтэй, ямар нэг аян дайны үе биш, тайван цаг бол ямагт тэндээ өвөлжиж, дараах дулааны улиралд нь цэрэг тоолж байна.

МНТ-ны шууд бусаар илтгэн харуулж буй *өвөлжөөнүүд* нь өнөөгийн утгатай ижил бөгөөд хүйтний улирлын нутаг, түүнийг ойлгох ойлголт хамгийн багадаа найман зуун жилийн хугацаанд өөрчлөгдөөгүй. Өөрөөр хэлбэл, 13-р зууны Монголын уламжлалт эдийн засаг дахь хүйтний улирлыг суурин өнгөрүүлдэг арга өнөөгийнхтэй ижил байсан гэсэн үг. МНТ дахь мэдээнүүдээс үзэхэд Чингис хаан өөрийн гэсэн хөдөлгөөнгүй *өвөлжөөтэй* байсан нь шууд бусаар мэдэгдэж байх бөгөөд дундад зууны үед хаад, ноёд, баячууд өөрийн хувийн өмчийн *өвөлжөөтэй* байсан нь эргэлзэх зүйлгүй юм.

Өвөлжөөг өрх эзэмшихдээ *хотоор* дамжуулан эзэмшинэ. Өвөлжөөг халдварт өвчин голомтлон гарсан онцгой тохиолдлоос бусад үед солихгүй, үе дамжин өвлүүлдэг. Доржийнхны өвөлжөө, Пунцагийнхны өвөлжөө хэмээн *өвөлжөө* нь хотын ахлагчийн буюу эсхүл өрхийн тэргүүний нэр дээр бүртгэгдэж байв. 1859 онд холбогдох нэгэн бичигт нэр бүхий ардууд нэг өвөлжөөнд хэдэн жил нутаглаж буйгаа тодорхойлон бичжээ. Үүнийг хүснэгтлэн жагсаавал:

Нэр	Өвөлжөөний нэр	Өвөлжсөн жил	Өвөг дээдэс нь нутаглаж байсан эсэх
Самдан	Авдрантайгаас Өвөр ташир бэлчир	70 илүү жил	Өвөг дээдэс нь өвөлждөг байсан, хугацаа тодорхойгүй
Гэлэн Наваан-Одсэр		Эцэг өвгийн цагаас гурван үе 70 илүү он	Өвөг дээдэс нь өвөлждөг байсан, хугацаа тодорхойгүй
Янжив		60 илүү жил	Өвөг дээдэс нь өвөлждөг байсан, хугацаа тодорхойгүй
Шагдар	Авдарын зүүн тал Дуут	56 илүү жил	Өвөг дээдэс нь өвөлждөг байсан, хугацаа тодорхойгүй
Чавганц Дарьхүү	Авдарын Хананы бууц	Хоёр үед 70 илүү жил	
Тумба	Авдарын баруун өвөр	Гурван үед 50 шахам жил	
Бүргэд	Авдарын Өвөр цагаан өөл	80 илүү жил	
Чэсүрэн	Авдарын зүүн тал Улаан гүү хэмээх газар	40 илүү жил	
Цэрэндорж	Авдарын өвөр Алаг үзүүр	Гурван үед 40 жил	
Ишжамц	Авдарын баруун тал Улаан чулууны ам	87 жил	
Наваанцэрэн	Авдарын Чулуун хороот, Далд хэмээх хоёр бууц	65 жил	
Очир	Авдарын өвөг Цовуугийн гараа	Гурван үеийн турш	

Эх сурвалж: Хувьсгалаас өмнөх Монгол дахь газрын харилцаа, Улаанбаатар: УХГ, 1975. 109-р тал.

Дээрх бүртгэлээс үзэхэд, Самдангийнх Өвөр ташир бэлчир өвөлжөөндөө 70 илүү жил өвөлжсөн ба өвөг дээдэс нь мөн тэнд өвөлжиж ирсэн боловч чухам дээдэс нь анх хэзээ өвөлжих болсон, үе удмаараа чухам хичнээн үе, хичнээн жил тэнд өвөлжиж буйг мэдэхгүй гэжээ. Өрхүүд өвөлжөөнд нутагласан хугацаагаа өөрсдийн мэдэж буй хэмжээнд 50-87 жил гэж мэдээлсэн ба чухам хэзээнээс эхлэн өвөлжиж эхэлснээ мэдэхгүй буюу олон үеэрээ удам дамжин өвөлжиж ирсэн дөрвөн өрх байна. Мөн *хувийн өвөлжөө, язгуурын өвөлжөө* гэж байхаас гадна язгууртан, баячууд дулаан цагийн өвөлжөө, хүйтэн цагийн өвөлжөөтэй байжээ.⁷¹ Иймээс уламжлалт мал аж ахуйд *өвөлжөө* нь хувийн эзэмшил байж, үе дамжин өвлөгддөг, язгууртан буюу баячууд өнтэй өвөл өвөлждөг, зудтай жил өвөлждөг хэд, хэдэн өвөлжөөтэй байжээ. Энэ шинж чанар ялангуяа Хангай, Хэнтийн мал аж ахуй төвлөрсөн бүс нутагт илүүтэй тод илэрдэг.

Өвөлжөөний эзэмшлийн бүртгэл

Нутаг эзэмшлийн бүртгэл *өвөлжөөг* л онцгойлон бүртгэх тул нутаг эзэмших эрх нь өвөлжөөнд суурилан үүснэ. Өвөлжөөний төлөөх тэмцлийн хамгийн хурц хэлбэрүүд ихэвчлэн захиргааны нэгж хооронд өрнөж байв. Энэ нь *өвөлжөөг* тов тодорхой харьяалалтай, хэн нэгний нэр дээр бүртгэгдсэн байхыг шаардана. Ямар нэгэн засаг захиргааны нэгжийн харьяалалгүй, хэрмэл тэнүүлч өрх буюу хот нь өвөлжөөгөө бие даан хамгаалж чадахгүй бөгөөд ер нь өвөлжөөг эзэмших, үе залгамжлуулах байтугай ганц өвөл нутаглах ч эрхгүй байна. Учир нь *өвөлжөө* бүхэн ямар нэгэн засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт, мөн нэг мал аж ахуйн хотын эзэмшилд харьяалагддаг.

Өөрийн нутаг дэвсгэр дээрх *өвөлжөөнд* гадны өрх, хотуудыг буулгахгүй, бэлчээрийг идүүлэхгүй сахин хамгаалах нь засаг захиргааны нэгжийн удирдлагын нэг үндсэн чиг үүрэг байв. Сайн ноён аймгийн гүн Дэлэгдоржийн хошууныхан говь нутагт өвөлжөөтэй бөгөөд зуслан гарахдаа арваад өрхийг “тайгам” буюу өвөлжөөний *сахиураар* суулгаж байжээ. Хэрэв бусад хошууны хотууд өвөлжөөнд ирж буувал тэднийг хөөх, тэднээс бариа барих буюу малыг нь барьцаанд хураах чиг үүрэгтэй аж.⁷²

Өвөлжөөг олон өрхийн хамтын эзэмшил дээр бүртгэж байсан түүх байхгүй ба ихэвчлэн мал аж ахуйн хотын *ахлагч* дээр бүртгэдэг. *Ахлагчийн* нэр дээр буй өвөлжөөнд тухайн *ахлагчийн* толгойлсон *мал аж ахуйн хот* өвөлжинө. Нэг *өвөлжөөнд* мал аж ахуйн хоёр хот өвөлжихгүй бөгөөд хэрэв хоёр хот нэг өвөлжөөнд буусан тохиолдолд нэгдэн нэг ахлагчтай мал аж ахуйн нэг хот болон хувирдаг. Мөн үүний эсрэгээр мал аж ахуйн нэг хот хоёр тусдаа өвөлжөөнд өвөлждөггүй, хэрэв хоёр өвөлжөөнд өвөлжвөл тус тусын ахлагч бүхий мал аж ахуйн хоёр хот болон задарч, нутгийн захиргаанд бүртгэгдэнэ. Нутаг эзэмшлийн

⁷¹ *Хувьсгалаас өмнөх Монгол дахь газрын харилцаа*, эмхэтгэсэн Цэ. Шархүү, Улаанбаатар: УХГ, 1975. 197-198-р тал.

⁷² *Хувьсгалын өмнөх Монгол дахь газрын харилцаа*, эмхэтгэсэн Цэ. Шархүү, Улаанбаатар: УХГ, 1975. 21-р тал.

бүртгэл өрх дээр бус, мал аж ахуйн хот дээр, түүний ахлагчийн нэр дээр хэрэгждэг тул мал аж ахуйн хот нь газрын харилцааны үндсэн оролцогч байж иржээ. Өөрөөр хэлбэл нэг хонины хотонд нэг л өвөлжөө эзэмшүүлдэг байв. Ийм учир хувь хүний болон өрхийн засаг захиргааны нэгжийн харьяаллыг мал аж ахуйн хотын эзэмшдэг өвөлжөөгөөр нь тогтоодог. Хэнтий аймгийн Биндэр сумын багууд “Адуучин” тэмцээн зохион байгуулахдаа баг тус бүр зөвхөн тухайн багийн харьяа адуучдыг хамруулдаг бөгөөд багийн тэмцээнд оролцох малчдын багийн харьяаллыг тухайн малчны өвөлжөө аль багийн нутаг дэвсгэрт харьяалагддагаар нь тодорхойлж байна.⁷³

Нутаг нь уур амьсгал, бэлчээр, хот гурвыг цогцолбороор агуулсан дулааны ба хүйтний улирлын *нутгуудаас* бүрдэх ба *нутаг* дээр үүсэх газрын харилцаа бүхэлдээ хүйтний улирлын нутаг – *өвөлжөөнд* захирагдан оршино. *Өвөлжөө* бол малчин өрх нэг газартаа үе дамжин нутаглаж буй суурин цэг юм. Өөрөөр хэлбэл, *өвөлжөө* бол Монголын уламжлалт эдийн засагт 40-60 мянга орчим байдаг, хөдөлгөөнгүй, хувийн эзэмшилд оршдог суурин байршил юм. Энэ суурин байршил нь нэг *хотонд* байх сүргийн тоо толгойг 1200 орчим хонин толгой дотор байх зүй тогтлыг үүсгэж байдаг.

Өвөлжөө эзэмших, бусдын эзэмшлийн өвөлжөөнд өвөлжих, өвөлжөөгөө бусдаас хамгаалах нь Монголын газрын харилцааны үндсэн хэлбэрүүд бөгөөд Монголын уламжлалт эдийн засагт өвөлжөөний энэ төрлийн газрын харилцаанд үндэслэсэн эдийн засгийн байгуулал тогтжээ. Малчин өрх нь *өвөлжөөг* мал аж ахуйн хотын *ахлагчийн* нэр дээр нутгийн захиргаанд аман хэлбэрээр бүртгүүлэн эзэмшиж, төр, нутгийн захиргаа болон мал аж ахуйн хотууд хоорондоо өвөлжөөнөөс шалтгаалсан газрын харилцаанд орж байв.

НУТАГ ЭЗЭМШЛИЙН ХАРИЛЦАА

Монголын түүхэнд газар нь төрийн өмч байж ирснийг ихэнх судлаач хүлээн зөвшөөрдөг. Хүннү улс хүн нутагладаггүй ээлүүд газрыг Дунхуд өгөх эсэх талаар маргаан өрнөхөд эцсийн шийдвэрийг Модунь шаньюй гаргаж байв. Их Монгол Улсын үед Чингис хаан улсын газрыг мянганд хуваарилж, мөн түүнчлэн онцгой хүчин зүтгэгсдэд *нутаг* дархлан олгож байгаа нь газрын эцсийн өмчлөгч хаан байсныг харуулна.

Газрыг төрийн нэрийн өмнөөс эзэмшиж буй мянган, хошуу зэрэг нутгийн захиргаад нь газрыг өмчлөхгүй, төрийн нэрийн өмнөөс эзэмшинэ. Газар нь улсын бүх нутаг дэвсгэрийг хамрах бол *нутаг* нь зөвхөн мал аж ахуйн эдэлбэрийг хамрах ба үүнээс шалтгаалан Монголын уламжлалт эдийн засгийн байгуулалд газрын харилцаан дотор *нутаг эзэмшлийн харилцаа* хэмээх онцлог харилцаа бүрэлдэн тогтжээ.

Нутаг гэж мал аж ахуйн эдэлбэрийг, өөрөөр хэлбэл мал аж ахуйд хэрэгтэй, ашиг тустай уур амьсгал, бэлчээр, ус, газрын байц зэрэг газарзүйн цогц шинж

⁷³ Зохиогчдын ажиглалт, ярилцлага. Хэнтий, Биндэр. 2025.6.11.

чанарыг хэлнэ. Нутгийн захиргааны харьяанд байх мал аж ахуйн хотууд газрыг биш, харин мал аж ахуйн эдэлбэр газар болох *нутгийг* эзэмшиж, нутаг эзэмшлийн харилцаа үүсгэдэг. Нутгийг мал аж ахуйн үйлдвэрлэлийн нэгжид эзэмшүүлэхдээ газрын хэвлийн болон дээрх баялаг нь нутаг эзэмшилд хамаарахгүй, газрыг зөвхөн мал аж ахуйн үйлдвэрлэлд ашиглуулах зорилгоор *нутаг* болгож олгоно. Нутаг дотроос өвлийг давах зориулалттай цогц шинж бүрдсэн байршлыг *өвөлжөө* хэмээж, улмаар түүнд тулгуурлан *сүргийн байгуулал*, *мал аж ахуйн хот* хөгждөг. Мал аж ахуйн хот, сүргийн байгуулал, хөдөлмөр зохион байгуулалт гурав нь газрын *нутаг* хэмээх хэсгээр, нутгийн дотор орших *өвөлжөө* хэмээх хүйтний улирлын байршлаар төрийн өмчийн газартай уягдаж, тогтвортой эдийн засгийн байгуулал үүсгэж байв. Өвөлжөөний доор буй *газар* нь төрийн өмч бол харин өвөлжөөний *нутаг* нь төрөөс нутгийн захиргаагаар дамжуулан мал аж ахуйн хотод олгосон үнэгүй, хугацаагүй *нутаг эзэмших эрх* юм. Нэг мал аж ахуйн хотын эзэмших өвөлжөөний доорх суурь газар, газрын хэвлий, өвөлжөөний ойр орчимд байх гол ус, ойн сан хааны буюу өмч байж, хааныг төлөөлөн нутгийн захиргаа тэдгээр газрыг эзэмших бол харин өвөлжөө оршин буй *нутаг*, түүнийг бүрдүүлдэг *өвөлжөө* болон ойр орчмын *бэлчээр* нь тухайн нэг *хотын* эзэмшилд байжээ.

Өөрийн гэсэн өвөлжөөгөө үнэгүй, хугацаагүй эзэмшиж, эзэмших эрхээ нутгийн захиргаагаар баталгаажуулсан *мал аж ахуйн хотууд* Монголын уламжлалт эдийн засгийн байгууллыг бүрэлдүүлж байжээ. Ийнхүү Монголын уламжлалт эдийн засагт газрын харилцаа *нутаг эзэмшил* хэлбэрээр хэрэгжиж, тэрхүү нутгийг мал аж ахуйн хот эзэмшиж, нутаг эзэмших харилцаанд мал аж ахуйн хот оролцдог байв. Тухайлбал, МНТ-д гарч буй “нутаг дархлах” гэдэг үйл явдал нь газрыг феодалын өмч болгон соёрхож буй явдал биш, харин мал аж ахуйд зориулагдсан эдэлбэрийг хувь хүнд үнэгүй, хугацаагүй олгож буй явдал юм. Нутаг эзэмшлийн харилцааны үндсэн шинж нь *нутгийг* мал аж ахуй эрхэлдэг субъектэд мал аж ахуй эрхлэх зориулалтаар эзэмшүүлэх явдал байжээ.

Энэхүү *нутаг эзэмшлийн* онцлог харилцаа социализмын үеийн *сум-нэгдлийн тогтолцоонд* ч үйлчилсээр байв. 1960 оны Үндсэн хуульд хөдөө аж ахуйн нэгдлүүдэд үнэгүй, хугацаагүй эзэмшүүлэхээр заасан “бэлчээр” хэмээх ойлголт нь уламжлалт нийгэм дэх “нутаг” гэдэг ойлголттой давхцаж байв. Сум-нэгдлийн үед Үндсэн хуулиар *бэлчээрийг* хөдөө аж ахуйн нэгдлүүдэд үнэгүй, хугацаагүй эзэмшүүлсэн явдал бол газар төрийн өмчид хэвээр байж, нутгийн захиргаа газрыг төрийн нэрийн өмнөөс эзэмшиж, харин “бэлчээр” хэмээх *нутгийг* мал аж ахуй эрхлэгч субъектэд эзэмшүүлсэн явдал бөгөөд өмнөх үеэс онцлог ялгаа нь нутаг эзэмших эрх бүхий мал аж ахуй эрхлэгч субъект нь уламжлалт мал аж ахуйн хот бус, харин социалист *хөдөө аж ахуйн нэгдэл* байв. Гагцхүү 1992 оны Үндсэн хуулиар Монголын уламжлалт нутаг эзэмшлийн харилцаа бүрэн өөрчлөгдөж, “бэлчээр” буюу *нутаг* анх удаа мал аж ахуй эрхлэгч субъектын эзэмшлээс гарч, мал аж ахуй эрхэлдэг болоод эрхэлдэггүй нийгмийн бүх гишүүдийн эзэмшилд очсон билээ.

ДУГНЭЛТ

Монгол малчин өрх нэг жилд 25 орчим хонин толгойтой тэнцэх малыг идшэнд хэрэглэнэ. Үүний тулд нэг өрх хамгийн багадаа 100 орчим хонин толгой малыг өөрийн өмчид байлгах шаардлагатай. Гэвч хөрөнгө чинээний ялгаатай байдал нь малчдын бүлгүүдийг дангаар оршин тогтноход тохиромжгүй болгодог байна.

Малчин өрхүүд өмч ба малын тоогоороо ялгаатай бүлгүүдэд хуваагдах ба ялгаатай бүлгүүдийн ихэнх нь дангаар оршин тогтнох чадваргүй буюу тохиромжгүйн улмаас *мал аж ахуйн хот* гэсэн зохион байгуулалтад ордог. Монголын уламжлалт нийгмийн анхдагч нэгж бол малчин өрх бөгөөд харин эдийн засгийн үүднээс харвал үйлдвэрлэлийн үндсэн нэгж нь *мал аж ахуйн хот* байна. *Мал аж ахуйн хот* нь нэгдүгээрт, малын зайлшгүй зарлагаа хариуцдаг байх, хоёрдугаарт, сүрэг хариулахад зарцуулах өдөр тутмын хөдөлмөрийг хэмнэх, гуравдугаарт, хөрөнгөөр ялгаатай өрхүүд харилцан дутуугаа нөхөх, дөрөвдүгээрт, сүргийн тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах, тавдугаарт, технологи хамтран ашиглах гэсэн эдийн засгийн шийдвэрүүдийг хэрэгжүүлнэ. Мал аж ахуйн хотууд үйлдвэрлэл эрхлэх үндсэн хэлбэр нь *сүрэг* байв. Монголчууд хонь, адуу, үхэр, тэмээ, ямаа гэсэн таван хошуу малыг дөрвөн *сүрэгт* ангилан маллах бөгөөд энэхүү сүргүүдээс хонин сүрэг, хонины хот нь *мал аж ахуйн хотын* үндэс болдог. *Мал аж ахуйн нэг хотонд* байх хамгийн бага сүрэг 400 хонин толгой, хамгийн их сүрэг 1200 хонин толгой бөгөөд энэ нь *мал аж ахуйн хотын өвөлжөөний* даацаар хязгаарлагддаг.

Өнөөгийн Монгол Улсын нутаг дэвсгэрт ойролцоогоор 40-60 мянган *өвөлжөө* оршиж ирсэн бололтой. Мал аж ахуйн нэг хотын *өвөлжөөнд* хоёроос дээш өрх, 540 орчим сүрэг өвөлждөг нь Монголын уламжлалт эдийн засгийн нэгжийн суурь багтаамж юм. Үүнд үндэслэвэл, Монгол улсын нутаг дэвсгэрт түүхийн турш 40-60 мянган өвөлжөөнд 120 мянгаас дээш 180 мянга хүртэл тооны өрх, 846 мянга орчим малчин хүн ам, 21.6-32.4 сая толгой мал өвөлжиж иржээ.

Монголын уламжлалт нийгэмд *газар* төрийн өмчид байв. Гэвч газар бүхэн мал аж ахуйд тохиромжтой биш учир зөвхөн мал аж ахуйн эдэлбэр газрыг илэрхийлэх *нутаг* хэмээх ойлголт үүсжээ. *Нутаг* гэж уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлд эдэлбэр болж ашиглагдаж байгаа газрыг хэлнэ. Тиймээс Монгол газарт оршин буй газар бүхэн *нутаг* болж чаддаггүй ажээ. *Нутаг* нь өөрчлөгддөггүй тогтмол ойлголт байж ирсэн бөгөөд дотроо нэг жилийн дулаан-хүйтний, нэг хоногийн өдөр-шөнийн гэсэн хос циклээр дамжин мал аж ахуйн үйлдвэрлэлд ашиглагддаг. Дулааны улирлын *нутаг* Монгол даяар элбэг байж, тэдгээр дэлгэр нутгуудад *хотууд* нийтээр нутаглах бол хүйтний улиралд нутаглах *өвөлжөө, хаваржсаа* нэн хязгаарлагдмал болдог.

Малчин өрхүүдийг мал нь биш, харин *сүргийн зохион байгуулалт* болон *мал аж ахуйн хот* хэмээх зохион байгуулалт нь *нутагтай* холбож, нутагтай уяж байжээ. Монгол газрын цаг уурын эрс тэс нөхцөлд өвлийн шөнө -40 хэм хүйтэнд

20 м/с хүчтэй шуурга шуурахад амьтны арьсан дээр -70 хэм хүйтэн мэдрэгдэнэ. Монголын нутаг дэвсгэр дээр энэхүү хүйтнийг сааруулдаг хязгаарлагдмал тоотой онцгой байршлууд *өвөлжөөний нутаг* болдог. *Өвөлжөө* бол малчин өрхийн дөрвөн улирлын нүүдлийн нэг түр буудал биш, харин *мал аж ахуйн хотын* эзэмшдэг үндсэн *нутаг*, хаваржаагаа хамтатган удам дамжуулан өвлүүлдэг *нутаг* юм. Мөн түүнчлэн, хүйтний улирлыг давахын тулд *өвөлжөө*, *хаваржааны бэлчээрийг* хамгаалах, малд идүүлэхгүй байх зайлшгүй шаардлагын үүднээс *мал аж ахуйн хотууд* дулааны улиралд *өвөлжөө*, *хаваржаагаа* орхин нийтийн эзэмшлийн *зуслан*, *намаржаа* руугаа нүүн оддог.

Малчин өрх нь мал өмчлөгч, өмчийн харилцааны үндсэн субъект байж ирсэн боловч *нутгийг* малчин өрхөөр биш, харин *мал аж ахуйн хотоор* эзэмшиж байжээ. *Мал аж ахуйн хот нутгийг* мал маллах зориулалтаар, үнэгүй, хугацаагүй эзэмшиж, түүнийг *газар өмчлөгч* төр баталгаажуулж байв. Монголын бүх газар нутгийн дээд өмчлөгч нь төр (хаан) байв. Харин орон нутгийн захиргааны удирдагч нь төрийн нэрийн өмнөөс газрыг эзэмшиж, нутгийн захиргааны удирдагч нэг *өвөлжөөг мал аж ахуйн нэг хотод* эзэмшүүлж, өвөлжөө эзэмшлийн бүртгэл хөтлөх чиг үүрэгтэй байжээ. Ингэснээр Монголын уламжлалт эдийн засагт өвөлжөө эзэмшлийн харилцаа, өөрөөр хэлбэл *нутаг эзэмшлийн харилцаа* тогтож, газар өмчлөгч – төр, газар эзэмшигч – нутгийн захиргааны удирдлага, нутаг эзэмшигч – *мал аж ахуйн хот* гэсэн газрын харилцааны гурван субъект оршиж байжээ. Монголчууд зөвхөн дулааны улиралд л газрыг нийгмээр ашиглаж байсан бөгөөд хүйтний улиралд нийгмийн шинжгүй, харин хувиар, *мал аж ахуйн хотуудаар* эзэмшиж байв.

Ийнхүү малчин өрхүүдөөс бүрдсэн *мал аж ахуйн хот*, хөдөлмөр хэмнэх зохион байгуулалтаас үүссэн *сүргийн байгуулал*, өвлийг амьд мэнд давах шаардлагаар үүссэн *нутаг эзэмшлийн харилцаа* гэсэн гурван зохион байгуулалтаас Монголын уламжлалт эдийн засгийн байгууллын үндэс бүрэлдэж, энэхүү эдийн засгийн өвөрмөц байгуулал нь Монголд мандсан нэгдмэл төрт улсуудын эдийн засгийн үндсийг нөхцөлдүүлж байв. Хүйтний улирлын нутгийг *мал аж ахуйн хот* эзэмшдэг энэ онцлог нь Монголын бүх түүхийн үндэс, дэлхийн нүүдэлчдээс Монголын уламжлалт мал аж ахуйг ялгах гол онцлог ялгаа болж байжээ.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулиар Монгол Улсын иргэний оршин суух газраа чөлөөтэй сонгон суух эрхийг баталгаажуулах нэрийн дор бэлчээр нутгийг Монголын түүхэнд анх удаа бүх нийтийн эзэмшил болгов. Бэлчээр нутгийг мал аж ахуйн зориулалтаар өөрийн харьяа малчдад эзэмшүүлдэг, бүртгэдэг, өөр засаг захиргааны харьяа малчдаас хамгаалдаг нутгийн захиргааны эрх мэдэл устав. Ингэснээр уламжлалт эдийн засагт байгаагүй бэлчээр нутаг эзэмшлийн цоо шинэ харилцаа бий болжээ.

Өөрийн малчны *нутгийг* бүртгэж, өөрийн малчны *нутгийг* гадны малчнаас хамгаалдаг нутгийн захиргааны чиг үүрэг, хэдэн мянганы түүхтэй уламжлалт *нутаг эзэмшлийн харилцаа* сүүлийн гучаадхан жилд өрнөсөн бүх нийтээр бэлчээр эзэмших давалгаанд автагдан түүх болон үлдэж, бэлчээрийн доройтолд нэрвэгдэх үү?

Номзүй

1. Базаргүр, Д. *Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй (Монголын нүүдэлчдийн жишээгээр)*, газарзүйн ухааны докторын диссертаци, Улаанбаатар: МУШУА-ийн Газарзүйн хүрээлэн, 1996
2. Владимирцов, Б.Я. *Общественный строй Монголов, Монгольский кочевой феодализм*, Ленинград, Издательство Академии Наук СССР, 1934
3. Гантөмөр, Х. *Монгол орны байгалийн янз бүрийн бүсэн дэх сум, САА-н бэлчээр ашиглалтын газарзүйн онцлог*, Газарзүйн ухааны дэд эрдэмтний зэрэг горилох бүтээлийн гар бичмэл, Улаанбаатар, 1984.
4. Гонгор Д. *Халх товчоон*. II боть. УБ., 1978.
5. Ижцамц Н. *Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь*. УБ., 1974
6. Майский, И. *Орчин үеийн Монгол (Автономит Монгол XX зууны гараан дээр)*, Улаанбаатар, 2005,
7. *Монголын феодализмын нийтлэг, онцлогийн зарим асуудал*, Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл, 1987.
8. Нацагдорж Ш. *Монголын феодализмын үндсэн замнал*. УБ., 1978.
9. Онуки, М. *Нүүдлийн мал аж ахуйн нийгмийн орчин үе*, Осака: Такацуки-Бүнко, 1990.
10. Самбуу, Ж. *Мал аж ахуй дээрээ яахиж ажиллах тухай ардад өгөх сануулга сургаал*, Улаанбаатар: БНМАУ-ын хэвлэл, 1945.
11. Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980
12. Хамфри, К., Снит. Д. *Нүүдэллэхүйн ёсон эцэслэх үү?: Өвөр Азийн нийгэм, хүрээлэх орчин*. Орчуулсан Ц.Очирбал. УБ., 2006.
13. *Хувьсгалын өмнөх Монгол дахь газрын харилцаа*, эмхэтгэсэн Цэ. Шархүү, Улаанбаатар: УХГ, 1975.
14. *Үндэсний статистикийн хорооны цахим хуудас*, www.1212.mn
15. Симуков, А.Д. *Труды о Монголии и для Монголии*, Том 1, Осака: Государственный музей этнологии, 2007.
16. Симуков, А.Д. *Труды о Монголии и для Монголии*, Том 2, Осака: Государственный музей этнологии, 2007.
17. Толыбеков С.Е. *Общественно-исторический строй Казаков в XVII-XIX веках*. Алма-Ата, 1971.
18. Altantugs, N., & Delgerjargal, P. (2025). Sum-Negdel: Administrative and Cooperative System in the Mongolian People's Republic. *Inner Asia*, 27(2), 190-209. <https://doi.org/10.1163/22105018-12342722>
19. Atwood C.. Banner, Otog, Thousand: Appanage Communities as the Basic Unit of Traditional Mongolian Society. *Mongolian Studies*, Vol. 34 (2012), pp. 1-76
20. Khazanov, A.M. *Nomads and the Outside World*. Second edition. The University of Wisconsin Press, 1984.
21. Kamimura, A. (2013). Pastoral Mobility and Pastureland Possession in Mongolia. In: Yamamura, N., Fujita, N., Maekawa, A. (eds) *The Mongolian Ecosystem Network. Ecological Research Monographs*. Springer, Tokyo. https://doi.org/10.1007/978-4-431-54052-6_14
22. Rachewiltz, I., *Index to The Secret History of the Mongols*, Bloomington: Indiana University, 1972.

Abstract

The traditional Mongolian economic structure was organized around the triad of *khot-süreg-nutag* (settlement-herd-territory): the *khot* (pastoral settlement) formed by livestock-owning households, the *süreg* (herd) composed of livestock, and the *nutag* (pastureland territory) arising from land use. These pastoral settlements and herds were anchored to the land via the *övöljöö* (winter settlement), which served as a permanent fixed point. Consequently, the traditional Mongolian economic system was comprised of pastoral settlements that held specific winter settlements, which themselves consisted of diverse households—including noble, wealthy, middle-class, and poor herders. At the foundation of this economic structure stood the *Khagan*, the supreme lord and owner of all land—including Mongolia’s territory, waters, mountains, subsoil, forests, and deserts—and the administrative units that managed the land on his behalf through his sovereign decree. Distinct from other forms of Eurasian nomadic pastoralism, the essence of the traditional Mongolian economy was rooted in state-owned land relations, where cold-season pastureland was granted to production units for free and indefinite use.